ФРЕДЕРИК

ПАР

ЧАМАЙГ ҮЗЭН ЯДНА

ФРЕДЕРИК ДАР

ЧАМАЙГ ҮЗЭН ЯДНА

(роман)

www.kiebooks.com

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Би тэнгисийн хөвөөнд, бүр усны захад зогсоод гэрэл чийдэн тольдсон бараан мандлыг нь ширтэж байхад тэнгисийн долгион сэтгэлд нэгийг шивэгнэн уруу татав уу гэлтэй, энэ цээл их усанд үсрэн орох хүсэл төрөв. Энэ хүсэлд минь бүр хүзүүндээ ширмэн туухай уяж байгаад үсрэх юмсан гэсэн жигтэй сонин бодол чимэг нэмж байх шиг.

Гагцхүү өөр нэгэн учир байдал бий. Юу вэ гэвэл би бага байхдаа. үөийн найз нартаа сайрхан гайхуулах гэж нэгэн том гүнзгий усан санд шумбаж ороод золтой л живж үхээгүй юм. Усанд живж байхад хамаг бие сэтгэлийг минь эзэмдсэн аймшигт сэрлийг одоо санаад бие зарсхийв,.. Тэр үед төрсөн бодол хуучин киноны кадрууд аятай толгойд минь жирвэс жирвэс хийлээ... Усанд хахаж цацаж байхад үхлийн нялуувтар амт амггагдах шиг болж, эцсийн бүлэгт ингээд үхэж дуусдаг байжээ гэж бодсонсон... Энэ нэгэн дурьдатгал сэтгэлд их эвгүй бай сан учир би эргэлзэв...

Түрүүнээс хойш хориод минут хэмлэж байсан тамхиныхаа ёзоорыг ус руу нулимлаа... Үгүй, өнөөдөртөө больё, Миний зүрх хүрэхгүй байна. Тэгээд би намайг даллан буй уснаас холдлоо. Тэнгэрээр сийрэг үүлс нүүгэлтеэн намуухан дөлгөөн шөнө байлаа. Би боомтыг орхин гарч тэнгисийн хөвөө дагасан цагаан зам дээр очлоо. Замын нэг талаар лаавар мод ургаж. нөгөө талаас хаялгана эхэлжээ.

Би гараа халаасандаа хийгээд аргалшгүй хүнд байдалд орсондоо шаналан итгэл муутай сажилж явтал гэнэт машины хос гэрэл замыг гийгүүллээ. Энэ нарийхан замаар машиныг хажуугаараа өнгөрүүлах гэж лаавар модны зүг зайлав. Тэр машин гашуудлын цуваа дагаж яваа юм шит их удаан явах аж. Жолооч нь төөрчихөөд надаас зам асуух гэж байгаа юм болов уу гэж нэг бодов. Би эндхийн газрыг мэдэх биш дээ.

Машин миний дэргэд зогсож, хаалга нь онгойход сайн сүрчигийн тансаг үнэр сэнхийв. Жолооны ард эмэгтэй хүн суужээ.

- Та хаа хүрэх вэ? гэж жаахан хүйтэн хөндий ч гэсэн тайван дуугаар асуухад нь би гайхан балмагдлаа.Энэ хүүхэнд миний нүүр харагдаж байгаа гэж бодоод тэнэг юм шиг харагдахгүйн тулд инээмсэглэх аядаж:

- Зүгээр зугаалж явна. Сартай сайхан шөнө байна гэв.

- Надтай хамт машинаар зугаалахгүй юу? гэж ширүүхэн дуугарахад нь сэжиг төрөх шиг боллоо. Би хэзээ ч ингэтлээ сандарч байгаагүй гэж батлан хэлж болох байна.

- Тантай юу? гэж би бөвтнөлөө.

Хүүхний царай зэвхий цагаан агаад сэтгэл нь тоггож ядан байна уу гэлтэй, жолоогоо хуруугаар тогшиж байв.

- Тийм, надтай!

Тэрхэн мөчид миний цээжинд төрсөн сэтгэлийг айдас гэж арай боломгүй... Юутай ч гэсэн би машинд нь орж суугаад үүдийг хаалаа.

Машин нь ордон шиг тохилог том америк машин юм. Хүүхнийг харах гэтэл толгойгоо торгон алчуураар битүү ороожээ. Гэсэн ч голшиг сайхан бие цогцостойг нь ажиглаж амжив. Хүүхэн ханцуйгүй цагаан платье өмссөн байлаа.

Машин байрнаасаа аяархан хөдлөв. Энэ үл таних эмэгтэйгээс бид хаашаа явах гэж байгааг асуух гэснээ эвгүй юм уу даа гэж бодоод дуугүй өнгөрч, цаашид юу болохыг хүлээхээр шийдэв. Машин усан дээгүүр хөвж буй завь аятай замаар зугуухан явж байлаа. Бид хэдэн минут нэг ч үг сольсонгүй дуугүй явав. Хүүхэн хааш явж байгаагаа сайн мэдэж буй бололтой. Замын эцэст хүрээд явдлаа удаашруулан хажуу тийш эргэж, харанхуйн дунд живсэн бүр нарийхан зам руу оров. Энэ нь одоо хүнгүй байгаа бо лолтой хувийн байшингийн хашаанд тулж очсон мухар байна. Үл таних хүүхэн машинаа хамгийн харанхуй газар зогсоож, дараа нь над руу эргэж харав. Би нүүрний нь байдлыг сайн харахын тулд юугаа ч хайрлахгүй өгөхсөн. Даанч бидний эргэн тойрон пад харанхуй байсан болохоор хүүхний царайг ялгаж харах арга бай сангүй. Үүнээс ялимгүй жаахан илүү харанхуй болбол бид нүхэн хонгнлд байж байна гэж бодсон ч болмоор.

Машинд бараг үхээрийн газар шиг нам гүм. Гагцхүү хаанаас гарч байгаа нь үл мэдэгдэх сонсдомтөдий чимээ гарна. Энэ нь хүүхэн платьемыхаа урд талын бүх товчийг тайлан энгэрийг нь ярж байгаа чимээ болохыг би сая ойлгов. Тийнхүү платьеныхаа энгэрийг ярах нь ямар нэг жимсийг дундуур нь хуваж байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлэв... Платьены нь дотуур өөр хувцас юу ч алга.

Энэ хүүхний надаас юу хүсэн хүлээж байгааг би сая нэг юм ухаарч, айх, гайхах сэтгэл замхран арилаад түүний цээжин дээр гараа тавьж, уруулыг нь уруулаараа тэмтрэн олов. Тэгтэл бидний хооронд зэрлэг араатны ноцолдоон шиг юм боллоо. Хүүхэн хамгаалахыг оролдон тийчигнэж эхэлсэн боловч миний сэтгэл хөөрөөд энэ банзал хүүхнийг машины нь суудал дээр дарж авахад арван таван шийдэмгий залуу эр ч саад хийж чадахааргүй тийм байдалтай болсон байв.

Дараа нь хэсэг зуур тэнхээ алдран бид амьсгааган дарахыг оролдож байлаа. Хүүхэн эхлэн сэхээ орж дээш өндийн хөлөрч норсон бие дээр платьегаа бушуухан товчлоод төдөлгүй машин байрнаасаа ухасхийн хөд лөв. Машин зам дээр гарч ирсний дараа намайг буу гэж тушаахад нь би чихэндээ итгэсэнгүй.

- Юу гэнээ? гэж лавласанд

- Муухай амьтан чи буу! Бушуул! гэлээ.

- Тоглоомгүй хэлэхэд та надад ийм зан гаргах хэрэггүй юм биш үү?

Би цаг тухайн байдалд зохицуулан биедээ эзэн бол чаддаг тэнхээ сайтай. эр гэдгээ энэ хүүхэнд саяхан үзүүлээд өгсөн шүү дээ. Тэгтэл нэг юм час-няс хийх сонсдоход цүнхнээсээ нэг юм гаргаж байгааг нь ойлгов. Тэр "нэг юм" нь гар буу байлаа. Гар буу харанхуйд гялс

хийв.

- Буу!

- За буу гэж байгаа юм бол яах вэ.... гэж би бөвтнөөд машины хаалгыг онгойлгов.

Гэвч би машинаас тайван буухын оронд огцомхон эргэж, хүүхний буу барьсан гарын бугуйг хүчтэй цохисонд буу нь суудал дээр унаж, хүүхэн хилэгнэн дуу алдав. Би эрүүг нь өрөөсөн гараар барьж авлаа. Хүүхний нүдэнд хилэнгийн оч гялалзан байна.

- Хүүхэн чамайг ингэж элдэв маяг гаргаад байвал би нэг их баярлахгүй байх шүү, ойлгож байна уу?

Дараа нь миний сэтгэл гэнэт тайвширч, хүүхнийг тавиад машинаас бууж, хаалгыг нь өсгийгөөрөө өшиглөн хаав... Машиныг урагш ухасхийхэд дугаарыг нь тогтоож авах санаа төрлөө. Дугаар нь тогтооход амархан 98 Т16 гэсэн байв.

Би нойтон элсэн дээр суув. Машины гэрэл холдон одлоо. Маргааш нь би эрт сэрэв. Сэрээд урьд шөнө надад тохиолдсон явдал зүүд биш байгаа даа гэж нэг бодлоо. Зүүд гэхэд ухаан санаанд даанч тов тодхон байх юм Зүүдний дараа ийм тод дурьдатгал үлддэггүй билээ. Би амандаа дуу аяланхан шүршүүр дор биеэ угаав. Урьд шөнийн адал явдал амьд явахын амтыг таниулж, сэтгэлийг минь сэргээжээ.

Зочид буудлын эзний яравгар царайг хараад ч сэтгэл нэг их эвдэрсэнгүй. Энэ хүн байрны хөлс нэхэмжилсэн бичиг хамрын минь өмнө сэгсчин гурав хоног нэхэл дагал болж, би мөнгө ирэхгүй саатаж байгааг учирлан гурав хоног түүнд зовлон тоочиж байгаа билээ.

Эцсийн бүлэгт би энэ буудалд суудаг хүмүүсийн дотроос мөрийтэй тоглоомын өргөөнд хамаг байдгаа хамуулсан эхний хүн биш байхаа. Хэрэв жаахан гүн ухаантан байя гэвэл ер нь номин Хөх Эрэгт зочид буудлын эзэн байсны хэрэггүй юм даа.

Би зочид буудлын эзэнд элдэв сайхан юм амалж арайхийн нэг юм салаад цагдаагийн газар руу явлаа.

Тэнгис урьд урьдынхаас илүү цэлмэг сайхан агаад агаарт цэцгийн үнэр анхилан хөлчүүрүүлнэ.

Цагдаагийн газар намайг тоож анхаарах завтай хүн алга. Хоёр байцаагч пиджакаа тайлж тавьчихаад тоостой ширээний ард хөл бөмбөгийн тухай цэц булаалдаж байв. Тэдний анхаарлыг татах санаатай аяархан ханиалгаж үзээд нэмэр болсонгүй. Би бүр хүлээж ядлаа. Тэгж тэгж, насаар арай залуу дөрвөлжин эрүүтэй, бор царайтай чийрэг зузаан эр намайг юу хүссэн ч миний хүсэлтийг хүлээж авахгүй юм шүү гэж урьдаас шийдсэн хүний царайтай дэргэд минь ирж

- Та юу гэж яваа вэ? гэж ширүүхэн асуухад нь би өөдөөс нь элэгсэг найртай инээмсэглэн

- Би даатгалын нийгэмлэгийн төлөөлөгч байна гэв.

- Өө тийм үү! Тэгээд юу гэж?

- Тан дээр ийм нэг хэргээр ирсэн юм. Манай нэг харилцагч... гээд дуугаа намсган хүндэтгэлээ илэрхийлэх байдал үзүүлж: - Улс төрийн нэр нөлөөтэй зүтгэлгэн юм. Миний юу хэлэх гэж байгааг та ойлгож байна уу? гэв.

Тэр хүн юу ч ойлгосонгүй бололтой. Гэсэн ч сонирхож буй янз мэдэгдэв.

- Манай нэг харилцагч машины зогсоол дээр зохих журмаар машинаа тавьсан байж. Тэгтэл машины нь ар талыг гэмтээжээ.

- Гайхалтай юм болжээ! гэж цагдаа егөөдөв.

- Танаас би шууд хариу сонсоно гэж бодоогүй. Манай харилцагчийн машиныг гэмтээсэн этгээдийн машины дугаарыг тогтоож авсан гэрч байгаа юм. Тэр хүн дугаарыг нь зөв тогтоосон гэж би сайн итгэхгүй байна. Би сэмхэн мөрдөн судалж байгаа юм гээд би нүд ирмэж:

- Амьдралд авхаалж самбаа хэрэгтэй байдаг даа. Үүнийг та юу эс андах вэ гэлээ.

Миний оршил үг түүнд таалагдсан бололтой.

- Та тэгээд юу хүсэж яваа юм бэ? гэв.

- 98 T16 машины эзний хаягийг мэдэж авмаар байна. Хэрэв болдог юм бол... гэсэнд цагдаа хэсэг бодолхийлээд

- 6 гэдэг нь Тэнгис орчмын Альп... Түр хүлээгээрэй. Би Ниццагийн захиргаанд утасдаад үзье гэхэд нь

- Ноён байцаагч. та их эелдэг хүн байна гэж би тал өгөв.

Бүх юм ингэж эхэлсэн хэрэг

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Энэ бол гүвээний цэцэг ногоотой бэлд барьсан ямар стиль маягтай нь үл мэдэгдэх тансаг баян, том байшин байлаа. Дээврийг нь нугалаас хятад маягтай, дотор хашаа нь испани маягтай, бүхий л байдал нь ер бишийн болж ирээд нилээд сүр жавхлантай.

Би хонхны нь товчийг дарсанд оршуулгын хонх шиг чимээ сонсдов, Байшингаас зарц авгай гарч ирээд таримал модны хоорондуур наашаа бууж ирэв. Түүний ойртож ирэхэд энд миний айлчилж ирсэн нь авгайд яасан их тээртэй байгаа бол гэж бодов. Ийм орон байрны үүдийг тайлж өгнө гэдэг холын аялал гэсэн үг.

Авгай хашааны хаалганы дэргэд ирж зогсоод намайг нилээд хардаж сэжиглэж байгаа бололтой, могойн нүд мэт жижигхэн нүдээрээ намайг цоо ширтэн

- Танд юу хэрэгтэй вэ? гэв.

Миний ямар хэрэг зоригтой ирснийг энэ авгай хэлээд өгдөгсөн бол надад үнэлж баршгүй их тус болохсон.

- Ноён Лекентэй уулзмаар байна гэсэнд авгайн уруул ам даруй үрчилзэж

- Ноён Лекэн энд байхгүй гэв.

- Тэгвэл хатагтай Лекэнтэй уулзья.

- Энд хоёр охин нь л байдаг гэж авгай итгэл муутайхан хариулав.

Миний зан байдлын юу нь ч юм бэ авгайд аятайхан санагдсан бололтой.

- Яасан сайн юм бэ! Тэдэнд миний тухай дуулгаж тус болно уу.

- Ямар хэргээр вэ?

- Хувийн хэргээр

Би өөр юу хэлэх вэ дээ. Энэ байшинд нэвтрэхэд тийм ч амаргүй бололтой. Зарц авгай эргэлзээд байна.

- Би ороод өөрийгөө танилцуулья гэсэнд авгай нэг ч үг хариу дуугаралгүй үүд онгойлгож өгөв.

Намайг ороход зарц авгай хашааны хаалга хаагаад намайг дахин шинжин харлаа. Миний цэнхэр костюм цагаан цамц, нэгэн өнгийн зангиа бас төлөв төвшин байдал түүнд итгэл төрүүлсэн бололтой. Би авгайг даган таримал моддын хоорондуур, гол хаалганы довжоо өөд өгслөө. Нүд гялбам цагаан шатаар өгсөж, зүйл бүрийн ногоон ургамлаар чимэглэсэн үүдний сэрүүн танхимд оров.

- Таны алдар нэр хэн бэ? гэж зарц авгай дахин асуулаа.

- Виктер Менда...

Авгайн царайд өнгөрсөн хойно эргэлзэх сэтгэл төрөхийг ажиглав. Авгай намайг хүлээж бай гэж дохиод нарны гэрэл гийсэн том өрөөнд орлоо. Шивэгнэлдэх сонсдов... Хэсэг хүлээлгэсний дараа үүдний танхимаар дамжин дотоод хашаанд оруулав. Энэ дотоод хашаа нь гайхалтай сайхан юм... Шигтгэмэл ногоон хавтангаар хүрээлсэн усан сангийн хажууд тахир дутуугийн тэргэнцэр дээр харахад нас хориос хэтрээгүй цайвар шар үстэй, гоо үзэсгэлэн төгс бүсгүй сууж байв. Хөл дээр нь цагаан баавгайн сайхан арьс тавиастай байлаа. Бүсгүйн царай зэвхий цагаан боловч усан сангийн уснаас илүү ногоон өнгөтэй сэргэлэн нүд нь амь оруулах аж. Бараг цагаан гэмээр цайвар шар үс нь толгойгоо хүрээлэн туяа татуулж байх шиг санагдана. Бүсгүй нимбэгийн модны мөчрөөс барьжээ. Цэцэрлэгт зүйл бүрийн жигүүртэн шувуу жиргэн донгодож, нэгэн зүйл гайхамшигт яруу ая өргөнө.

- Орох ажаам уу! гэж зарц авгайн ширүүн хэлэхэд би давхийн цочив.

Гоо үзэсгэлэнт бүсгүйг ширтсээр байгаад хамгийг мартаж орхижээ. Зарц авгайг даган хурц тод өнгийн зөөлөн сандалууд тавьсан асар том өрөөнд оров. Дотоод хашаа руу харсан нэг ханыг нэлэнхийд нь шиллэсэн байлаа.

Ногоон ширээний ард залуу эмэгтэй суугаад юм бичиж байгаа харагдав. Нас гуч хүрч яваа болов уу гэмээр байх боловч ямар нэг оо энгэсэг тавиагүй нүүрийн төв ихэмсэг, ширүүн төрх нь арай ахимаг харагдуулна. Хөх ягаан өнгийн платье өмсчээ. Нас бие гүйцсэн эмэгтэйчүүд эмгэнэлийн үе дуусаны дараа ийм платье өмсдөгсөн. Энэ хүүхэн ч урьд шөнө намайг машиндаа суулгасан хүүхэн байх ёсгүй дээ. Миний өөдөөс цоо ширтэх мэт харахад нь би сандрав.

- Мадемуазель аа...

Хүүхнийг надаас нэг юм асуух болов уу гэсэн чинь дуугарсангүй, ядахдаа хөдөлсөн ч үгүй, ер сайн юм болохгүйг зөгнөх мэт дургүйцсэн байдалтай ажин шинжив.

- Миний ирснийг та гайхаж байгаа болов уу даа? гэж асуусанд хариуд нэг ч үг хэлсэнгүй.

Мөн тэвчээр ээ! Ай Тэнгэрийн минь өршөөл, энэ хүн хэн хэлгүй юм болов уу?

- Би нэг юм.. лавлах гэж ирсэн. Танайд 98 Т16 дугаартай машин бий юу? гэсэнд хүүхэн сая нэг юм нээж

- Та өөрөө хэн юм бэ, эрхэм ээ? гэж жаахан уцаарлангуй дөлгөөн дуугаар асуув.

- Уучлаарай... Намайг Виктор Менда гэдэг.

Энэ хүүхэн миний нэрийг яаж мэдэх вэ дээ. Хэрэв миний тухай ямар нэг юм сонссон бол тун гайхалт сонин байхсан.

- Ноён Менда та ямар үндсэн дээр миний машиныг сонирхох болов?

Хүүхэн өөрөө мэдэлгүй миний асуусныг нотолсон хариу өгөв. Би дотоод хашаанд хөдлөхгүй сууж буй бүсгүйг харлаа. Энэ бүсгүй яасан ч урьд шөнө намайг урхидсан хүүхэн байж таарахгүй. Миний харц ярилцаж буй хүүхэн дээр дахин туслаа

- Урьд шөнө би... таны машинд дайруулсан, хатагтай...

- Мадемуазель шүү!

Хүүхний нилээд зэвүүцсэнийг ажиглав. Дургүйцсэн байдалтай ярвайж үрчилзэхийг нь хараад намайг ямар нэг янзаар өөрөөс нь хэдэн мөнгө салгахаар ирсэн хүн байна гэж бодож байгааг нь ойлголоо.

- Урьд шөнө үү? Нээрээ юу?

- Нээрээ.

- Энэ чинь тун гайхалтай хачин хэрэг байна. Миний машин гурав хоног гараашаас гараагүй байгаа гэхэд нь надад гэнэт эргэлзэх сэтгэл төрж

- Таны машин америк машин биз дээ, тийм үү гэж лавлав.

Эцсийн бүлэгт би машины дугаарын аль нэг тоо буруу харсан байж болох юм. Бөөн шавар наалдсаны улмаас ялангуяа шөнийн харанхуйд наймын тоо нь зургаа шиг харагдсан байж болох билээ.

- Тийм, америк машин гэж хүүхэн хариулснаа миний эргэлзээг тасаллаа.

- Тэгвэл би эндүүрээгүй юм байна. Таны машин мөн л дөө. Хаялгана руу гардаг зам дээр намайг дайрсан... Харж байгаа биз дээ, золоор би бэртэж гэмтээгүй...

- Сайхан хэрэг ээ! Тэгвэл та костюм чинь , авахын танаггүй муухай болсон гэж хэлэх юм байгаа биз дээ? хэмээн хүүхэн егөөтэй асуув.

Нэгэн агшны төдийд би энэ хүүхний огцом дууг таних шиг санагдлаа. Үгүй дээ, тийм байх ёсгүй. Миний өмнө яавч урьд шөнийнх шиг тийм хачин авир араншин гаргамааргүй төлөв төвшин хүүхэн сууж байна.

- Үгүй, мадемуазель аа... миний костюм бас гэмтээгүй... Би зүгээр л тэр машиныг жолоодож явсан эмэгтэйг харах гэсэн юм... Таныг байсан гэж бодохгүй байна....Төвөг удсаныг минь уучилна уу.

Би мэхийн ёслоод явахаар завдан эргэв. Намайг шатны эхний гишгүүр дээр хөл тавьж байх үед араас минь

- Ноён Менда! гэж дуудахад нь би зогсож, эргэм харав.

Хүүхэн үүдний танхимын гол дунд элгээ эвхээд хөдлөхгүй зогсож байлаа.

- Юу гээ вэ, мадемуазель аа?

- Та түр саатвал болох уу?

Би татгалзсангүй. Хүүхэн намайг мөнөөх өрөөндөө дагуулан аваачиж, зөөлөн сандал зааж

- Суугтүн! гээд зөөлөн сандалд миний өөдөөс харж суухдаа өвдгөө харагдахгүй байхуйцаар хөлөө ачив.

~ Би таны ярьсан намтраас юу ч ойлгосонгүй. Би энд тахир дутуу дүү бүсгүй... таны харсан зарц авгайтай гурвуул суудаг. Энэ хоёрын хэн нь ч машин барьж чадахгүй, та ойлгож байгаа биз... Миний тухайд гэвэл урьд шөнө жолооны ард суугаагүй гэдгээ танд батлан хэлж чадах байна. Ер нь би шөнө орой гадагшаа явдаггүй.

Хүүхний сэтгэл ихэд догдолсон нь илт байлаа. Би түүнийг өрөвдөн толгой сэгсрэв.

- Танаас машиныг чинь хүн гуйж авсан юм биш биз?

- Тэгсэн бол би мэдэх ёстой.

- Заавал биш. Танай гарааш зам руу гарцтайг би ажигласан. Түүний дээр таны машин мотор чимээгүй шахам юм билээ... гэсэнд хүүхэн дал мөрөө хавчив.

- Гэхдээ...

- Юу гэж?

- Гараашийн түлхүүр үү?

- Гарааш чинь төмөр сараалжтай юм байна. Заримдаа жижиг чулуу тээглээд дутуу хаагдаж, цоож нь түгжигдэхгүй үлдэж болох юм. Та лав шалгадаггүй байх

- Нээрээ тийм.,

- Та машиныхаа асаах түлхүүрийг хянах самбарт зүүлттэй орхидог уу?

- Тийм...

- Тэгвэл эрэх хэрэггүй юм байна... Танай айл хөршийнхний хэн нэг нь шөнийн цагт таны машинаар давхиж, сарны гэрэлд цэнгэдэг байж.

- Тийм байх ёсгүй. .

Надад бол ийм байдлыг гайхах зүйлгүй мэт санагдана. Надтай дайралдсан шөниийн эрвээхэйн зан байдал ухаан санаандаа элдвийг ургуулан бодох арвин боломж олгож байлаа.

- Би цагдаа нарт хэлбэл таарах уу, та юу гэж бодож байна?

Таны машин одоо гараашдаа лав байгаа юм уу?

- Саяхан байж байсан... Би нэг юм авах хэрэг гараад гараашид орж үзсэн юм.

Би босов. Үүдний танхимд шал шажигнах сонсдож чимээ гарсан зүг эргэж харвал дотоод хашаанд байсан бүсгүй тахир дутуугийн тэргэнцэрээрээ бидэн рүү ирж яваа харагдлаа. Ойроос улам илүү гоо үзэсгэлэнттэй харагдах юм.

Намайг эгцлэн ширтэхэд нь миний нүүр халуу оргив.Энэ бүсгүй скандинав домгийн амилсан дүртэй адил юм шиг цайвар шар үс, зэвхий цагаан царайд нь үлгэр домгийн бүсгүйн шинж байх шиг.

Эгч нь бид хоёрыг танилцуулж

Энэ ноён Менда... Энэ миний дүү Ева гэв.

Бүсгүй миний ямар хэрэг зоригоор ирснийг хэлэх болов уу гэж хүлээж байгаа бололтой. Эгч нь байдлыг тайлбарлав. Энэ жигтэй хачин намтрыг хөөрхий тахир дутуу гоо бүсгүй онц их сонирхохгүй байх шиг. Сурамгай хурдан хөдөлгөөнөөр тэргэнцэрээ надад ойртуулж

- Менда, гэв үү? Та Виктор Менда юу? гэж асуув

Эгч нь надаас дутуугүй гайхах шиг санагдлаа.

- Ева чи энэ ноёнтныг таних юм уу?

- Нэрийг нь мэднэ... Та ноднин жил радиогоор нэвтрүүлэг хөтөлж байсан уу?

- Нээрээ тийм... Та сонссон юм уу?

- Тогтмол сонсдог байсан, "Бүгдэд оройн мэнд" гэдэг хөөрхөн нэвтрүүлгийг эгч та санаж байна уу?

- Тэр хүн та юм уу?! гэж Элен гайхав.

Элений анх удаа инээмсэглэхэд зүс царай нь хичнээн их засарч сайжирсныг би хараад гайхлаа. Ухаан нь та тосгоны ойр хавиар, байгалийн байдлыг тоож анзаарахгүй явж байлаа гэе. Гэнэт үүлний цаанаас наран гарахад орчны юм бүхэн амилан сэргэж, аялгуу сайхан дуу эгшиглэх мэт болно... Энэ хүүхнийг үүн лүгээ адилтгаж болох мэт санагдав. Хүүхэн тэр даруй нас залуу, тун хөөрхөн, сэтгэл сэргэлэн болж харагдлаа.

- Тэр нэвтрүүлгийг би хөтөлж байсан нь үнэн... Сонсогчдынхоо ухаан санаанд ямар нэг ул мөр үлдээнэ гэж бодоогүй шүү гэсэнд

- Та их сайхан дуутай юм. Таны дууг мартахын аргагүй. Та яагаад радиогоор ярихаа больсон

юм бэ? Та их сайхан нэвтрүүлэг хөтөлдөг байсан шүү дээ! гэж Ева хэлэв.

Үүнийг хорооноос лавлах хэрэгтэй. Радио хорооыхонд миний нэвтрүүлгийн дэндүү аминчхан байдал нь таалагдаагүй бололтой. Тэгээд хасчихсан юм.

- Тоогүй дээ гэж Элений хэлэхэд

- Үүнийг би хэн хэнээс илүү харамсдаг юм гэж наргиа болгон өгүүлэв.

- Одоо та юу хийж байгаа вэ? гэхэд нь би хуруугаа дугуйлан "тэг" дүрс үзүүлж

- Ийм л юм хийж байна... Парист чадах юм бүхнээ хийж, чухамдаа бол юу ч хийхгүй байсаар залхаж гүйцээд азаа үзэхээр наашаа ирсэн юм. Эндхийн "Монте- Карло Радиод" ажил өгмөөр юм хэлсэн... Бүтээгүй... Тоглоомын өргөөнд очиж үзсэн чинь... хувхай хоосон боллоо... Хөл минь чилж эхлэв. Би өндийж.

- За би явах юм уу даа гэв.

- Та хаачих юм бэ?

- Хаачих вэ дээ... Нэг тийшээ явна... Би эндхийн газрыг муугүй мэддэг болсон.

Ева эгчийнхэа өөдөөс харж| - Намайг юу бодож байна гээч? гэв. Эгч нь нэгийг мөрөөдөн санаашirсан юм уу даа, дүү бүсгүйнхээ өөдөөс хайхрамж муутайхан эргэж харав.

- Би шүлэг найраглалаа ноён Мендагаар уншуулж соронзон хальсанд бичүүлбэл сайхан аа? Та юу гэж бодож байна вэ? гэж Еваг хэлэхэд

- Болох л юм гэж Элен дуугарав.

Евагийн сэтгэл гэнэт хөөрөн догдолж, надад хандан

- Та төвөгшөөхгүй биз? Миний хэр тааруухан шүлэг найраглалыг тан шиг сайхан дуутай хүн уншвал уянгалаг яруу болно гэж итгэж байна. Манайд хэсэг саатаж, бидэнтэй хамт үдийн зоог барихгүй юу? гэв.

Энэ саналыг сонсоод миний хоосон ходоод хоржигнон хариу өгөв. Би өчигдрөөс хойш хэлэн дээр юм тавиагүй яваа. Тийм болохоор хэсэг мах, шарсан төмсний төлөө юу ч хийхээс буцахгүй болоод байв. Хэдий тийм боловч хүмүүжилтэй хүний ёсыг бодож татгалзахаар шийдэв.

- Өө би шүлэг найраглал уншиж чадахгүй... Уран уншлагад тун тааруухан...

Ева дур булаан цайвар шар үстэй толгойгоо нэг сэжиж

- Миний шүлэг найруулгад нэг их уран уншлага хэрэггүй гэв.

Энэ бүсгүй өөрийн хүссэн санасан болгоныг гүйцэлдүүлж сурсан эрх танхи амьтан гэдэг нь бүхий л байдлаас ил. Би ч гэсэн үгийг нь дагалаа.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Үдийн хоолны дараа дотоод хашаанд хоёр эзэгтэй лүгээ хамт тамхи татаж суув. Би Евагийн шүлэг найраглал гэж нэрлэсэн, чухамдаа тахир дутуугийн тэргэнцэрт хадагдсан хорин настай гоо үзасгэлэнт бүсгүйн цөхөрлийн дуу гэмээр дөрвөн жижиг эхийг уншиж хальсанд буулгав. Тэр хэдэн шүлгийг уншсаны дараа сэтгэл гутруу байлаа. Горь тасарсан гашуун гунигт шүлгийн дараа гэгээн нарны гэрэл ч бүдгэрэх шиг санагдана.

Энэ хоёр бүсгүйн байдлыг ажихад чамлахааргүй хөрөнгө зөөртэй ч гэсан энэ лут том байшинд амьдрах нь тийм ч хөгжил баясгалантай биш шиг. Танилцаад хэдэн цаг болсны дараа учир зовлонгоо цухас ярьсныг нь сонсоод би байдлыг ойлгов. Ева нь полиомиелит хэмээх нугасны бор эсийн үрэвслийн улмаас доод мөч нь эзэнгүй болжээ. Тахир дутуу хүн их аминчхан сэтгэл татам байдаг байна. Ева өөрийн эгч Эленээс нэгэн биеэ огоорон золихыг шаарджээ. Заяа тавилангийн эрхээр ийм байдалд орсон Эленд тун амаргүй байдаг биз.

Би нүдээ анив. Ирээдүйг бодож сэтгэлээ зовоомооргүй санагдана! Одоо тохиогоод байгаа энэ жаргалант мөчийн цэнгэлд сэтгэл ханаж суувал барав. Энд юм бүхэн сайхан байна. Дотоод хашаанд амар тайван, ус усан санд шоржигнож, цэцэрлэгт шувуу жиргэн шивэгнэлдэнэ. Хамгийн гол нь эгч дүү хоёр бүсгүй! Би дутуу аньсан зовхины цаанаас эгч дүү хоёрыг ажиглаж байв. Элен нь эртний герегийн хөшөө барималтай адилхан юм. Ариун журамт хүний тайван дөлгөөн, үзэсгэлэн сайхан царайтайг нь би нэгэнт лавтай мэдэв. Нүүрийн тэг нь өчүүхэн ч өөгүй. Элен цэцэрлэгийн хөнгөн сандал дээр суугаад дотоод сэтгэлийнчээ ямар нэгэн дуу хоолойг чагнаж байна уу гэмээр. Элений бодлогоширсон байдал надад их таалагдав. Хэрэв би зураач байсан сан бол энэ бүсгүйн дүрийг зотон дээр мөнхлөхсөн. Ева хөлөө хучсан цагаан баавгайн арьсыг илбэн байна. Ийм халуун нартайд цагаан баавгайн арьсаар хучдаг байна шүү! Үүнд нэг л үл ойлгогдох юм байна. Магадгүй өвчтэй хөл нь халуун, хүйтний алийг ч мэдэрдэггүй биз. Тэгвэл энэ ёсноос гаж илүү маяг хэнд хэрэгтэй юм бэ?

Олноос онцгой жаргалтай сайхан амьдралын төлөө заяасан баймаар ийм гоо үзэсгэлэнт бүсгүйд ийм гай зовлон тохиосон нь бүр ч аймшигтай! Уг нь Ева гоо үзэсгэлэн төгс, оюун ухаан сэргэлэн бүсгүй юм. Бүсгүйн эрхтэн дутуу байдал нь.жигшин сэжиглэх сэтгэл төрүүлэх авч баавгайн арьснаас дээшхи бахдам сайхан бие цогцос нь өөрийн эрхгүй нүд булаана. Нэг ч эрийн гар хүрээгүй байж таарах хөөрхөн мээмийг нь би бахдан ширтэв.

- Ноён Менда та юу бодоо вэ? гэж Ева гэнэт асуулаа.

Би тамхиныхаа ёзоорыг сандлын тохойвчинд зоосон үнсний саванд нухаад

- Би юм бодоогүй, үүл хөлөглөн хөвж байна... гэв. Элен хий гөлийн бодлогоширсон байдлаас гарч, нүдэнд нь сүйрдэгийн даваан дээр очсон амьтны аврал эрэн дуудаж буйтай адил харц илэрч

- Ийм байдал давтагдах нь гагц танаас шалтгаална гэв.

- Та их эелдэг хүн байна. Баярлалаа...

- Үгүй, харин бид хоёр л танд баярлах ёстой, тийм үү Ева?

Бүсгүй хариу хэлсэнгүй. Юунд ч юм бэ, нэг зүйлд санаа зовсон байдалтай харагдав... Нилээд удаан дуугүй сууцгаасны эцэст Ева хуруугаа инчдэж

- Ингэхэд та ажил олтлоо манайд түр байвал яасан юм бэ? гэв.

Ийм санал сонсоод амьсгаа минь давхцав.

- Бодоорой! гэж Элен дүүгийнхээ саналыг дэмжлээ

- Миний хувьд хоёр цагийн турш дан үүнийг л бодож байна гэж Ева бүр үнэнээ дэлгэв.

Гэхдээ ямар журмаар? гэхэд

- Сайн нөхрийн журмаар. Бидэнд дотнын нөхөр байхгүй. Одоо ингээд дотнын сайн нөхөртэй боллоо. Тийм үү, эгч ээ?

Эгч дүү хоёрын ярианы нэг онцлог гэвэл нэг нь нөгөөгөөрөө зөвшөөрөл авахаас нааш ямар нэг санааг гаргаж хэлэхгүй юм. Хоёул нэг гэрт олон жил хамт байсан амьдрал нь бат нягт холбоотой байсан болохоор эцсийн бүлэгт хоёр биетэй нэгэн өвөрмөц бодгаль болсон юм уу гэмээр. Би нэгтэй нь ярьж байхдаа өөрийн эрхгүй нөгөө рүү нь харж байв.

- Тийм л дээ, дүү минь.

Би эрс татгалзаж

- Энэ огт болшгүй хэрэг, мадемуазель... гэж эхэлтэл Ева уурсан тэргэнцэрийнхээ дугуйг чанга цохив.

- Тэнгэрийг бодож намайг дахиад битгий мадемуазель гэж дуудаач. Намайг Ева таныг Виктор, эгчийг Элен гэдэг. Зүгээр нэр нэрээрээ дуудаж байя... За одоо үүнийг яагаад болшгүй хэрэг гэж байгаагийнхаа учрыг тайлбарлана уу. Та нүдэнд дулаахан залуу хүн байна. Энэ байшинд иймэрхүү нэг хүн байж байвал бидэнд хэрэгтэй... Би ганц Амелиягийн царайг харсаар бүр залхаж гүйцлээ! гэв.

- Үнэнийг хэлэхэд Ева... гэсэнд бүсгүй дал мөрөө хавчаад

- Би бодсоноо хэлж байна. Миний амьдрал дэндүү арчаагүй. Тэгж санагдахгүй байна уу? Би алтан торонд хийсэн хөлгүй шувуутай адил... Энэ байшингийн өнцөг булан бүр нүдний минь өмнүүр өнгөрдөг... Би энэ усан оргилуурыг нэгд нэгэнгүй мэднэ... Чимээ нь миний зүрхийг урж сэтгэлийг сэмлээд байдаг юм...

- Тайвшир, Ева!

Элен дахиад төв ихэмсэг дүртэй болж, ширүүн байдлаар ярив. Ева тэргэнцэрийнхээ дугуйг хэдэнтаа аяархан цохиж эргүүлэн буруу харж суулаа,

- Ноён Менда та сохор улаан мөнгөгүй үлдсэн байна... гэж Еваг эхлэн ярихад

- Ева! гэж Элен дургүйцэн зандрав. Бүсгүй түүнийг нь тоосонгүй

-Танд идэх юм олдохгүй. Энэ тийм ч хөгжилтэй биш санагдахгүй байна уу, аан? гэж бүр хашгирав.

Би цорын ганц шийдвэр гаргаж өндийгөөд зөвхөн Эленд хандан

- Сайхан хоолоор дайлсанд тань баярлалаа... гээд эр хүн шиг толгой дээгүүр том том алхлан үүд рүү явав.

Ингээд эв эвдэрч, эгч дүү хоёр Лекэнтэй миний харьцаа ингээд дуусах болжээ. Ева даанч хэтэрхий эвгүй зан гаргасан болохоор Элен уучлал гуйхыг ч оролдсонгүй. Гагцхүү гэнэтийн тохиолдол энэ байдлаас аварч болох байв. Тэгтэл тэр даруй тийм нэг инээдэмтэй хөгийн юм болсон юм.

Усан санг тойруулсан нарийн хөвөө дээгүүр явж байсан би тахир дутуу бүсгүйн тэргэнцэрт ойр хүрэхгүй гэж энэ замыг сонгож авсан юм. Гэвч хөл минь хавтанг онгойлгодог цагирагт тээглэв. Тээглээд тэнцвэрээ олж ядан нөгөө хөл маань усан сангийн зүлгэмэл хүрээнд хальтирч би усанд уналаа. Эйэ бүхэн нүд ирмэхийн зуур болж өнгөрөв.

Дараа нь би гүн нь дөчин сантиметрээс үл хэтрэх усанд сууж байлаа. Дэлбэртлээ уурласан миний төрх байдал харваас инээдэмтэй байсан бизээ. Эгч дүү хоёр элгээ хөштөл инээлдэв. Босоход хувцсыг минь даган ус урсаж байлаа. Би өөртөө ч эгч дүү хоёрт ч уур хүрээд энэ хийх ажилгүй хоёр хүүхнийг нэг нэг сайн алгадаад авах юмсан гэхээс гар минь загатнаж байлаа.

Хүний сэрэл сэтгэлийн бүх илрэл дотроос инээд хэмээгч хамгийн халдвартай нь билээ. Миний уур төдөлгүй намдаж, би энэ насандаа хэзээ нэгэн цагт инээж байгаагүйгээрээ инээв. Би усан сангийн зах дээр сандайлж тэндээ эвхэрч нугаран хөл минь усан дотор санжигнаж байлаа.

Хамгийн эхлээд Элен инээхээ больж суудлаасаа босож, миний дэргэд ирээд надад гар сунган уснаас гарахад минь туслав.

Дотоод хашааны чулуун хавтан дээр биед наалдсан нойтон өмдтэй зогсож байгаа би инээдэмт жүжгийн жүжигчин шиг харагдаж байсан байх.

- Та хувцсаа солих хэрэгтэй. Халуун усны өрөөнд очицгооё.., Танд гэрийн дээл өгье. Амелияг зочид буудал руу явуулж, таны хувцсыг авчруулья. Та хаана буусан бэ? гэж Элений асуухад

- "Цэнхэр долгион" зочид буудалд... гэв.

Би Эленийг даган хоёрдугаар давхарт буй халуун усны өрөө рүү очлоо. Нойтон костюмаа мушгиж байхдаа зарц эмгэнд Элений заавар тушаал өгч байгааг сонсоод байрны мөнгө төлөөгүйгээ даруй санав. Тэр эрхэм хүндэт буудлын эзэн миний юмыг зарц авгайд яасан ч өгөхгүй дээ! Би ичиж үхэх шахан хаалгыг дутуу онгойлгож

- Мадемуазель Лекэн! гэж дуудсанд Элен даруй хүрч ирэв.

Өргөн цээжийг минь яг барьсан гэрийн цагаан халадтай би яасан инээдтэй амьтан харагдаа бол?! Ханцуй нь миний тохойнд хүрэхгэй үгүйтэй юм.

- Би... Танай зарц авгайд төвөг удах хэрэггүй болов уу даа... Өмдийг минь индүүдээд өгвөл болоо. Тэгвэл би хот орж болох байна... гэсэнд Элен үгийг минь тоож сонссонгүй.

- Тэгж яриад яах вэ! Өмд чинь шал нойтон байна Маргааш ч гэсэн чийгтэй хэвээр байх болно гэв.

- Тэгсэн ч гэсэн.,. Би...

Элен бас эсэргүүцэж үг хэлэх гэснээ гэнэт учрыг ойлгосон бололтой дуугүй болов. Би ичсэндээ нүүр минь халуу оргиод ирлээ. Элен цааш эргэж, зарц авгайг дуудан

- Амелия! гэв.

- Юу гээ вэ, мадемуазель аа?

-- Ноён Менда манай энд түр суух болно. Зочид буудлын эзэнтэй ярилцаж тохироод ноёнтны тээшийг хөлсний машинаар аваад ирнэ үү гэсэнд Амелия гайхан балмагдаж

- Энд суух гэнэ... гэж аман дотроо бөвтнөснөө даруй санаа авч: - За тэгье, мадемуазель гэв.

- Та Еваг ингэж баярлуулахаас татгалзахгүй юм байгаа биз гэж Элен хэлээд инээмсэглэв.

Энэ нь түрүүчийнхээс өөр инээмсэглэл байлаа. Инээмсэглэлийн нь цаанаас сэтгэл зовсон байдал нэвт харагдана.

Хэрэв би эгзэгтэй хүнд байдалд ороогүйсэн бол Элений саналыг дахин татгалзах байсансан. Гэтэл одоо би аягүй байдалд ороод хувцаслах хүртлээ хүний нүднээс далд байх юмсан гэхээс өөр бодол толгойд байхгүй болжээ....

-Энэ тухай сүүлд ярья гэж би шүүрс алдан өгүүллээ. Элен миний дэргэдүүр өнгөрч, гантиг дуурialган будсан модон шат тийш харсан нэг хаалгыг онгойлгож - Танд одоо өрөөг чинь зааж өгье гэв. Миний өрөө гэнэ шүү. Юу ч гэх вэ, гайхалтай сонин адал явдал болж байна!

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЛЭГ

Ямар ч атугай энэ шөнө би тавтай сайхан унтав, Үүрээр миний өрөөний хавьд аяархан шажигнах чимээ гарахад сэрээд орноос ухасхийн босож, цонхны дэргэд очив. Энэ бол байшингийн ар тал юм байна. Гимнастикийн цагираг дээр Элений дасгал хийж байгааг, хийх хийхдээ энгүй сайхан хийж байгааг би хараад гайхан мэлрэв. Хажууд нь татлага өлгөжээ. Элен бариу цэнхэр өмд сайхан мээмийг нь дурайтал тодруулсан хөх цагаан судалтай майк өмссөн байв. Бүр хараад байгууштай!

Би нүүр гараа бушуухан угааж, маалинган өмд, битүү цагаан цамц өмсөв, Би тоглоомын өргөөнд хэдэн цагаар суудаг байсан ч өнгөрсөн хэд хоногт бие минь аятайхан борлосон учир энэ цагаан хувцас миний зосон арьсыг улам тодруулах учиртай. Өргөөнд дуган доторхи шиг чимээ аниргүй байв. Шатаар чоно мэт сэмхэн гэтэн бууж үүдний өрөөнд очиход кофений үнэр ханхлана.

Цаг зургаа болж байна. Олон жил би ийм эрт босоогүй. Дотоод хашааг өнгөрөн байшингийн ард очлоо. Элен цагираг дээр дасгал хийсээр. Би Элений араас сэм очиж, тамхи асааж аваад том чулуун дээр суун түүнийг харж эхэллээ. Элен биеийн тамирын танхимд уралдаанд оролцож байгаа тамирчдын л хийдэг тийм дасгал хийж байв, Эцэст нь сум шиг суниаж, цагиргыг алгуурхан тэлэн урагш тонгойхдоо л намайг харав бололтой даруй үсрэн буулаа. Түүний нүүр улайж, цээж нь оволзон байв.

- Догь байна! Та их сайн тамирчин юмаа! гэсэнд хүүхэн хариу хэлэх гэснээ амьсгаа нь давхцаад чадсангүй.

- Та өглөө болгон ийм дасгал хийдэг үү? гэхэд хүүхэн толгой дохиод

Тийм. Бие чийрэгжүүлэх үүнээс өөр арга байхгүй гэв,

Би тамхиа хаяад эзэгтэйгээсээ нүд салгаж чадахгүй ширтэн байлаа. Урт хөл, нарийхан бэлхүүс, уяхан нуруу . Миний нуруугаар хүйт оргих шиг болов.

-Та биеийн тамирын дасгал хийх гэж өглөө бүр ийм эрт босдог юм уу?

- Тиймээ дүү бүсгүйгээс болоод, Дасгал хийж байгаагаа дүүд харуулахгүй гэж л.

Би гэж нэг тэнэг амьтан "яагаад?" гэж асуусан даруй учрыг ойлгож

- Өө тийм л дээ, таны зөв! гэж залруулан хэлэв.

Эгчийнхээ дасгал хийж байгааг дүү бүсгүй нь харвал сэтгэл нь эвдрэх биз.

Элен явж хувцсаа солих болов. Би түүнээс салалгүй, хараад л баймаар байлаа.

-Элөн танаас нэг даруу биш юм асууж болох уу

- Асуу л даа .

Та хэдтэй вэ? гэсэнд духныхаа хөлсийг гараараа арчаад

- Гучин хоёртой гэв.

-Намайг дэмий юм асуулаа гэж гомдоогүй биз?

- Өө хаанаас.

- Тэгвэл дахиад нэг юм асууж болох уу? гэхэд хүүхэн инээмсэглэн

- Тэгсэн ч яах вэ гэлээ.

- Ер нь бол гучин хоёр настай, эрд очоогүй эмэгтэйг, уучлаарай, хөгшин хүүхэн гэж болно. Таныг хэлж байгаа юм биш шүү. Ер нь юу болж дуусах вэ?

Би арай дэндүүлснээ даруй ойлгов. Элений царай зэвхий дааж, нүдний нь харц хүртэл хүйтэн зэвүүн болоод

- Би хэвийн байдлаар төлөв төвшин амьдарч байна. Биеийн тамирын дасгал хийдгийг та өөрөө сая харлаа... гээд бүр ичиж сандарсан байхыг нь харж тэврээд авмаар дур хүрэв.

- Уучлаарай. Би гэж усан тэнэг... Элен та хөөрхөн гэж хэлэхэд багадахаар гоо үзэсгэлэн төгс юм гэсэнд хүүхэн үнэнээсээ уурлаж

- Намайг ингэж магтахад зэвүү хүрээд байдаг юм. Миний санаанд таардаггүй гээд гүйн одов.

Би ичингүйрэн байрандаа зогсоод үлдлээ. Тэгтэл тасхийтэл инээд алдахыг сонсоод тэр зүг харвал хоёрдугаар давхрын цонхоор Евагийн царай харагдав. Ева саяын бүх үзэгдлийг нүдээр харсан байж. Намайг гар даллан дохиход бүсгүй хариу өгөхийн оронд цонхноос холдлоо. Үүдний танхимын цаад захад Евагийн тэргэнцэрийг хоёрдугаар давхарт гаргах өвөрмөц маягийн өргүүр хийжээ. Тэр нь ачаа өргөдөг төхөөрөмжтэй ойролцоо агаад хаалганы оронд аюулаас хамгаалах сур бэхэлсэн байв. Намайг үүдний өрөөгөөр өнгөрч явахад Ева бууж ирлээ. Бүсгүйг сэтгэлийг угаас өрөвдөхийн сацуу эвлэг аятайхан хөдөлгөөнийг нь өөрийн эрхгүй, бахдав. Эрүүл бидний биеэ албадалгүй чөлөөтэй алхаж гишгэдгийн адил Ева тэргэнцэрээ чадамгай хөдөлгөх юм. Энэ тэргэнцэр түүний биеийн нэг хэсэг мэт болсон нь мэдэгдэж байлаа.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Энэ өглөө Ева шотланд цамц өмсөж, энгэрээ хөхний цагаан даруулга нь харагдахуйцаар яржээ. Өчигдөр Евагийн өөгүй сайхан бие цогцсыг хараад сэтгэл догдолсон шиг одоо бас зүрх минь булгилав. Би дэргэд нь очиж нээмсэглэх аядан

- Сайхан нойрсов уу Ева? гэсэнд бүсгүй жуумалзан

- Та тоглож байна уу даа? Би нойр муутай болсоор хэдэн жил болж байна гэв.

- Таны насан дээр үү дээ?

- Энд миний нас ямар ч хамаагүй. Та ойлгомоор юм даа...

- Та шөнө шүлэг зохиодог уу?

-Тийм.

- Тийм болоод таны шүлэг найраг хар бараан байдаг юм уу? Хэвтээ үзэл санаа шиг дэмий юм байхгүй.

Бүсгүй өөдөөс минь нүд бүлтийн ширтэх нь өнөөдөр өчигдөрийнхөөс илүү өнгөтэй харагдаж байна.

- Би эгц босоо үзэл санаа гаргахыг хүсдэг юм. Даанч энэ болшгүй хэрэг.

Бүсгүйн сэтгэлийг засаж юу хэлмээр юм бэ?

- Та миний насыг асуухгүй юм байна гэж бүсгүйн шивэгнэх төдий өгүүлэхэд миний нүүр халуу оргиж

- Таны царайг хараад насыг чинь мэдэж болох байна. Та хорьтой гэсэнд

- Таачихлаа. Та өөрөө хэдтэй вэ? гэв.

- Хорин наймтай.

Бүсгүй намайг ичиж эрээлхэлгүй бахдан харах нь хэтрээд тэргэнцэрээрээ намайг тойрон хараад Элөнд миний хэлснийг дууриан элэглэж байгаа юм шиг

- Та цэвэрхэн сайхан эр юм... гэхэд нь миний уур хүрч

- Та миний гадаад төрх байдлыг шоолж сонжих гэж намайг энд үлд гэсэн юм уу? гэсэнд

- Өө хаанаас. Таныг зүгээр харж байх гэсэн юм. Би чинь сүүлдээ энэ дэлхий дээр эр хүн байдаг болов уу гэж өөрөөсөө асуух болсон хүн гэв.

Амелия орж ирэв. Энэ авгай намайг нэг нүдээрээ ч үздэггүй.

- Цай бэлэн.

Би Евагийн тэргэнцэртэй зэрэгцэн зочлох өрөөнд оров, Элен тэнд биднийг хүлээж байлаа. Тариачны банзал, цагаан цамц өмсчээ. Бүр харсаар байтал залуужиж байх шиг.

Би нэг аяга аагтай кофе уугаад сандлаа ширээнээс холдуулж

- Одоо би та нарыг орхин явахаар хатуу шийдсэн гэв.

Эгч дүү хоёрын царайд ав адилхан гайхан мэгдэх байдал илэрч, бие нь хөших мэт болов.

- За дахиад эхэллээ гэж Ева санаа алдан өгүүлэв.

Би босож өрөөн дотуур сэтгэл тогтож ядан хөлхөн

- Миний энд байх нь утгагүй хэрэг гэдгийг хэлэхийн хэрэг алга. Би чинь угаадас долоодог мууртай адилгүй. Хүүхнүүд намайг шоолж инээлдэхийг яасан ч хүлцэхгүй.

- Та эвгүй үг хэлж байна гэж Элен шивэгнэв.

- Би тухайн байдалд тохирох үг хэлж байна гэхэд тэр

- Жаахан бодоод үзээч! Өвөртөө сохор улаан мөнгөгүй, толгойдоо ядаж хэдэн улаан мөнгө яаж олох өчүүхэн ч бодол санаагүй би танай гэрт толгой хоргодож танай хоолыг хороож байна. Энэ чинь хэвийн байдал уу?

Ева сонин хачин зураг үзэж байгаа юм шиг намайг харав. Арай л гараа дугуйлан дурандсангүй.

- Энэ хүн уурлахаараа сүртэй сайхан харагдах юм. Тийм үү, эгч ээ? гэхэд нь

- Дуугүй байгаач! гэж Элен зандарлаа.

Энэ хүүхний сэтгэл ингэтлээ хөөрөн догдолсон байгааг би урьд үзээгүй. Хацар нь бүр минчийн улайжээ.

- Виктор та ямар улстай харилцаж байгаагаа ойлгоогүй юм шиг байна.. Тоогүй дээ. Хэдийгээр бид жаахан хөрөнгө мвнгөтэй ч гэсэн чухамдаа ядарсан хоёр бүсгүй шүү дээ. Бид энд хоригдол юм шиг сууж байдаг гэж Элөннй хэлэхэд

- Энэ хэний буруу юм бэ? Та нарыг энд хэн хорьсон юм бэ? гэв.

- Танаас бусад нь бүгдээр. Та мэддэг ч болоосой. Тодорхой нөхцөл байдал бий. Манай эцэг гэрийн мухар сахисан хүн байсан. Багагүй зовлон амссаныг хэлэх хэрэгтэй. Ээж маань намайг төрүүлээд нас барсан юм. Манай эцэг хойноос нь арван жил гашуудан уйлаад дараа нь дахин гэрлэсэн. Хоёрдахь эхнэр нь манай эцгийн охин байж болохоор залуу хүүхэн. Еваг

төрүүлсний дараа аавтай хамт байж байгаад... дараа нь нэг хар хүн дагаад алга болсон. Тэгэхэд нь аав бид хоёртой хамт энд ирж төвхнөсөн юм. Эцэг маань өвчтэй араатан шиг хүн байлаа. Тэгээд ийм нэг лут том нүх ухаж биднийг гадаад ертөнцөөс тусгаарласан юм гэж Элөн яриад дуугүй болов.

Минчийн улайсан хацар дээгүүр нь нулимс урсан байлаа. Нулимс урсаж байгааг өөрөө мэдэхгүй байх шиг. Би хамаг учрыг даруй ойлгов. Энэ хоёр бүсгүй гадаад ертөнцийн хөл үймээнт жинхэнэ амьдралыг огт үзээгүй юм байна. Тийм болоод намайг ингэж хоргоогоод байгаа бололтой. Эдний нүдэнд би бусад бүх ертөнцийг төлөөлсөн хүн болж харагдаа юу даа.

- Дараа нь Ева өвдсөн юм гэж Элен нэмж хэлэв.

- Намайг ийм болоогүй бол танд амьдралын аятайхан боломж байх байсан даа. Үүнийг би үргэлж боддог Та мэднэ... Мйний тэргэнцэр хүзүүнээс чинь зүүгдэж, таныг амьдралаа золиход хүргэсэн юм гэж Ева аяархан өгүүлэв.

Би хоёр бүсгүйн гашуун гунигт үгийг даасангүй, доош харан суулаа.

- За тэгвэл ийм байна...- гэсэнд хоёул дуугүй боллоо:

- Яах вэ, би нэг хэсэгтээ энд үлдье... Нэг л болзол бий. Би ажил олмогц... гэсэнд

- Баярлалаа гэж Элен шивэгнэв.

- Ажил олоход амархан. Надад санал байна гэж Еваг эхлэн хэлэхэд би үгийг нь таслан

- Цэцэрлэгчийн ажил уу? гэсэнд

- Үгүй, бичээчийн ажил... Бид хамтарч ном хэвлэнэ. Та хэдийг авах вэ? гэв.

Элений царайд тэсэхүйеэ бэрх энэлэн шаналсан байдал ил. Дүү бүсгүйнхээ үгийг арга буюу дагах нь олон тохиолддог учир номхон хүлцэнгүй байдлаар харцаа буулгалаа.

- Ева та хэдийгээр баян чинээлэг ч гэсэн би үнэрхүү хүн шүү. Хөрөнгө бэл чинь намайг хөлсөлж хүрэхгүй. За би гадагшаа гарья. Орой болтол баяртай гэж хэлчихээд би гадагш гарлаа.

Би гудамжны амьсгалыг дахин мэдэрч, тэнгисийн усанд шумбан наранд шарж цэнгэн буй алаг цоог олны дунд ороод сэтгэл жаал сэргэв. Эгч дүүсийн гэр орны нөхцөл байдал надад зохисгүй нөлөөлж, бяр тэнхээг сулруулан бүр санаа сэтгэл алдагдуулсан байна. Тэнд би удаан байж тэсэхгүйгээ мэдрэв,

Миний халаасанд сохор улаан мөнгө ч байхгүй л дээ үүнээс нэг их айхгүй байлаа. Эгч дүү хоёр Леканы нэг хэвийн уйтгарт амьдралыг бодвол миний өл хоосон амьдрал ирээдүйн хүсэл найдлагаар дүүрэн байгаа. Тэгээд би урждар яах гэж амиа хорлохоор завдсанаа гайхав.

Би нарийхан гудамжаар явж байлаа. Замын цаана байшингийн хана, дээвэр улайстлаа халаад

ядахдаа өчүүхэн төдий сэвэлзэх салхигүй, тэнгэр цайвар өнөгтэй харагдана. Би хий алмайран алхалж явсаар асга хадны завсар хүнгүй зэлүүд газар олж, гараа дэрлэн тэнгэр харж хэвтээд тэнгисийн долгион намайг аажмаар бүүвэйлэхийг сонсож байв,

Үдийн хэрд гэдэс өлсөж эхлэхийг мэдэрлээ. Эгч дүү хоёрын гэрт эргэж очмоор санагдавч эр хүний наад захын омог бардам сэтгэл саад болов. Би өөрийн байдлыг эрэгцүүлэн бодож үзлээ. "Эндээс ажил олох хэрэгтэй" гэж хэлсэн минь сайхан хүсэл төдий байлаа. Надад ямар ажил олдохыг бүү мэд. Нэр нүүрээ мартаад цагаар хөлслүүлэх юм уу, зоогийн танхимд туслах ажил хийлтэй биш дээ, Би чинь эрхбиш жаахан боловсролтой, англиар бага сага ярьдаг хүн. Нийслэлийг орхиж гарсан нь гэнэн болчимгүй хэрэг болсныг одоо л ойлгож байна. Парист ямар ч хүн "Нүхээ олж" чадна. Сэтгэлээ чангалж байгаад үзэлцэх хэрэгтэй юм. Харин энэ амралт зугаалгын нутагт бол...

Гэнэт зам дээр нэг машин зогсоод чагнаалдаж байгаа сонсдов. Америк машин байна. Би нүд гялбам хурц нарнаас гараараа саравчлан яарвал жолооны нь ард Элен суусан байлаа. Түүнтэй уулзах боломж таарсанд баярлан босов. Бас хажууд өөр хүнгүй байхад... Элен цэнхэр костюм өмсчээ. Энэ өнгө түүнд их зохих юм. Нүдний нь харц сэтгэл ханасан байдалтай.

- Таныг энд байгаа гэж мэдсэн юмаа хэмээн аяархан өгүүлэв,

- Яагаад?

- Мөнгөгүй хүн тэнгисийн хөвөөнд ирж хэвтэхгүй өөр хаачих вэ дээ?

- Учир зүйтэй үг байна, мисс Шерлок Холмс оо! Намайг ямар ч ажилгүй ингээд хэвтэж байхад Элен таны олж ирсэн нь таатай байв. Одоо намайг ажил эрж байгаа гэдэг чинь яалаа гэж ам асуун зэмлэх бололтой.

- Харав уу даа, би элсэн дээр сууж байна. Нарийндаа бол шаварт суучихаад байгаа хэрэг! гэж бөвтнөв.

Тэгснээ энэ хүүхнийг хараад энэ чинь цаад шөнийн солиотой банзал биш байгаа даа хэмээн сэжиглэж зэвүүрхэв. Бүр ар нуруу руу хүйт оргиод ирлээ.

- Та юунд намайг ингэж муухай харна вэ? хэмээн Элен гайхан асуув.

- Би... юм бодож байна.

- Юу бодоо вэ?

Би "ухаан санаа руу нь өнгийж харъя" гэсэн мэт өөдөөс нь эгцлэн харж

- Таныг тэр шөнийн хүүхэн байсан юм биш биз дээ гэж бодож байна... гэсэнд

- Таныг дайрсан хүүхэн үү? гэв.

- Тийм... Намайг... дайрах шахсан хүүхэн!

Элен огт жишимгүй байна. Нүүрнийх нь нэг ч булчин хөдөлсөнгүй. Нүд нь цэвэрхэн, гунигтай хэвээр байлаа.

Өө та их зөрүүд хүн юм байна... Би шөнө гадагшаа явдаггүй гэдгээ танд хэлсэн шүү дээ. Түүнээс гадна та намайг хүн дайрчихаад зугтах хүн гэж үнэнээсээ бодож байна уу? Виктор та миний тухай их муу юм боддог хүн юмаа!

- Уучлаарай... Толгойд хий бодол ороод... Ингэхэд та энд юу хийж яваа вэ?

- Таныг эрээд...

- Намайг эрээ юу?

- Тийм. Таныг эрсэн!

- Үгүй, юу болж байгааг ойлгохгүй байна, учрыг хэлнэ үү, Элен.

Хүүхэн хариу хэлэлгүй машинаасаа буун ирэв. Савхан өсгийтэй хөх туфли өмсчээ. Элсэн дээгүүр хэдэн алхам ойртож суугаад

- Манай дүү бүсгүй үе үе санаа сэтгэлээр их гуньж гутардаг. Ингэж гуньж гутрах нь цөөнгүй байдаг ч гэсэн энэ удаагийнх шиг ингэтлээ унаж байгаагүй. Тантай уулзсан нь Евад ингэж их нөлөөлсөн юм шиг санагдаад байна гэв.

- Надтай уулзсанаас уу? гэсэнд Элен толгой дохив. Би гар дэлгэн гайхширч

- За харж байгаа биз дээ. Би алга болох хэрэгтэй. Ер нь би байлаа гээд дүү бүсгүйд чинь ямар хэрэгтэй юм бэ?!

- Виктор та даанч ойлгохгүй байна гэж үү Манай Ева таныг харсан дороо дурлачихсан байна. Миний хоолой өөд нэг муухай юм огшоод ирэхийг мэдрэв. Өрөөл татанхай бүсгүйтэй ойртоно гэж бодох нь цус нийлүүлсэнтэй адил санагдаж байлаа.

- Тэгвэл надад эргэлзэх юм огт алга. Би нэгдүгээр араа залгаад алга болъё... гэсэнд Элен миний өөдөөс жигшин зэвүүцсэн байдалтай хялам хийж

- Ноён Менда та сүрхий өрөвч зөөлөн сэтгэлтэй хүн юмаа! гэж егөөдөв.

- Өрөвдөх сэтгэл үл зохих тийм тохиолдол бий шүү дээ, мадемуазель Лекэн! гэсэнд Элен нэг л бодлогоширон байснаа дараа нь гэнэт инээмсэглэн

- Та бидний уулзсан нь гайхалтай сонин юм. Учир нь та бид хоёр арван үг солих бүрдээ бие биеэ гомдоох юм даа. Таныг манай гэрийн босго алхсан цагаас л хатуу үг хэлж байна гэв.

- Нээрээ тийм. Еидний харилцаа төдий л таарамжтай биш байна...

Бид дуугүй болов. Элен байрандаа суусаар. Гэхдээ би түүний эрхэмсэг дүр төрх, ариун

журамт төлөв байдлыг хараад бахдах сэтгэл төрлөө. Энэ хүүхнээс ихэс язгуртны эрхэмсэг намба төрх туяаран байх шиг санагдана.. Олон хүүхэнд байдаггүй нэг тийм онцгой шинж түүнд байна.

- За тэгээд та алга болох юм уу? гэж хүүхэн асуув.

- Би алга болох хэрэгтэй байна. Дүү бүсгүй чинь чинь 20 настай гэвч жаахан охин хэвээрээ юм. Түүний насанд иймэрхүү сэтгэл газар авахуулах нь аюултай. Таны саяын хэлсэн анх харангуут дурлалаа гэдэг чинь өсвөр насны жаал охины хийрхүү хоосон санаа. Хүн санаанд таарсан номоо сонирхдог шиг Ева намайг сонирхсон хэрэг.

- Та түүний занг мэдэхгүй байна. Нэгэнт оройтжээ, Виктор оо! гэхэд нь би элс атгаж

- Евагийн дурлал гэдэг нь үүнтэй адил... гээд алгаа тэнийлгэв.

Хэдэн элс миний алганд шигдэн үлджээ. Элен гэнэт гараа сунган алгаа минийх дээр тавьсанд элсэн ширхэг миний алганд үлдсэн элсний ширхэг түүний арьсыг жаахан урав. Гэнэт миний зүрх цээжиндээ багтаж ядан дуугүй байж тэсэхгүй боллоо. Энэ нэгэн сэрэл миний ухаан санааг бүрэн эзэмдлээ. Хүүхний өөдөөс болгоомжтой харвал тунгалаг хөх нүд нь алс тэртээх тэнгисийн мандлыг ширтжээ.

- Элен!

- Өөв?

- Би алга болох хэрэгтэй нь Евагаас болж байгаа юм биш...

- Аан?

- Танаас болж байгаа юм...

Хүүхнийг шүүрс алдах юм уу, миний өөдөөс нэг онцгой харсан гэж бүү бодоорой. Элен хэсэгхэн зуур түдгэлзээд дараа нь миний гараас гараа татаж авахад мөчир дээр сууж байсан шувуухай нисэн одох мэт болав.

- Элей та намайг ойлгож байна уу?

- За яах вэ, мэдэж байгаа гэж бодъё. Тэгээд юу гэж?

Энэ хүүхэн миний тэртэй тэргүй бэрхшээлтэй байдлыг улам хүндрүүлэх гээд байна уу даа? Эсвэл намайг өөрийн сэтгэл зүрхний гүнд удирдан аваачих гэж байгаа юм уу?

- Тэгвэл үү? Тэгвэл зүгээр... Хэрэв би адал балмад явдалтай хүн байсан бол арга заль гаргаж болох сансан. Би энгийн нэг мөрөөрөө шудрага хүн... Энэ цагийн байдалд зохицох чадваргүй дэндүү цэвэр, нэр нүүрээ дэндүү их боддог хүн. Миний юу гэж байгааг та ойлгож байна уу?

- Дүгнэлт нь?

- Дүгнэж ядах юм алга. Нэгэнт эхэлсэн энэ явдлыг үргэлжлүүлэх нь та бидний хэн хэнд ашиг болохгүй. Ямар ч гэсэн би та нарт тус болж чадна бодохгүй байна гээд би өндийв.

- Юм бүхэн таны хүссэнээр болно, Виктор таныг хоёр, гуравхан хоног л хүлээгээч гэж хүсэх байна. Энэ завсар Евагийн урмыг хугалж болох байдлыг олж чадвал. Хогийн ургамлыг устгахын тулд хор цацдаг шиг Евагийн мөрөөдөнгүй хөөрүү сэтгэл дээр ус асгаж, урмыг нь хугалах хэрэгтэй байна. Та очино биз дээ гэлээ.

Би хойноос нь дагав. Машинд нь суусан даруй шөнийн адал явдал эрдэг хүүхэнтэй зууралдан ноцолдсоноо даруй санаж, бүр одоо болж байгаа юм шиг дурслаа. Үгүй дээ, янхны газраас хүүхэн урхидсан цэрэг аятай, гудамжнаас намайг урхидаж суулгасан хүүхэн энэ Элен байх ёсгүй... Эсвэл эргүүлээд хэлэхэд Элен тэр хүүхэн байх ёсгүй!

ТАВДУГААР БҮЛЭГ

Ева биднийг байшингийнхаа довжоон дээр хүлээж байв. Түүний тэргэнцэр, цагаан баавгайн арьс, алтан шаргал үсийг харахад уран зураачид зургаа зурахаар сууж байна уу гэмээр. Машинаас миний буухыг хармагц Ева огцомхон эргэж, байшин руу бушуухан орлоо. Биднийг үүдний өрөөнд ороход өргүүр хэдийн хоёрдугаар давхарт гарсан байв.

- Ингэж элдэвлэхийн хэрэг юу вэ? гэж Эленээс асуусанд

- Евагийн яахыг тааж мэдэх аргагүй. Сэтгэл түгшин уйтгарлаж байснаа одоо жаахан тайвшраад маяглаж байгаа нь энэ. Маргааш болтол маяглах ч магадгүйгүй гэлээ.

- За яах вэ байдллыг үзэж мэдье. Өрөө нь хаа байдаг юм бэ?

- Өргүүрийн зүүнтээх эхний хаалга.

Би Евагийн "урман дээр ус асгах" ажлаа нэн даруй эхлэхээр хатуу шийдэн шатаар өгсөн гүйв. Энэ бүсгүйн толгойноос анх харсан даруйдаа дурласан гэдэг бодлыг нь одоохон ховх цохиод өгье! Би үүдийг нь чанга балбав. Ева хариу өгсөнгүй. Тэгэхэд нь зөвшөөрөлгүй онгойлгон орох гэтэл өвчтэй амьтан чинь үүдээ түгжчихсэн байна.

- Ева! Одоохон онгойлго! Чимээ алга.

- Үүдээ одоохон онгойлгохгүй бол би даруй явна гэдгээ сануулья. Миний хойноос хүн явуулах юм байгаа биз.

Ева үүд онгойлголоо. Хаалганы цаана түгжээг нь гартаа бариад хүлээж байсан бололтой, хаалга агшич зуур онгойв. Би бүсгүйн өрөөнд орлоо. Сүрчигийн зөөлөн үнэр ханхалж байна. Булбарай ягаан өнгийн цаасаар доторлож, өнгө нийцсэн улаан хүрэн хивс дэвсжээ. Х Карлын үеийн хийц маяг бүхий цайвар шар өнгийн хогшил тавилгатайай. Ягаан юм уу, цагаан өнгийн гэрэлт чимэд чулуун өнгийн эд юмсаар чимэглэсэн байв.

- Тантай учир явдлаа ярилцья...

Бүсгүйг өвчтэй байгаа юм уу гэж айв. Царай нь цав цагаан болж, уруул нь цайж хөхрөөд хий гөлөрсөн нүдэнд нь учир битүүлэг далдын айдас нуугдсан байлаа. Би үүд хаав. Ева тэргэнцэртэйгээ хана руу очив.

- Би таны авир араншингийн тухай ярихаар ирлээ, хүүхээ!

- Та ичдэггүй юм уу? Та өөрөө ямар авир араншинтай болоод ингэж байгаа вэ?! Та өөрийгөө хүмүүжилтэй хүн гэж боддог уу? Би энэ насандаа тан шиг ийм бүдүүлэг хүнийг үзээгүй юм байна.

- Уучлаарай. Нэгэнт та намайг өөрийн дотнын нөхөр гэж хэлснээс хойш би таны дотны нөхрийн ёсоор тантай харилцаж, танд туслахыг хичээе.

Ева миний өөдөөс нэг хатуу үг хэлэх гэснээ яагаад ч юм бэ, дуугүй өнгөрөх шиг. Хэрэгтэй үг олоогүй юм уу эсвэл зогьсуулах гээд юм хэлж чадахгүй байна уу? гэтэл нь тун их догдолсон янзтай.

- Ева та тахир дутуу болохоор өөрийгөө олон талын давуу эрхтэй гэж үздэг байна. Жинхэнэ хэрэгтээ таныг асарч тойлдог хүмүүст их хэцүү байгаа! Та өөрт учирсан зовлонг эрэлхэг зоригтой хатамжлан тэсэхийн оронд гуниг гутралдаа автаж суух амархан замыг сонгож авсан байна гэсэнд

- Тэгээд би яах ёстой юм бэ? Гудамжинд гуйлга гуйх үү? Та намайг тэг гэж байгаа юм уу

- Ойлгохыг оролдоод үз. Та явж чадахгүйгээ мартаж, явж чаддаг хүмүүсийг үзэн ядахаа болих гэж оролдоод үз.

- Та сургаал айлдаж байна уу?

Миний зэвүүг хүргэх гэж элдэвлэн оролдож байгаа нь бүр жигшмээр. Би тэссэнгүй алгадаад авлаа. Би энэ насандаа эмэгтэй хүнд анх гар хүрч буй нь энэ. Ингэнэ гэж даанч бодоогүй явсансан... Миний гар тугалга цутгасан юм шиг хүнд байсныг тэр даруй мэдээд харамсан гэмшив. Евагийн өөдөөс харахад ичмээр байлаа. Нүд минь эрээлжлээд хаалганы бариулаас шүүрэн гарах гэтэл

- Виктор оо! гэж дуудахад нь эргэж харав.

Хацар нь улайсан байх боловч царайд нь инээмсэглэл туяаран нүд нь дахиад усан сангийн уснаас ногоон өнгөөр туяаран байна.

Наашаа ойртоод ирээч! гэж бүсгүй гар занган дуудав.

Би үгийг нь даган ойртож очихдоо одоо миний нүүр амыг маажих гэж байгаа юм болов уу гэж нэг бодлоо. Гэтэл Ева миний толгойг хоёр гараараа тэврэн авч өөр рүүгээ татан миний уруулд уруулаа наалаа. Бүсгүйн шүд хавиралдан тачигнаж миний аманд цус амтагдах мэдэгдлээ. Ева дээд уруулыг минь хазсан байж. Намайг ухрах гэтэл бүр хүчтэй зууран тэвэрлээ. Бүсгүйн халуун амьсгаа миний цээжинд нэвтрэхийг мэдрэв. Ева намайг галзуу юм шиг озон таалж байлаа. Би анхандаа ингэж нийлэхийг эсэргүүцэж байснаа төдөлгүй энэ бүсгүйн эрэмдэг зэрэмдгийг ч мартаж орхиод... өөрөө түүнээс дутуугүй озон таалж эхлэв.

Тэгж тэгж, бүсгүйн гараас мултрахад толгой эргэж байлаа. Би алчуур гарган уруулаа арчив. Ева нүдээ дутуу аниад миний хөдлөх бүрийг ажиглаж байлаа.

- Та намайг алгадаад авсан нь намайг өөрийн зарчмын дагуу хэвийн эрүүл хүн шиг үзэж хандсангүй. Тийм болохоор хэрэв би хэсэг зуур ч гэсэн хэвийн эрүүл хүн шиг загнасан бол намайг уучлаарай...

Уруулын цус тогтсоны дараа би хаалганы бариул эргүүлэн

-За би явья гэхэд бүсгүй татгалзсангүй.

Оройн хоолон дээр Ева их хөгжилтэй, яриа хөөрөөтэй байлаа. Ердөө архи ууж халамцсан юм шиг чанга, чанга дуугаран гар хуруугаа дохиж занган зүв зүгээр байснаа тас, тасхийтэл инээж байв. Надтай үнсэлцсэний дараа сэтгэл нь гүйцэд тогтоогүй бололтой. Үүнийг Эленд хэлэх болов уу гэж айж байлаа. Ева бид хоёрын хооронд болсон явдлыг Эленд мэдэгдэхгүйн тулд би юу ч хийхэд бэлэн байв. Хүний амьдралд амьдралаасаа хайр найргүй аваад хаячихмаар тийм мөч тохиолддог байна. Тэнгэр минь, би Еватай үнсэлцсэн тэр агшныг хичнээн их үзэн ядна вэ!

Хоолны дараа бид дотоод хашаанд гарч эрүүл агаар амьсгалав. Ева гэнэт дуугаа хурааж, хөдлөхгүй боллоо. Дахиад сэтгэл нь хямарч эхэлсэн бололтой. Эленийг явж унтацгаая гэхэд нь энэ эвгүй байдлаас гарах аятайхан үг хэмээн баярлаж даруй тарцгаав... Мэдээжээр, миний нойр хулжсан... Евагийн өгсөн адал явдалт роман унших гэж оролдсон боловч уншсанаа огт ойлгохгүй байлаа. Цонхны дэргэд суун, тамхи асааж авав... Өрөөнд муухай бүгчим халуун байсан учир гадагш гарч жаал сэрүүцэхээр шийдлээ. Шатаар сэмхэн буув. Биднийг өрөө өрөөндөө орсноос хойш хэдэн цаг өнгөрчээ. Дотоод хашааагаар тойрон байшингийн ард очлоо. Нүцгэн хөлийн дороос элс аятайхан сэрүүцүүлнэ. Би дан гэрийн өмдтэй байв. Сэрүүн агаар цээж дүүрэн амьсгалаад биеийн чилээ гарган суниаснаа дотоод хашаанд нэг хүн байх шиг сонсдоход нь давхийн бослоо,

Муур юм болов уу гэж бодоод сайн харвал нэг хүн хашааны дагуу сарны гэрлээс нуугдан гэтэж явна. Гарааш руу гэтэж явна шүү!

Би амьсгаа даран модны араар нуугдлаа. Төдөлгүй дотоод хашаанаас хана даган Элений гарч ирэхэд миний зүрх пал хийж, нүд харанхуйлан хөл минь золтой бохисхийсэнгүй. Би амдаж очоод

- Элен! гэж дуудсан хүүхэн давхийн цочиж, амьсгаа аваад

- Та намайг цочоож орхилоо! гэв.

- Та хаачих гэж байгаа юм бэ?

Намайг бодвол Элен хувцастай байлаа. Өргөн банзал хөнгөн ноосон цамц өмсчээ.

- Салхинд гарч явна гэж хүүхэн хариулав.

- Та шөнө гадагшаа гардаггүй гэж хэлсэн шүү дээ.

- Тийм. Өнөөдөр нойр хүрч өгдөггүй...

- Тэгвэл та одоо машиндаа суугаад хаялга дээрээс нэг хар юм урхидах л үлдэж дээ.

Хүүхний эрүү ээтийж, нүд нь гялалзах нь харанхуйд хүртэл харагдсан гэж танд андгайлах байна.

- Виктор та солиоров уу?

- Асуух юу вэ?! Тан шиг ийм бүсгүйг үнэн хэрэг дээрээ нэг муу банзал юм байна гэж мэдээд галзууралгүй яах вэ!

Элен намайг түрүүнд дүүг нь миний алгадсанаас дутуугүй чанга алгадаж шагнав. Их хурдан алгадсан тул би зайлж завдсангүй. Миний зүүн хацар халуу шатаж энэ нь миний сэтгэлийг тайвшруулллаа. Элен амьсгаадан

.- Танд намайг доромжлох эрх хэн олгосон юм. "Нэг хар юм урхидана" гэдэг чинь юу гэсэн үг Таны толгойд яаж ийм балай бодол ордог байна Та яасан ичдэггүй хүн бэ?! гэж хашгичив.

Би амьсгаа авлаа. Толгойд олон зүйлийн бодол эргэлдэв.

- Элен! Би таны машинд дайруулсан гэж худлаа хэлсэн юмаа...

- Тийм ч байх гэж сэжиглэж байсан гэж хэлэхэд

- Яагаад? гэж би гайхан асуув.

- Би нягт нямбай хүн шүү, Виктор оо. Гаражныхаа үүдийг үргэлж түлхүүрээр түгждэг. Миний машиныг шөнө хэн ч авч чадахгүй гэж бат итгэж байна

Би эндүүрч, Эленийг дэмий сэжиглэснээ сая ойлгов. Элен хэрэв тэр шөнийн зальхай хүүхэн мөн байсан бол машиныг нь хүн хулгайлж хэрэглэсэн гэсэн миний таамаглалыг няцаахгүй, харин ч бүхий л чадлаараа дэмжих байсансан. Би

- Би хэлэх юмаа хэлж дуусаагүй байна... гэж эхлэн ярьснаа хоёрдугаар давхрын нэг цонхонд гэрэл асахыг ажиглав.

- Евагийн цонх. Бидний яриаг сонсоогүй байх болтугай... гэж Элен шивэгнээд миний гараас хөтлөн холдуулж, модны дор аваачив.

Тэнд бид нарсны шилмүүс хучсан элсэн дээр, гэрэлтэй цонхыг ширтэн удтал дуугүй сууцгаалаа, удалгүй цонхны гэрэл унтрахад бид дахин ярилцаж эхлэв

- Таны хэлснээр... гэж Элений эхлэхэд би үгийг нь таслан

- Тийм шүү... Та ямар ч нягт нямбай хүн байсан гэсэн тэр шөнө таны машин гараашаас гарсан нь үнэн. Гэхдээ харин намайг дайраагүй... өөр нэг юм болсон...

- Өөр нэг юм гэж юу вэ? гэж Элений асуухад энэ хүүхэнд үнэнийг хэлэх яасан хэцүү вэ! Түүний тунгалаг харцын дор хэл минь татчих шиг боллоо.

- Виктор танд ямар явдал тохиолдсон юм бэ?

- Намайг салхинд явж байтал хажууд минь нэг машин ирж зогслоо... Машинд нэг залуу эмэгтэй байсныг танд батлан хэлье. Царайг нь харж чадаагүй, их харанхуй байсан... Эмэгтэй намайг машиндаа суу гэлээ... Та... Та намайг ойлгож байна уу?.. гээд дуугүй болсонд Элен

дуугүй толгой дохив.

- Та тэгээд машинд нь суусан юм уу? гэж нэг л өөр дуугаар асуухад нь би нэг хэсэг эргэлзэн байснаа

- Тийм гэж хариулаад болсон явдлыг товч ярив.

Элен намайг нарийн тодорхой ярь хэмээн шаардах болов уу гэж айж байв. Гэтэл хоёр гараар толгойгоо бариад уйлж эхэллээ. Би үсийг нь илбэн

Элен.,. гэж аяархан дуудав.

- Та үүний тулд нь манайд ирсэн юм уу? Тэр хүүхнээ олно гэж найдсан уу?

- Тиймээ. Тэгэхдээ ердийн амьдралд ямаршуу хүн байгааг нь харах гэсэн юм. Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүүхэн байгаа болов уу гэж бодсон, одоо ч тэгж бодсон хэвээр...

- Хэрэв тэр хүүхэн чинь би байсан бол та яах байсан бэ?

- Бүү мэд... Таныг доромжилж, хэрүүл шуугиан дэгдээх байсан болов уу даа..

- Тэгэхлээр та саяхан намайг... гээд Элен цааш үргэлжлүүлж чадсангүй, жигшин зэвүүцэж, цөхрөнгөө барсан бололтой байв.

- Элен та өөрийгөө миний байранд тавиад бодотун. Таныг хана даган гарааш руу гэтэж явахыг чинь хараад...

- Тийм дээ, тийм...

- Нэгэнт илэн далангүй ярьж эхэлснээс хойш хэлье. Миний толгойд урьд ч ийм бодол ордог байсан. Өчигдөр хаялганы дэргэд таны машинд орж суухад...

- Тэгвэл та сая намайг амдах гэж боссон юм уу?

- Хаанаас даа тэнгэр минь! Тантай нэг адил нойр хулжаад... Ийм шөнө..

Би цээжин бие минь нүцгэн байгааг мартаж хүүхний мөрөн дээр гараа тавьж, өөр рүүгээ татан хацар нь миний нүцгэн цээжинд хүрэхэд тэр давхийн ухасхийн зайлав.

-- Элен!.. Танд нэг юм хэлмээр байна...

- Үгүй, хэрэггүй...

- Элен... Би танд хайртай!.. Сая ханын дагуу гэтэж явааг хараад нээрээ сэтгэл мэдрэлийн өвчтөн шиг санагдаж, нүд минь харанхуйлсан... Би ухаан алдах шахсан шүү...

Элен мод налан суув. Нүүр нь харагдсангүй өмнө нь өвдөг бөхрөн сууж, мөрөн дээр нь гараа

тавьсанд бүсгүй эсэргүүцсэнгүй, гагцхүү бие нь чичирлээ

- Элен

Би бүсгүйн дээрээс тонгойж, бие рүүгээ татан уруулыг нь озлоо. Тэгэхэд минь Элен намайг хоёр гараараа тэврэн авч, бид хоёр хүсэл тачаалдаа хөлчүүрсэн адгуус аятай, элсэн дээр унав...

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Би элсэн дээр сунайн хэвтээд одтой тэнгэрийг ширтэн байлаа. Элен миний гэдсийг дэрлээд хоёр гараар намайг тэврэн хэвтэж байна.

- Миний шөнийн амьдралын талаар чиний санааг улам лавшруулаад өглөө дөө би гэж Элен шүүрс алдан өгүүлэв,

- Үгүй шүү, Элен...

Энэ хүүхэн сая надтай учирснаараа огт ондоо нотолгоо гаргаж өглөө гэдгийг өөрт нь хэлж болох уу! Бид хоёрын сая ойртож хавьтсан нь бузар муухай тачаалтай огт адилгүй байсан. Элен сая надад шударга журамт бүсгүйн адил биеэ тайван өгч, юуны өмнө сэтгэлээ өгөв. Би үсийг нь илээд

- Үгүй дээ, Элен. Тэр бол чи биш байсныг би баттай мэдэж байна гэв.

Бид хоёр сая биеэр ойртсоноосоо илүү одоо сэтгэлээр ойртохын цэнгэлийг эдлэн хичнээн удаан хэвтсэнийг хэлж мэдэхгүй байна.

- Элен!

- Өөв?

- Чи надад хайртай юу?

Иймэрхүү нөхцөл байдлын дунд эр хүн эмэгтэй хүнээс ингэж асуухад арваас есөн тохиолдолд нь учир үл ойлгогдох урт хариу сонсоно гэж баттай хэлж болно. Элен бол “хайртай” гэх ганцхан үг хэллээ.

Хажуугийн төмөр замаар галт тэрэг давхиж өнгөрөх сонсдов.

-Хоёул одоо буцаж орон болсон юм биш үү дээ гэсэнд

-Чиний зөв гэлээ.

Хоёул босоод би Эленийг дахин тэвэрч үнсэн таалав. Хувцас нь юу ч үгүй норж, элс наалджээ. Хүүхний чичирхийлэн буй халуун биеийг мэдрээд золтой л дахин солиорсонгүй. Элен надаас холдож

-Явцгаая гээд гараас минь хөтлөн дагууллаа. Тэнгисийн зөөлөн салхи сэвэлзэн байна. Аяа энэ салхи яасан таатай вэ? Байшинд орохын өмнө би дахин зогсож Эленийг тэврэх гэтэл зөвшөөрсөнгүй.

-Элен би чамд нэг юм хэлмээр байна ...

-Би бас ...

-Хэл л дээ

-Эхлээд чи хэл ...

-Би хэзээ ч одоогийнх шиг ийм жаргалтай байж үзээгүй. За одоо чи хэл

-Би бас чамд ингэжл хэлэх гэсэн юм

Бид хоёр үүдний танхимд оров. Гаднаас орж ирэхэд тас харанхуй байлаа. Эленийг гэрэл асаахад шатны дэргэд тэргэнцэртээ сууж байгаа Еваг хараад би хөшиж орхилоо. Биднийг харцаараа цоо өрөмдөх мэт ширтэхэд нь бид хоёрын төрх байдлыг нэгд нэгэнгүй нарийн ажиглан шинжиж байгааг нъ мэдрэв. Миний нүцгэн цээж, үсэнд наалдсан гацуурын шилмүүс, эгчийнхээ үнгэгдсэн нойтон хувцас, бидний үсэнд наалдсан элс... Хамгийн гол нь дурлалын эрхэнд автагдсан бид хоёрын харцыг ажигласан биз.

Элен дүүгийнхээ харцыг дааж өнгөрүүлөв. Ева түрүүлэн харцаа буулгалаа. Нэг хэсэг яахаа мэдэхгүй эргэлзэж байснаа дараа нь тэргэнцэрийнхээ дугуйг огцомхон эргүүлэн өргүүр тийш очлоо.

Дээшээ алгуурхан өгсөж яваа Евагийн хойноос Элен бид хоёр харж байв. Ева хүйтэн хөндий харцаа Эленээс над дээр шилжүүлж, тэгснээ амьгүй амьгүй цайвгар хөл нь харагдаад удалгүй далд орлоо. Элен нүдээ гараар таглаж

-Аймшигтай юм гэж шивэгнэв.

Үнэнээ хэлэхэд надад ч гэсэн тийм хөгжилтэй биш байлаа.

Түрүүн Еватай үнсэлцсэн, үнсэлцээгүй байдал их эгзэгтэй байсан. Үнсэлцсэний дараа бүр арга мухардсан аймаар байдал бий болох шиг.

- Одоо яах вэ? гэж Элен шүүрс алдан асуулаа

- Явж унтацгаая. Яахыг маргааш шийдье...

- Би байна шүү...

- Юу гэж?

- Би айгаад байна, Виктор оо!

- Юунаас айгаа вэ?

- Еваг тэнэглэж сүйд хийх вий гэж. Хэцүүхэн ааш зантай хүн шүү!... Юу ч болж мэднэ!

- Жаахан уйлж байгаад унтана биз. Маргааш хамаг учрыг хэлье.

- Юу гэж учирлах юм бэ?

- За бид хоёр бие биедээ хайр сэтгэлтэй болсон гэж!

- Ева үүнийг мэдээгүй гэж бодож байна уу?

—Мэдсэн л дээ. Бид үүнийг хэвийн нэг зүйл гэж хэлнэ. Ева үүнийг хүлээж авах ёстой.

Элен бүр гайхшаа барсан байдалтай байв. Түүнийг аргадаж тайтгаруулах гээд нэмэр болсонгүй.

- Энэ санааг Ева хэзээ ч хүлээж авахгүй.

- Бүү тэнэг юм хэл.

Элен цөхрөнгөө баран хуруу гараа нужигнуулав. Энэхэн мөчид улам үзэсгэлэнтэй сайхан болсон шиг санагдлаа. Би энэ хүүхэнд ухаангүй дурлажээ.

- Виктор оо... чи одоо дүү дээр очих хэрэгтэй. Дүүд хамаг учрыг сайн хэл... Чиний үгэнд орох байх. Чи л түүнд учрыг хэлж чадна

- Маргааш...

- Маргааш гэхээр хожимдож магад. Чи Евагийн занг мэдэхгүй байна. Яаж ч мэднэ...

- Юу гэж?

- Өсөө авахын тулд яахаас ч буцахгүй... Хэрэв Ева дээр орохгүй юм бол би...

Энэ ч бас болшгүй хэрэг.

За яах вэ... Явж унт. Би Еватай яриад үзье. Евагийн тэргэнцэрийг их нарийн бодож зохиосон учир ямар ч саадгүй хөдлөх боломжтой. Суудлыг нь өргөж буулгаж, түшлэгийг нь гэдийлгэж болно. Үүний ачаар Ева хүнээр туслуулалгүй орон дээрээ гарч, бууж чадна. Намайг өрөөнд нь ороход Ева орондоо хэвтэж байлаа. Би тэргэнцэр нь хоосон байхыг анх удаа харав.. Эзэнгүй тэргэнцэр их эвгүй харагдах юм. Ева бид хоёрын нэгийг ирнэ гэж хүлээж байсан бололтой, үүд нь түгжээгүй байв. Намайг ойртон очиход өөдөөс минь доогтой жуумалзан инээмсэглэж

-Хараач! Энэ гэрийн эр хүн ороод ирлээ! гэв. Энэ битүү егөөтэй үгийг сонсоод миний дотор хүйтэн оргиж

- Битгий дэмий юм ярь гэсэн шүү юм дуугараад орны нь дэргэд сандал дөхүүлэн сууж:

- Жаал бүсгүй жөтөөрхөж байгаа юм уу даа? гэсэнд Ева учир зүггүй тас тас хөхөрч

- Би жөтөөрхөх гэж үү? Танаас болоод уу? Ах та биеэ өргөмжлөхийн интэй хүн байна! гэв.

- Би эгчид чинь хайртай, Ева!

Энэ үг түүний барьцыг алдуулжээ. Уг нь намайг болгоомжтой үг хэлнэ гэж хүлээж байсан бололтой. Тэгээд миний түс тас хэлсэн үг түүнийг балмагдуулав.

- Тэр худлаа. Үгүй, үнэн, Би өөрийгөө яаж. ч чадсангүй. Хар аяндаа ийм. юм болсон. Эгч чинь бас надад хайртай.

- Та хоёр ханилан сууж олон хүүхэдтэй болно... гэж Ева хэлээд хийрхэн инээд алдсанаа биеэ барьж чадалгүй мэгшин уйлж эхлэв.

- Ева... Би ажил явдлаа аялуулж байж дараа нь ханилан суух тухай ярина.

- Тэгвэл зуун жил хүлээх болно доо.

- Даажигнахаа болиоч. Сэтгэлээ онгойтол уйлбал дээр.

- Хараач хөөе!..

- Нээрээ шүү, сайн уйлбал танд тус болно. Ингэж хэлэхийг хүлээж байсан мэт Ева асгаруулан уйлж эхэллээ. Дэрэнд нүүрээ нуугаад бие нь чичрэн эхэр татан уйлахад нь би аргадаж тайтгаруулахаас ч айгаад... зүгээр хүлээж байв. Нулимс хэмээгч хүний сэтгэлийг ариутган угаах увьдастай байдаг гэсэн. Тэгж тэгж Евагийн сэтгэл тайвширсан боловч уйлж улайсан нүдэнд нь ичсэн байдал илэрч, миийй өөдөөс эгцлэн харахаас зайлсхийж байв.

- Ева! Танд бас нэг юм хэлж болох уу? гэсэнд бүсгүй толгой дохив

- Би байна шүү, танд...

- Үнэнхүү журмын сайн нөхрийн сэтгэлтэй байдаг уу. Яриад байгаарай, ярьсан бүхнийг чинь би үнэмшье гэх бас л егөөдөн өгүүлэв.

- Үгүй дээ, Ева, энэ бол нөхөр журмын сэтгэл биш. Илүү нарийн мэдрэмж... Би Элен та хоёрыг ялгаж салгахыг хүсэхгүй... Та ойлгож.байна уу? Энэ айлд гэрсэг сайхан агаар амьсгал бий болгохыг хичээнэ. Харж байгаарай, бид олон сайхан юм бодож олно шүү! гэса Ева өөдөөс минь гайхан ширтэв,

- Өчигдөр танд миний юу хэлснийг санаж байна уу?.. Бид хоёр тэгж нэг солиорохын өмнө?- гэсэнд Ева жуумалзаад

- Таны хэлсэн тэр солиорлын тухай эгчид хэлбэл юу болохыг та төсөөлж байна уу? гэв.

Энэ нэг жүжгийн бүр эхнээс аваад Еваг намайг сүрдүүлэн шахаж магадгүй гэдгийг мэдэрч байсан юм. Миний нүүр халуу оргисон ч шальгүй жаахан төрхгүй зангийн тухай ярьж байгаа юм шиг өөдөөс нь тайван харж, хөгжилтэй дүр үзүүлэн

- За яах вэ, тэглээ гэж бодьё гэв.

- Эгчийн яахыг та мэдэх үү?

- Яана гэж?

- Таныг одоо даруйхан зайл гэх болно. Тэгээд та чемоданаа аваад явах ганц зам үлдэнэ...

Би энэ эгзэгтэй хүнд байдлаас гарахын тулд одоо даруйхан хүний санаанд оромгүй нэг онцгой юм хийх хэрэгтэйг ойлгов. Тэгээд гудамд гарч

- Элен! Наашаа түр хүрээд ирээч! Ева танд нэг юм хэлэх гэж байгаа бололтой! гэж дуудлаа,

Евагийн өөдөөс эргэж харахад нүдэнд нь гайхан тэвдсэн байдал илэрч, түрүүчийнхээс огт өөр хүн болсон байлаа. Элен шөнийн цайвар хөх хувцастайгаа, сэтгэл зовнисон байдалтай орж ирээд үүдний тэнд түр зогсож, дүүгийнхээ өөдөөс айсан байдалтай харлаа

- Юу гээ вэ, дүү минь? гэхэд нь Ева хоолой засаад

- Виктор сая хэллээ... гэв.

- Аан?

- Та хоёр бие биедээ хайртай болсон, тэгээд ойрын үед ханилан суух гэж байгаа юм байна... Виктор ажилд орохоор тэгэх юм уу?

Элен миний өөдөөс гайхан харж, нүдээ анивчив. Ева цагаан даавууныхаа сэжүүрийг имрэн байж

Бас та нар намайг эндээ хамт байлгах болов уу гэж найдаж байна гэхэд нь Элен орны дэргэд очиж, дүүгийнхээ нүүр рүү унжсан алтан шаргал үсийг арагш нь болгож,

- Тэгэлгүй яах вэ дээ, дүү минь... гэв.

- Виктор түргэхэн шиг ажил олбол сайн байна. Тэгвэл их сайхан болно тийм ээ? гэхэд нь Элен толгой дохив.

Ева дахиад асгаруулан уйлж эхэллээ. Бүр цурхируулан уйлахад нь би айв. Ор нь доргиж, бүсгүй юу юугүй бахардан унах нь уу гэмээр байв. Элен зэргэлдээх халуун усны өрөөнд гүйн орж, нэгэн аяга ус авчран жижиг ширээн дээрээс хүрэн өнгийн шилтэй шингэн авч гурав дусаагаад Евад уулгалаа. Тэгээд Еваг эх хүн мэт хайрлан тэвэрч

- Унт даа дүү минь. Маргааш ярьцгаая гэв. Евагийн эхэр татан зогисуулах нь аажмаар намдаж, амьсгаа нь жигд тайван болоход Элен бид хоёр өрөөнөөс нь гарав. Миний хамаг биеийн хүйтэн хөлс чийхарсан байлаа. Зүрхний хий гэдэг энэ.

- Баярлалаа. Аймаар байсан шүү, тийм ээ? Гэж Элений хэлэхэд дал мөрөө хавчаад

- Санаа дагаад тэгж санагдсан хэрэг гэлээ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хэдэн хоног гойдын юм бололгүй өнгөрөв. Тэр нэгэн галзуутай шөнийг бодвол хачин тайван үе эхэллээ. Элен бид хоёр сүй тавьсан хоёрын байдалтай байж, ямар ч атугай журамтай хүмүүсийн ёсоор бие биеэ хүндэтгэн "та" хэмээн дуудах боллоо. Ева ч гэсэн бидэнтэй адил баярлаж байгаа бололтой, ам л ангайвал удахгүй болох хуримын тухай ярина. Би түүний хөөрүү сэтгэлийг жаахан дарах хэрэгтэй болж

- Ева! Энэ тухай ярихад арай эрт байна шүү гэдэг байв.

Ингэж хэлээд миний нүүр халуу оргино. Би ажил олж хийх талаар өөрөө хуруу ч хөдөлгөөгүй байгаа шүү дээ, Элен дуу шуу цөөтэй байх болов. Бид гурвын дотроос Элений сэтгэл хамгийн их тогтворгүй байх шиг.

Нэгэн орой бид урьдын нэгэн адил хоолны дараа дотоод хашаанд сууж, Амелия бидэнд кофе аягалж байв. Зарц авгай намайг нэг нүдээр үздэггүй хэвээр. Би айлд ирээд эдний нарын амьдралыг орвонгоор нь эргүүлсэн байж л дээ. Авгай ч сэтгэлийнхээ гүнд намайг адал балмад явдалтан гэж үздэг бололтой. За ер нь энэ зарим талаар зөв ч юм уу даа. Эмгэнийг явсны дараа Ева надад хандан

- Вик та (намайг Вик гэж дууддаг болсон юм) хэл дээ. Та олдохгүй ажлыг олох гэж биеэ зовоож байснаас жишээ нь нэг дэлгүүрийн эзэн болбол дээр юм уу? гэхэд нь би ярвайж

- Үгүй, энэ надад таарахгүй! гэв.

- Танд мөнгө байхгүйг мэдэж байна. Тэр ямар хамаа байсан юм бэ? Эгч бид хоёр өөрснийхөө мөнгөөр дэлгүүр худалдаад авч болно... Та ажил хэргийг нь эрхлэн хөтөлнө, Сайхнаа даа, аан? гэж Евагийн сэтгэл хөдлөн өгүүлэхэд Элений царай туяарч

- Евагийн хэлдэг зөв. Энэ их сайхан санал байна

- Та нар тэртэй тэргүй надад их өршөөлтэй хандсан гэсэнд

- Энд юу нь өршөөлтэй байгаа юм бэ? Энэ чииь харин арилжаа наймааны ажил. Эгч бид хоёр мөнгө гаргаж дэлгүүр авна. Бидэнд ажлыг нь эрхлэн явуулах хүн хэрэгтэй. Таныг ичээж зовоохгүйн тулд дэлгүүрийг бидний нэрээр ажиллуулна. Ашгийг хуваж авцгаана... Үүнийг сайн бодох хэрэгтэй. Тийм үү, эгч ээ?

- Тийм л дээ.

- Та маргааш нотариусад утасдаарай гэхэд нь би тэднийг зогсоож

- Байзаарай... гэсэнд

- Бас өөр юу байгаа юм бэ? гэж Ева тэсэж ядан өгүүлэв.

- Та нар нэг жижигхэн зүйл мартчихжээ.

- Юу юм бэ?

- Би арилжаа наймааны ажил огт мэдэхгүй. Мэддэг чаддаг юм гэвэл бичиг цаастай ноцолдох. Арилжаа наймаа мэдэхгүй хүн яаж дэлгүүрийн эзэн болж чадах вэ дээ?

- Дэлгүүр янз янз байдаг. Заавал архи дарс, хуурай хэрэглэл худалдаалах алба уу? гэж Элен хэлэв.

- Тэгээд юу худалдах юм бэ? гэсэнд энэ ярианд Евагийн сэтгэл хөөрөн хацар нь улайгаад

- Юу худалдахыг би мэднэ гэв.

- Үгийг чинь сонсоё.

- Вик ээ, бидэнд их догь дэлгүүр хэрэгтэй. Пянзны тасагтай байна. Хамгийн түрүүнд америк пянз. Гүйлгээ маш сайн байх болно! гэв,

Энэ аятайхан санал юм. Ева үргэлжлүүлэн

- Дараа нь дэлгүүрт бас уран зургийн тасаг байна. Хэрэв ажлыг сайн зохион байгуулж, үнэхээр авьяастай зураачдын сайн зургийг сонгон авч чадвал бас гүйлгээ сайтай байна... Бас урлагийн талын номын тасагтай байна... Товчоор хэлэхэд шилмэл дээд хэсгийнхэнд үйлчлэх соёл, урлагийн танхим байх юм... Марсель, Ментоний хооронд өөр ийм дэлгүүр байгаа ч юм уу үгүй ч юм уу, хэн мэдэх вэ! гэхэд нь энэ санаа миний сэтгэлийг ч эзэмдэж

- Энэ санааг гүйцэлдүүлэхэд хэдий хэрийн хөрөнгө мөнгө орохыг та нар мэдэж байгаа биз дээ гэсэнд Ева Элен тийш эргэж

- Эгч ээ бид үүнийг хийж чадахуйц бэл бэнчинтэй биз дээ гэхэд Элен хэсэг бодолхийлээд

- Хүрэлцэхээр хөрөнгө мөнгө бий байх, үүнийг сайн бодож үзэх хэрэгтэй байна гэж хариулав. Ингээд бид даруй ажилдаа орлоо. Үүдний өрөөнд шал дээр өдий төдий зураг, төсөл ноорог дэлгэж тавив. Амелия нотариус, үл хөдлөх хөрөнгийн худалдагч, уран барилгач нарт хаалга тайлж өгдөг ажилтай боллоо.

Би пянз худалддаг нэг томоохон пүүстэй харилцах болов. Энэ зүйлд миний нэр хүнд хэрэгтэй боллоо. Олны сонирхолыг татсан радио нэвтрүүлэг хөтөлдөг над шиг хүн иймэрхүү ажил эрхэлж эхэлснийг тэр пүүсийнхэн зүй ёсны асуудал гэж үзжээ,

Элен бид хоёр хэдэн долоо хоногт чухам ямар байр эс үзэв?! Тэдгээрийн аль нь ч зай муутай шиг санагдлаа. Тэгж тэгж бид Каннын яг төвд буй хуучин грашийн байрыг сонгож авлаа. Тэнд бидний анх бодож төлөвлөснөөс хавьгүй их ажил хийх хэрэгтэй байв. Гэхдээ бололцоо нь ч илүү өргөн юм

Нэгдугээр давхрыг нэлд нь дэлгүүрт зориулах ёстой. Хоёрдугаар давхарт нь уран зургийн үзэсгэлэн худалдаа байрлуулна. Бэлтгэл ажил өрнөж байх зуур зарлал сургалчилгааны талын юм хөөцөлдөж Ницца болон тэр нутгийн сонины газруудад хандлаа. Хэрэв намайг Номин

Хөх Эрэгт байх үедээ сонины газруудад ажил өгнө үү хэмээн хүсэж хандсан бол надтай олон таван юм ярихгүй байсан нь мэдээж. Харин намайг бие даасан ажил үүсгэхээр сэдэж байгааг мэдмэгц миний санааг даруй сонирхоцгоов.

Би тэр ноёдод хожим бараагаа хөнгөлттэй үнээр өгнө хэмээн амалж, тэд нар өөрсдийн зүгээс "Мөрөөдлийн хайрцаг" /нэрийг Ева бодож олсон юм/ хэмээх шинэ дэлгүүр нээгдэх гэж байгааг өргөн зарлан сурталчилахаар амлав. Тэд нар миний урьд хийж байсан нь ажиллагааг даруй дурсан санаж намайг авьяастай хэмээн магтацгаав... Зарим нь тэр ч байтугай соёл урлагт зориулсан нүүртээ миний гэрэл зургийг гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Би нэр нөлөө бүхий хүмүүстэй уулзаж тэднээр дамжуулан уран зураач Пикассотой танилцаж, зарим нь намайг Кап-Феррад Кокто Дээр авч очив. Би хоёр их зураачаас өлзийтэй сайн ерөөлийн үг сонсож тэдний дэмжлэгийг авахаар боллоо. Ялангуяа уран зургийн үзэсгэлэн худалдааны талаар. Товчоор хэлэхэд би энэ хөөрхөн адал явдалд хамаг хүч бололцоогоо дайчлан оролцож, энэ ажил надад гайхам сайхан санагдах боллоо. Үүнийг гайхах зүйл алга. Миний заяа тавилангаар азын тэнгэр наашаа харсан нь энэ.

Хэрэв эгч дүү хоёр Лекэн азаар таарч туслаагүй бол би гэдэг хүн ёстой нэг гуйлгачин болох замаа засаад байсаи юм. Тэгээд Эленийг хайрлах сэтгэл түүний ачийг санан хүндэтгэх сэтгэлээр улам батажлаа. Бас Ева анх харсан даруй дурласан сэтгэл гэдгээсээ миний ямар нэг оролцоогүй, өөрөө бие даан салж чадсанд нь би түүнд их баярлаж байлаа. Евагийн зан хувирч, номхон дуулгавартай болсонд нь баярлан би эгч дүү хоёрт улам их ээнэгшин даслаа. Эцсийн бүлэгт би энэ айлын хүчээр л хөл дээрээ босожд* эхлэв. Тэгээд "учраа ярилцсан" тэр нэгэн шөнө Евад амалсныхаа дагуу энэ айлд эвтэй сайхан уур амьсгал бий болгохыг аль чадахаараа хичээж байлаа.

Ажил явдалд оролцох тусам сэтгэлд улам аятайхан санагдах болов. Би хөрөнгө зөөр хэмээгч юугаар ч сольшгүй зүйл байдаг юм байна гэсэн "гайхамшигтай" нээлт хийв. Юу вэ гэвэл хөрөнгө бэлтэй хүний өмнө үүд хаалга бүхэн аяндаа нээгдэж, үйл ажиллагааны хязгааргүй эрх чөлөө бий болдог байнам..

Энэ өргөөний үүдний хонхыг дарсан тэр өдөр миний толгойд гайхалтай сайхан санаа төрж дээ! Тэр өдөр аяа тавилан минь намайг тэтгэсэн байжээ.

Би энэ олдсон бүх юмны жинхэнэ эзэн нь биш гэдгийг маш сайн мэдэж байв. Хэдий тийм боловч энэ бүхэн миийй мэдэлд байж байна. Тэгэхлээр эцсийн үр дүн нь би энэ бүх юмны эзэн нь байсантай бараг адил болох төлөвтэй.

Би өглөө бүр зургаан цагт босож, Элентэй хамтран цагираг, олс дээр биеийн тамирын дасгал хийх болов. Бараг тамир тэнхээ алдартал дасгал хийгээд дараа нь усанд орно. Дараа нь Еватай хамт хэдүүл дотоод хашаанд өглөөний цай хоол ууж иднэ.

Өглөөний цай бидний хамгийн хөгжилтэй сайхан цаг байдаг. Бид кофе ууж, хачиртай талх идэнгээ тэр өдөр хийх ажил явдлаа ярилцана. Элен худалдаа арилжааны хэсгийг эрхэлж, Ева уран сайхны талыг харна. Ева өдий төдий нэрсийн жагсаалтыг шүүн үзэж өөрийн сонирхсон пянзыг тэмдэглэн авн, холбогдох мэдээ баримтыг тусгай дэвтэрт бүртгэж авдаг. Миний

тухайд гэвэл өглөе нь дэлгүүриын байрыг янзлах ажлын явцыг хянаж байгаад үдээс хойш ажил төрлийн хүмүүстэй уулзана.

Тэр өглөө халуун усанд ороод дотоод хашаанд Ева алга байхад нь бид их гайхав. Амелиягаас асуухад Еваг түрүүнээс хойш ер харагдаагүй гэлээ. Би Эленийг ганцаараа кофе ууж бай гээд өөрөө юу болсныг мэдэхээр дээш гарав. Евагийн өрөөний үүдний тогшиход хариу өгөхгүй болохоор нь даруй дотогш орлоо.

Ева бөх унтаж байна. Уг нь өдийд хэдийн боссон байдагсан. Миний сэтгэл зовоод бие нь зүгээр эсэхийг мэдэх гэж орны нь дэргэд очлоо. Амьсгаа нь жигд тайван байна. Духан дээр нь гараа тавьж үзэхэд халуунгүй байв. Бодвол нойр нь хулжаад унтахгүй байсаар бүр үүрээр унтсан болов уу даа.

Би өлмийгөөрөө гэтэн өрөөнөөс гарах гэтэл өрөөсөн хөл нь орон дээрээс унжсан байсанд Еваг сэрээд мэдээгүй хөлөө татан авч чадахгүй болов уу хэмээн сэтгэл зовж, хөлийг нь орон дээр гарган тавих санаатай аяархан барьж авлаа.

Евагийн хөлийн шагайд шавар наалдан хатсан байхыг хараад миний гайхсаныг яана. Энэ бол ухаан санаанд багтамгүй гэнэтийн явдал байсан учир миний хөл дороо хөшиж орхив, Эцэст нь би энэ ер бишийн нээлттэй уялдсан анхныхаа бодлыг /миний толгой бүр эргэж хоцорсон байв/ цэгцлээд Евагийн шагайд наалдсан шаврыг хумсаараа болгоомжтой авч алган дээрээ нухан үйрүүлэв. Ямар ч яриагүй ёстой шавар мөн байна.

Шал балай юм. Санамсаргүй тохиолдол биз гэж та хэлэх болов уу даа. Харин энэ нэгэн тохиол миний сэтгэлийг үймүүлж орхилоо. Олон жил хөдөлж чадахгүй байгаа энэ хөлд яахаараа шавар наалддаг байна. Сүүлчийн алхмаа хэдийд хийснийг Эзэн тэнгэр л мэдэх энэ хөөрхий хөлд шүү. Би зөн совиндоо хөтлөгдөн гутлыг нь эрэв. Ева дандаа үслэг зөөлөн сөөхий өмчдөг. Тэр нь орны ойролцоо байж байна. Би үзээд ул нь цэвэрхэн байгааг баттай мэдлээ.

Би юу бодохоо ч мэдэхгүй эргэж орхиод Элен дээр эргэн очлоо. Элөн амандаа дуу аялан цайгаа ууж байв. Бүсгүй дүү нь байхгүй ч гэсэн сэтгэл өег байгаа бололтой. Би нэгэн агшны төдий түүний гоо үзэсгэлэнд нүд дальдрав. Би Эленийг харах бүрдээ түүний гоо үзэсгэлэнгийн шинэ талыг нээж олдог, Одоо гэвэл хар хилэн туузаар боосон үс нь нарны гэрэлд гайхамшигтай гялалзан байгааг ажиглав.

Цаана чинь юу болж байна? гэж асуухад нь би суугаад

- Бөх унтаж байна. Сэрээж түвдсэнгүй гэсэнд

- Зөв л дөө гэв..

Бид олон үггүй цайллаа. Эленийг ширээний араас босох гэхэд би юу ч хэлэлгүй гарыг нь атгав. Элен өргүүр тийш айсан байдалтай хяламхийн харлаа. Элен бид хоёрын халуун дотно харилцааны ямар нэг шинж тэмдгийг дүү бүсгүйдээ мэдэгдэхээс үхтэлээ айдаг юм.

- Ева юунаас болж хөл нь мэдээгүй болсон юм хэлээч.

- Полиомиелитээс болсон... Арван гуравтайдаа.,.

- Эмчлүүлж анагаах арга бүхнийг туршиж үзсэн юм байгаа биз дээ?

- Бололцоотой бүх аргыг туршиж үзсэн гэж бодож байна. Аав тэгэхэд амьд байсан. Еваг Стокгольмд аваачиж гарамгай эмч мэргэжилтэн нарт үзүүлсэн... Үр дүнг нь өөрөө бэлхнээ харж байна...

Элений ярьсан зүйл миний дэмий балай сэжиг таамгийг замхруулав

-Хөөрхий амьтан! гэж би шүүрс алдлаа.. Би Эленийг өрөөний нь үүдэнд хүргэж өгөв. Өрөө гудмын цаад үзүүрт, эгч дүү хоёрын дундын халуун усны өрөөний хажууд байдаг. Би явахыг яарахгүй хүлээзнэв. Үүнийг Элен ажиглаад

- Надад юм хэлэх гээ юу, Виктор оо? гэв.

Би үүдийг нь өвдгөөрөө түлхэн өрөөнд нь орлоо. Би түүнтэй учрахыг аймаар их хүсэв. Би энэ хуурай дурлалаар цаашид тэсэж чадахаа байлаа! Би чинь энэ хүүхэнтэй учрахын баяр жаргалыг эдэлсэн хүн. Түүнийг мартахын аргагүй!

- Элен! Бид хоёр хэзээ нийлэх юм бэ? Энэ дэлгүүрээс болоод бид дан уран зураг, пянз, дотоод чимэглэлээс өөр юм ярихаа болилоо. Бидний сэтгэлийг хамгийн их догдлуулж байгаа зүйлийн тухай нэг ч үг дурсахаа болилоо... гэсэнд Элен орныхоо зах дээр сандайлаад

- Бид яарах юу байх вэ дээ, Виктор оо... Нэг зэрэг хоёр байшин барьж болохгүй шүү дээ... гэв.

- Чиний зөв... Гэхдээ...

- Бид ханилан суух тухай ярьдаггүй юм гэхэд дурлалынхаа тухай ярьж болно шүү дээ... -

Намайг хажуудаа суухад Элен тэвэрч, үнсэн таалж эхэлнэ гэж айсан юм шиг холдож суув. Би бүр тэвчээр барагдаж гүйцлээ! Тэгээд түүний өөдөөс анхааралтай ширтээд

- Чи надад хайргүй юм байна! гэж уулга алдах шахан өгүүлэв.

Элен хариу хэлэхийн оронд уруул дээрээ хуруугаа тавиад

Битгий ийм чанга ярь! гэв.

Элений зөв юм даа. Би дэндүү тэсгэл муутай хүн юм.

Гэнэт миний сэтгэл гунигтай болоод ирэв. Гунигтайгаар үл барам, энэ өдрүүдэд надад ямар нэгэн үл мэдэгдэх өвчин туссаныг өөрөө мэдээгүй өдий хүрэв бололтой. Энэ өвчин миний сэтгэлд гүнзгий орогнож, үүнээс болоод сэтгэл тайван биш байна уу?..

- Чи надад хайргүй юм байна! Ердөө цаг зуурын хүсэл тачаалд автаад одоо тийм юм болсныг харамсаж байх шив? гэсэнд Элен инээмсэглээд

- Битгий тэгж ярь, хонгор минь... Огт тийм биш шүү. Би бие, сэтгэлээрээ чинийх байхыг хүснэ! гэлээ

- Нээрээ юу?

Элен өөрөө уруулаа надад ойртуулан маш халуун дотноор чанга озон таалав. Би бол лав ингэж чадахгүй байх...

Одоо би эгч дүү Лекэний аварга том америк машиныг барьдаг болсон. Энэ тийм ч амаргүй ажил юм. Энэ бол бух тэрэг шиг лужир амьтан юм. Би урьд нь бага оврын хөнгөн тэрэг жолооддог байсан.

Би Амелия авгайн өдөр бүр индүүдэж өгдөг цэвэрхэн сайхан хөх цэнхэр костюмаа өмсөөд эгнүүлэн тарьсан моддын дундуур гарааш руу очиж явлаа, Саяхан Элөнтэй учраа ярилцсаны дараа миний бие хөнгөрөн сэтгэл цэлмэсэн болохоор гараашид очих зам зуур хөгжилтэйхөн исгэрч явлаа. Энэ тэнгисийн хөвөө нутаг гайхалтай сайхан юмаа!

Гэнэт миний хөлийн дор нэг юм хэвтэж байхыг ажиглан түүнийг авахаар тонгойв. Тэр бол арван сантиметрээс хэтрэхгүй жижигхэн ягаан тууз байлаа. Евагийн зүүдэг энэ туузыг би даруй танив. Бүсгүй оройдоо гэзгээ хоёр салаа сүлжиж, ийм туузаар боодог юм. Миний олсон тууз бол бол Евагийн үсээ боодог туузын нэг мөн байлаа.

Миний гайхсаныг хэлээд яах вэ. Ева хэзээ ч үүгээр үзэгддэггүй. Гарааш тийш хөтөлсөн таримал модтой зам түүний тэргэнцэр багтахааргүй нарийхан!

Туузыг зангидсан байв. Би эргүүлж тойруулан үзэж байгаад халаасандаа хийлээ! Мөн хачин аа?! Миний сэтгэл догдлоод ирлээ. Хөлийн нь шагай дээр шавар наалдаад хатсан байсан. Одоо бас нэг ийм хачин юм олов. Ямар гээч ад зэтгэрийн хорлол вэ? Энд бодох юм ч байна даа

"Вик чи өөрөөсөө дэндүү олон юм асууж, толгойгоо эргүүлж байна шүү, хөө. Чиний ингэж элдэв дэмий юм ургуулан боддог чинь чамайг муу юманд хүргэж болзошгүй. Болгоомжтой байж үзээрэй, хөө..." гэж би өөрөө өөртөө хэлэв.

Энэ бүх дэмий балай бодлыг толгойноооо үлдэн холдуулахыг хичээн машинд сууж, гараашаас гарлаа. Дараа нь машинаас бууж гараашийн хаалгыг хаагаад дахин жолооны ард суух үедээ машины дугуй, их биеийн хэсэг шавар болсон байхыг үзээд дахин мэл гайхав. Машиныг сайн угааж цэвэрлээрэй гэж цэцэрлэгчид өчигдөр хэлсэн шүү дээ. Түүнээс хойш энэ машинаар хэн ч яваагүй байгаа.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Өглөө нь дэлгүүрийн байрны бэлтгэл ажлыг хянах гээд энэ бүхнийг таг мартчихжээ. Өдөр хоол идэхээр ирээд урьдын адил барааны нэрсийн жагсаалт үзэж буй Еваг хараад саявтар сонин хачин юм нээж олсноо санан сэтгэл минь дахин догдолж эхэллээ. Энэ удаа Ева дотоод хашаанд ганцаараа байв. Дэвтэр дээрээ юм тэмдэглэж байснаа намайг ороход сая нүдээ өргөв. Би хацрыг нь илээд

- Өдрийн мэнд, алтан шаргал бялзуухай! гэв. Бид хоёр иймэрхүү элгэсэг дотно харилцаатай болсон юм.

- Элен бий юу?

- Эгч махтай бялуу хийх гээд гал тогоотойгоо ноцолдож байгаа. Сайн эзэгтэй гэдгийгээ одоо батлаад өгнө!

Би хөмсөг зангидав. Евагайн дууны өнгө нь нэг л биш. Цаанаа л нэг гуниг харамсалтай байх шиг дахиад өнөө тоглоомоо эхлэх гэж байна уу? За ямар ч гэсэн, би огт юм ажиглаагүй дүр үзүүлэв.

- Ева чи өнөө өглөө мөн сайхан унтаваа?! Өглөөний цайнд ирэхгүй болохоор чинь яасан юм бол гэж Элен бид хоёрын сэтгэл зовоод би үзэх гэж очсон юм. Очсон чинь сахиулсан тэнгэр шиг сайхан унтаж байлаа... гэсэнд Ева хөмсөг зангидан

- Өчигдөр орой эгчийг надад жаахан нойрны эм өгнө үү гэж гуйсан. Тунг нь арай ихдүүлсэн юм болвуу даа... Өнөөдөр толгой өвдөөд... Бас сэтгэл хачин байна... гэв.

Би пиджакаа сандлын түшлэгт өлгөөд усан сангийн захад суулаа.

- Та намайг юунд ингэтлээ харна вэ? гэж асуугаад дахин хөмсөг зангидав. Нээрээ их алжаасан царайтай байна. Бас муухай ааштай байх шиг.

- Танаас нэг юм асуумаар байна...

- Элдэв юм асууж шалгаахад яснаас дургүй

- Хүн юм асуухад дургүй байдаг юм уу?

- Албархаг юм асуухад дургүй.. Би юу гэж хариулахаа мэддэггүй юм.

- Өө гойдын юм биш. Өвдөж хөл чинь мэдээгүй болсноос хойш... эмчлүүлэх гэж оролдож үзээгүй юу л гэж асуух гэсэн юм.

- Ингээд гүйцээ юу?

- Тийм гэсэнд Ева дал мөрөө хавчаад

- Үзээд алдья гэдэг санаа миний толгойд ч байсан л даа гэв.

- Тэгээд үр дүн нь юу болсон бэ?

- Ямар ч үр дүнгүй! Би элс чихсэн шуудай шиг хөдөлж чадахгүй байна. Үүнийг харваас ил биш үү

- Дахиад нэг оролдоод үзвэл яасан юм бэ?

- Ямар үхсэнээ хийх юм бэ? Уучлаарай...

Ева одоо бүр хилэгнэсэн байдалтай байх агаад ямар ч байсан өрөөл татанхай зовлонт хүн хэвээр байж, үүнийгээ бусдад мэдүүлж байх гэсэн эрс шийдэмгий байдал нүдний нь харцад ил.

- Би эмч биш, гэхдээ...

- Тоогүй дээ

- Бүү тохуурх!.. Би эмч биш болохоор эмнэлгийн асуудал дээр маш энгийн санаа бодолтой байдаг. Хүнд нэгэнт хоёр хөл байж байгаагаас хойш явж чадах ёстой гэсэнн туйлын эгэл бүдүүлэг үзэл баримталдаг юм. Ева танд нэгэнт хоёр хөл байгаа болохоор та энэ хоёр хөлөө өөрийнхөө тусын тулд ашиглаж чадах ёстой.

- Таны энэ үзэл бодол чинь бүдүүлгээр барахгүй тэнэг санаа байна.

- Би бат итгэсэн зүйлээ ярьж байна.

- Мйний оронд бол таны ямар байхыг үзэхсэн! Ядахдаа ганц хоёр минут ч гэсэн! Ви таны бодож байгаа шиг тийм муухай хорон санаатай хүн биш шүү!

- Би тийм юм огт бодоогүй!

Ева хи-хи-хи хэмээн инээд алдав. Ямар учиртай тэгснийг бүү мэд.

- Би нэг юм хэлье...

- Бас юу вэ?

- Би чадал тэнхээ сайтай эр шүү, Та мэдэх үү?

- Сайн л биз. Тэгээд юу гэж?

- Таныг хоёр хөл дээрээ зогсоход тусалмаар байна. Та хөлөө хөдөлгөх гэж оролдоод үз. Би харж байя...

Харах юм байхгүй, Вик ээ. Энэ хоёр хөл чинь ерөөсөө хөл биш. Ердөө дайвар төдий. Ямар ч

хэрэггүй дайвар.

- Маргалдаад байхын оронд туршаад үзье л дээ, Миний хүссэнийг битгий татгалзаач... Ева хэсэгхэн зуур эргэлзэв. Би шахаж шаардсангүй. Эцэст нь Ева толгой дохиод

-За яах вэ, таны сэтгэлийг хангахын тулд... Би Еваг тэврэн тэргэнцэрээс нь буулгахыг оролдоход чийрэг мээм нь цээжинд тулахыг мэдэрч, сэтгэл минь ихэд догдлов.

Би мөн ч хэцүүхэн зорилт тавьжээ! Бүсгүйн хоёр хөлийг уртааш нь сунгаж, өсгий нь шал дээр тулсан байхуйцаар хөвчин биеийг нь цэх шулуун барьж байх гэж аль байдаг чадлаараа оролдов. Усан сангийн усанд тольдсон дүрсээ харлаа. Ямар аймшигтай толь вэ? Евагийн хөл нь огт амьгүй, хөвөн чихсэн уут шиг сул санжигнаж байх юм.

- Нэг хөлөө урагш нь тавихыг оролдоод үзээч гэж гуйв.

Нэмэр алга. Миний цөхрөнгөө барах бүр туйлдаа хүрэв.

- Чадахгүй байна! гэж Ева уйлах шахан өгүүлэв

- Оролдоод үз л дээ гэж би дахин дахин гуйлаа!

- Болохгүй байна Вик ээ... Би хөлгүй хүн шүү дээ, Вик ээ. Энэ чинь миний хөл биш! Гуянаас доош ямар ч мэдээ байхгүй!

Ева хөлсөө асгаруулан уйлав, Гэнэт

- Ай Тэнгэр, та юу хийж байгаа хүн бэ?! Гэх Элений хүйтэн хөндий дуу сонсодлоо.

Усан санд Элөний дүрс тольдсоныг хараад эргэн харвал дотоод хашааны үүдэнд айсандаа нүд нь бүлтийн эогсож байв. Би Еваг тэргэнцэрт нь аваачиж суулгалаа. Евагийн явж чаддаггүйг би одоо лавтай мэдэв. Миний өөрөө зохиосон энэ аймшигт жүжгийн дараа үүнийг мэдэхэд хялбар байлаа. Элен бол намайг бүр солиотой амьтан гэсэн байдалтай харж

-Харав уу даа, Виктор оо! гэв.

Элений энэ үгэнд хорвоогийн бүх зэмлэл багтсан санагдав.

- Уучлаарай, Ева... Би... би мал шиг тэнэг хүн юмаа. Уг нь сайн санасандаа л ингэсэн юм. Та намайг ойлгож байна уу? гэсэнд Ева нүүрээ хоёр гараар даран уйлж эхэллээ.

Би сандлын түшлэгт өлгөсөн пиджакаа аваад Эленийг намайг дагаад явна уу гэсэн дохио өгөв. Бид үүдний танхимд хүрч ирэв. Шилэн хаалгаар Евагийн эхэр татан уйлж байгаа харагдлаа. Би өөрийгөө жанчиж чаддагсан бол нэвширтэл жанчихсан.

- Виктор та яах гэж ийм инээдэмт жүжиг тоглов оо? гэж Элений асуухад би нүдээ буулган доош хараад

- Нээрээ солиотой бодол юм. Дүү бүсгүйг чинь явж чадна гэсэн бодол миний толгойд бат оржээ.

Тэгээд би Евагийн хөлд, машины дугуй, их биеийн доод хэсэгт шавар наалдсан байсан, гараашийн хажуугаас ягаан тууз олсон зэрэг өөрийн сонин хачин нээлтийн тухай Эленд бүгдийг ярив...

- Энэ бүхэн Элен танд нэг юм бодуулахгүй байна уу?

- Байзаарай, Виктор оо. Тайван байгтун, Энэний учрыг олж болох юм... Машины тухайд гэвэл цэцэрлэгч өмнөд нутгийнхны нэгэн адил аймаар залхуу хүн. Тууз уу? Ева унагасан байх. Урьд шөнө их ширүүн салхитай байсан. Тууз нь таны олсон тэр газар хийсээд очсон биз...

- Тийм болог.. Шагайд нь шавар наалдсан байсныг яах вэ?

- Байз, байз... Ева Амелияд туслах дуртай... Өчигдөр оройн хоолонд испан хависхана гэдэг ногоо байсныг санаж байгаа биз. Хависхана шиг шавар шороо ихгэй ногоо байдаггүй.... Тэгээд шавар нь дүүгийн хөлд наалдсан байх. Хөл нь мэдээгүй болохоор шавар наалдсаныг анзааараагүй өнгөрсөн биз... Харж байгаа биз дээ, учрыг олж ядах юм алга.

Миний эргэлзээ тасрав. Миний таамаглал үнэндээ солиотой хүний бодол байж. Жинхэнэ хэрэг дээрээ учрыг тайлбарлаж бүрэн болох байлаа.

- Таны хэлсэн зөв байх...

- Виктор та юу бодох нь энэ вэ? Еваг нууцаар явж чаддаг, шөнө машины жолоо барьдаг гэж бодов уу? гэхэд нь би буруугаа хүлээн инээмсэглэж, ичсэндээ нүүр халуу оргив. Элөн үргэлжлүүлэн

-Ээ өвгөн минь, энэ яагаад ч болшгүй хэрэг! Таны дэмий оролдлого юу болж дууссаныг та өөрөө үзлээ шүү дээ.

- Нээрээ тийм. Намайг ингэж тэнэглэснийг Ева уучлах болов уу?

-Уучлана. Ер нь жаахан гомдсон байх... Ийм зовлонт байдалд орсондоо яаж шуу гуньж гутардгийг нь та мэддэг ч болоосой! Энэ тухай ярихад их дургүй байдаг...

-Бид ч гэсэн энэ тухай дахин ярихаа больё, Элен.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Шөнө би бараг цурам хийсэнгүй. Сэтгэл мэдрэл минь туйлдаа хүртөл хөвчрөөд байшингийн нам гүмийг чагнан байлаа. Ийм том байшинд чив чимээгүй байх гэж үгүй. Энд нэг юм шажигнаж, цаана нэг юм түжигнэн, өөр нэг газар юм шүрчигнэх шиг болно. Тэгснээ үхээрийн газрын буг чөтгөрийн чимээ юу гэмээр жигтэй хачин чимээ авиа гарна... Сэтгэл мэдрэл хөвчрөөд унтаж чадахгүй байх үед ийм чимээ авиа шиг аймшигтай юм байхгүй...

Би зуунтаа босож, цонхны дэргэд нэг очиж, дутуу ойлгосон хаалганы дэргэд нэг очиж үзэв.. Гудмаар хүн яваад ч байх шиг элдвийн хий юм сонсдоод... Шалгаж үзээд эндүүрснээ мэдэж байлаа. Энэ байшинд хаанаас гарч байгааг нь өчүүхэн ч эргэлзэх зүйлгүй нэг л чимээ сонсдож байгаа нь дээр унтаж буй Амелия авгайн хурхирах чимээ.

Би үүрээр сая нэг юм унтав. Энэ удаа би өглөөний цайнд очсонгүй.

Хэд хоног өнгөрлөө, Дэлгүүр байгуулах ажилд сэтгэл тавьж хөөцөлдсөөр гайхалтай бүх сэжиг таамаглалаа мартагнажээ. "Мөрөөдлийн кайрцаг" дэлгүүр аажмаар амиллан бидний анх бодож сэдсэнтэй улам бүр адил болж байлаа. Энэ дэлгүүр бүх талаар ер бишийн тэмдэглэлтэй орчин үеийн тансаг сайхан газар болно гэдэгт би эргэлзэхээ болив. Товчоор хэлэхэд энэ нутгийнхныг шуугиулах үйл явдал болох төлөвтэй.

Энэ нэгэн ажлыг бүтээхэд бид арван найман сая орчим франк зарцуулсан болов уу. Гэвч зарцуулсан өртгөө хувь нугалан олж чадах нь лав. Элен, Ева бид гурвын хэн хэн нь ажил төрлийн сонирхолд бүрмөсөн татагдаад сэтгэл их хөөрөн байв.

Еваг яаж гуйгаад ч надтай хамт ажлын байр очиж үзэхийг зөвшөөрөхгүй байсан учир би түүнд үйл явцыг төсөөлж болохуйц гэрэл зураг авчирч үзүүлдэг байлаа. Зарим зүйлийг Евагийн бодож сэдсэний дагуу хийсэн юм.

Ева гэрэл зургийг удтал анхааралтай үзэж, би анзааралгүй орхисон жижиг нарийн зүйлийг анхааран саналаа хэлдэг байв...

Тэр шөнө би нэг хачин зүүд зүүдлэв. Салхи сэм онгойж миний онгорхой цонхны торон сүлжмэл хөшиг дэрвэн байснаа хүн дүрстэй болоод ирлээ. Уг дүрс анх бүдэг балархай байснаа төдөлгүй Элений дүр тодроод ирэв.

Миний хамаг биеийн хүйтэн хөлс дааварлан намайг нэг хүн дуудаж байгааг даруй ойлголоо. Миний орны дэргэд үхсэн хүнийх шиг зэвхий цагаан царайтай Элен зогсож байв.

- Юу болоо вэ? гэж би уулга алдан асуулаа!

Миний өмнө лаван баримал шиг хөдлөхгүй байгаа хүний төрхийг харваас нэг сүйдтэй юм болсон нь илт

- Виктор оо. Нэг... аймаар юм болоод байна гэж Элен амандаа бөвтнөв

Айсандаа арай гэж голтой байх шиг. Элен тонгойн орны хөл түшиж, амьсгаагаа дарахыг

хичээв. Би яахаа мэдэхгүй хэвтэж байлаа...

- Ева... гэж Элений эхлэн дуугарахад хүн юуны өмнө муу юм боддог зангаар Ева амиа хорлосон юм болов уу гэж нэг бодов.

Энэ гэнэтийн таамаглал миний цээжийг сүлбэх шиг болов. Гэсэн ч би энэ таамаглалаа ил гаргаж хэлсэнгүй.

- Ева өвдөө юу?. гэж би сэтгэлээ тогтоож ядан асуулаа.

- Алга болчихжээ,.. гэхэд нь би хөнжлөө хуу татан өндийгөөд

- Элен та юу хэлнэ вэ? Алга болчихож ий? Тоглож байна уу? гэсэнд

- Үгүй, хаанаас!.. Өөрөө очоод үз гэв. Евагийн өрөө рүү ухасхийн орж харвал өрөө нь хоосон байлаа.

Орны хөнжил дэлгээстэй, тэргэнцэр дээр цагаан баавгайн арьс тавиастай... Миний нуруу руу хүйт оргиод явчив. Ялангуяа харанхуйн дунд өнчирч үлдсэн юм шиг тэр эзэнгүй тэргэнцэрийг харахад аймшигтай байлаа. Миний хойноос орж ирсэн Эленд хандан

- Ухаанд багташгүй юм! гэсэнд Элен дал мөрөө хавчив,

- Алга болсныг нь хэдийд мэдэв?

Элен өөрийн хэлэх хариу нь байдлыг өөрчилж болох юм шиг, юу хэлэхээ хэсэг бодолхийлэв.

- За ийм... Сүүлийн хэдэн жил миний нойр их сэргэг болсон... Ева дандаа л намайг дуудаад байх шиг санагддаг... Евагийн хөл татсаны дараа эхний үед намайг шөнөдөө гурав дөрвөн удаа дууддаг байлаа. Одоо ч тэгж дуудахаа байсан. Юу ч болж байсан өөрөө аргалж чаддаг болсон юм. Гэсэн ч миний тусламж хэрэг болж магадгүй гэсэн бодол толгойноос гардаггүй... ойлгож байна уу?

- Цааш нь ярина уу...

- Өнөө шөнө юунаас болсныг бүү мэд гэнэт сэрээд.. Чимээ гарсан юм уу, эсвэл дотоод ухамсраас болсон юм уу... Хэсэг хүлээгээд сэтгэлийн түгшүүр намддаггүй. Тэгэхэд нь босоод... очиж үзье гээд... наашаа ирсэн чинь...

Элений дуу нь огт өөр хүнийх шиг тавигдахгүй болжээ. Дотоод сэтгэлийн нь дуу юм болов уу даа...

Элен! Таны царай царай биш байна. Нэгюм уугаач...

Элен дан шөнийн цамцтай зогсож байгаагаа сая мэдэв бололтой.

- Хувцсаа өмсчих...

Элен толгой дохиж өрөөндөө орж, гэрийн дээлээ өмсөв. Тэр завсар би доош буув. Доод өрөөнүүдэд ч дотоод хашаанд ч Ева алга. Гадаах хаалга түгжээгүй байгааг ажиглалаа.

Элөн хөлөө дааж ядах мэт шатны гишгүүр бүрд саатан доош бууж ирэв. Би үүдний танхим дах эрэгнэгийн дэргэд очиж, хундага дүүрэн шарз хийгээд өгсөнд нэг ч үг дуугаралгүй авч уулаа. Уг нь архийг үзэж чаддаггүй юм. Зэвхий цагаан хацар нь даруй ягаараад ирлээ.

- Суугтүн, Элен. Сэтгэл тайван байж учрыг тунгаах хэрэгтэй байна.

Элен миний үгийг дуулгавартай дагаж, юу хий гэснийг хийж байв. Бүхий л байдлаас үзэхэд зориг нь мохсон бололтой.

- Ингэхлээр би тэр нэгэн удаа эндүүрээгүй юм байна. Дүү бүсгүй чинь явж чаддаг юм байна! гэсэнд

- Тийм байх ёсгүй шүү дээ, Виктор оо!.. Тийм байх ёсгүй. Үүнийг танд ямар ч эмч хэлээд өгнө гэв.

- Тэгвэл яасан байх вэ? Хулгайлсан байх уу| бодоод үзээрэй Элен. Манайх ямар Америк биш, Америкт бол хүн хулгайлах явдал алхам тутамд тохиолддог гэнэ лээ. Бид тэнд амьдран суудаг байлаа ч манай Еваг хулгайлах бодол хэний толгойд орох вэ

Коньяк уусных уу, миний үгийг үнэмшиж итгэсэн үү, Элений сэтгэл жаал тайвширч, биеэ барилаа.

- Виктор та манайд хэдэн долоо хоног байх зуур Еваг мэдэх болсон. Тэр ч байтугай та явуулж сургах гэж оролдоод үзэж байсан. Явах байтугай, хөл дээрээ цэх зогсож чадахгүй гэдпийг та сайн мэдэж байгаа

- Өдөр тутмын бодит байдал хичнээн тодорхой шиг санагдлаа ч нүд хууртах хэрэггүй. Ева тэргэнцэртээ суугаад явж чадахгүй гэж бидэнд батлан хэлдэг. Үүнийг нь бид ямар ч хөдөлбөргүй үнэн гэж хүлээн зөвшөөрч байна. Яагаад тэр вэ гэвэл цаг үеийн нөхцөл байдал, учир шалтгааны зүй, аль аль нь Евагийн хэлснийг нотолж байх шиг. Гэтэл Ева тэргэнцэр хэрэглэхгүйгээр өрөөнөөсөө гараад явах чадвартайг бид бэлхнээ нүдээрэй үзэж байгаа болохоор одоогийн энэ нөхцөл байдал, учир шалтгааны зүй аль аль нь түрүүчийн бат итгэлтэй зөрчилдөж байна шүү дээ.

Элен миний учирлан хэлснийг хүлээж авья гэж хичээж байгаа мэт боловч цаанаа зөвшөөрөхгүй байх шиг.

- Энд өөр нэг учир байх ёстой доо, Виктор оо...

- Чухам юу вэ? Таамаг төдий ч болтугай нэг юм хэлээд өгөөч. Би үгийг чинь сонсоё.

- Мэдэхгүй байна...

- За тэр дээ!

- Евагийн явж чаддаггүйг би баттай мэдэж байна. Энэ талаар надад өчүүхэн ч эргэлзэх зүйл алга. За яах вэ, Ева гэнэт явж чаддаг боллоо гэж бодьё. Тэгвэл түүнийгээ нууж, тахир дутуу хүн болж баашлахын хэрэг юу вэ? Энэ нууцыг ганц өөртөө хадгалж байх гэж тэгэх юм уу? Та бодоод үзээч...

Миний толгойд өөр нэг санаа төрж, гараа инчдээд

- Би учрыг таамаглах юм шиг байна Элен!.. гэв.

Элений нүд гялалзах нь харанхуйд хүртэл мэдэгдлээ. Сайн харвал миний дүрс хоёр жижиг толинд туссан мэг зэгдэх болов уу гэж бодов.

Элен та дотоод ухамсрын тухай саявтар ярьж байсан...

- Тэгээд юу гэж?

- Евагийн дотоод ухамсар нь өвчнөөсөө хүчтэй байжээ гэж бодогтун. Ева нойрон дундаа явж үзэхийг туйлын их хүсдэг байлаа гэж бодогтун. Тэгээд дотоод ухамсрын хүсэл зориг нь түүнд хүч өгдөг байвал яах вэ? гэсэнд Элен толгой сэгсэрсэн ч эрхбиш жаахан эргэлзэж байгаа бололтой

- Хн. Энэ чинь хоосон санаанаас зохиосон зүйл шиг санагдахгүй байна уу? гэв.

- Хоосон санаанаас зохиосон ч байж, хүн үнэмшиж болохоор санаа юм. Энэ таамаглал Евагийн ухамсрыг хөндөхгүй. Юу вэ гэвэл явж чаддагийгаа мэддэг мөртлөө дуугүй байгаа бол үүнийг юу гэж хэлэх вэ? Танд үг байна уу? гэсэнд Элен өндийж

- Түүнийг олох хэрэгтэй байна, Виктер оо. Миний сэтгэл зовоод болдоггүй... Явж чаддаг байлаа ч гэсэн чиг баримжаагаа яаж олох вэ? Энэ байшингаас гарч үзээгүй хүн шүү дээ...

- Гарч үзээгүй гэж үү? Би бол Еваг эндээс гарч үзсэн гэж танд хэлэх байна!

Би тэр нэгэн шөнө машин дотор солиотой хүүхэн лүгээ учирсан адал явдлаа нэхэн санав... Ай Эзэн тэнгэр! Энэ бүхнийг яаж авцалдуулах вэ?

-Таны юу бодож байгааг мэдэж байна гэж Элен шивэгнээд намайг анхааралтай ширтэв.

- Элен та үүнийг мэддэггүй байсан ч болоосой. Энэ дэлхий дээр бодохоос нүд харанхуйлж, ухааш балартмаар юм байдаг байна..

- Одоо тэгээд яах вэ?

- Хувцсаа өмсөөд явж эрцгээе. Та байшингийн ойр хавиар эр. Би гараашид орж, дараа нь явж болох бүх газраар явж үзье...

- За тэгье... Амелияг сэрээх үү?

Одоохондоо хэрэггүй. Эмгэний үглэх янших бидэнд юун нэмэр болох вэ дээ

Би өмд, ноосон цамц, гутлаа өмсөөд хашаанд гарч ирлээ. Бороо орох гэж байгаа бололтой, сарыг үүл халхлаад тас харанхуй. Агаарт чийг үнэртэж байна.

Би гараашид гүйж очив. Машин байрандаа байхыг үзээд миний дотор онгойж санаа алдлаа. Дараа нь хашааны хаалганы тэнд очиж үзэхэд яагаад ч юм түгжээгүй байв.

Би уулын бэлээр солиотой юм шиг ийш тийш гүйлээ. Еваг хаанаас эрэхийгээ мэдэхгүй юм... Юмны учир зүйгээр бол яагаад ч явж чадах ёсгүй хорин настай бүсгүйг ийм падан харанхуй шөнө эрнэ гэдэг тийм амар ажил биш ээ дээ?..

Модны хоорондуур гүйж явахдаа тэр нэгэн шөнийн шулмасыг үргэлж бодсоор байлаа... Ухаан санаагаа дайчлан тэр хүүхний биеийн дүрсийг Евагийн дүрстэй жишиж үзээд аажмаар Еваг тэр адал балмад хүүхэнтэй төсөөтэй юм байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Миний бодол намайг мөн ч хэцүү юм руу хөтлөн аваачиж байна даа...

Би хашааны хаалгаар гүйн гарч, ойр хавийн гудамжаар бүтэн цаг шахуу гүйн

- Ева!.. Ева... Ева!.. гэж дуудаж байв.

Нэг сүүдэр харагдах юм уу өчүүхэн чимээ сонсогдоход хашгиран дуудаж байв... Хашгирсаар байгаад хоолой минь сөөж эхэллээ.

Эрж эрж, тэнхээ алдарч, сэтгэл гутран гэртээ эргэж ирлээ. Бүх цонх гэрэлтэй байна. Үүдний танхимд орж д Эленийг дуудсанд хариу сонсогдсонгүй. Дүү бүсгүйгээ эрсээр байгаа юм болов уу? Би хоёрдугаар давхарт гарч, Евагийн өрөө рүү шагайгаад гайхсандаа бүр хараал тавилаа. Ева орон дээрээ бөх гээч унтаж байх юм. Би хоёр харайгаад орны нь дэргэд хүрч, хөнжлийг хуу татаж хаяад хөлийг нь харвал шагай нь шүүдэрт норж, нойтон хэвээр байв.

- Ева! гэж хашгиран дуудсанд бүр хөдөлсөнгүй. Би мөрнеөс нь барьж аваад сэгсчин

-Ева! Инээдэмт жүжиг тоглохоо болигтун! гэсэнд тэр амандаа ямар нэг юм бөвтнөөд нүдээ арайхийн нээв. Гэхдээ намайг онож харахгүй байх шиг. Ямар ч гэсэн намайг танихгүй байгаа бололтой.

- Ева, сэрээч! гэсэнд ямар ч хариу байдаггүй. Би халуун усны өрөөнд гүйн орж, хүйтэн усанд алчуур норгон нүүрэн дээр нь тавьсанд Ева ашгүй нэг юм сэрлээ.

- Ева! Та миний үгийг сонсож байна уу?

- Сонсож байна, Вик ээ...

- Юу болсныг мэдэж байна уу? гэсэнд Ева хөмсөг зангидан

- Байзаарай... Миний толгой ангалзаад байна... Модон дотуур зугаалж явна гэж зүүдлээд,..

Энэ бүсгүйн үнэн, худал хэлж буйн алин болохыг би ялгаж мэдэхээ байлаа.

- Зүүдэлсэн гэв үү?

- Тийм л дээ... Даараад байсан... Бас их муу байсан. Муухай... гээд найтаав.

Та даараад салхинд цохиулаа юу? гэж би ёжлон асуув.

- Вик та юу болов оо?

- Намайг тэнэг гэж боддог хүнтэй би дандаа ийм маягаар ярьдаг юм. Хэдий болтол ингэх юм бэ, Ева?

- Юу гэнээ?

- Та явж чаддаг юм байна... Өнөө шөнө босож явжээ. Сайхан хэрэг ээ! Би таныг хоёрдахь удаагаа хэргийн газар дээр барилаа. Намайг саяхан эгчтэй чинь энэ өрөөнд орж ирэхэд та байхгүй байсан. Та байхгүй байсан шүү! Ева айсандаа ам нь ангайж, нүд нь бүлтийв.

-Вик та юу хэлнэ вэ?!

- Үнэн хэлж байна, Та өрөөндөө байгаагүй. Тэргэнцэргүй бол хөдөлж чаддаггүй гээд байсан атал тэргэнцэр чинь эндээ байж байсан. Элен бид хоёр галзуурах шахаж, таныг газар сайгүй эрж, байшинг тойрон ,гадаа гудамж талбайгаар явж үзсэн. Тэр хооронд та эргээд амар тайван хүрээд ирсэн байж! Бид элдвийн муу юм бодож толгойгоо эргүүлж байлаа. Тэгэхэд та хүнд мэдэгдэлгүй сэмхэн эргээд ирсэн байна!

Еваг чанга уулга алдахад миний ар нуруу руу хүйт оргиод ирлээ.

- Худалч! Ичих нүүргүй муухай худалч! Та нар намайг солиотой хүн болгож үзүүлэх гэж байгаа биз. Тийм байна! Элен та хоёр намайг галзуугийн эмнэлэгт явуулаад манай эд хөрөнгөн дээр эзэн суух гэж байгаа юм байна.

Би хоёр чихээ таглав.

- Тэгвэл Элен бид хоёр солиотой болж таарах нь ээ. Миний саяын ярьсныг эгч чинь батална! Таны өрөө эзгүй байгааг эгч чинь түрүүлж мэдээд надад хэлсэн шүү.

Энэ сүүлчийн үг Еваг мухардуулав бололтой.

- Тэгвэл... эгч мэдсэн юм уу?

- Яг тийм!

Ева нүдээ анив. Царай нь тэр нэгэн өдөр бид хоёр үнсэлцэх үед үнсэн саарал өнгөтэй болсон шигээ тийм өнгөтэй болов.

- Вик ээ, би айгаад байна... Энэ Элен эгч..

- Элен юу гэж?

- Энэ Элен эгч л намайг солиотой хүн болгож үзүүлэх гээд байх шиг... Намайг сэрж чадахгүй болтол зөндөө их нойрны эм өгөөд дараа нь намайг байшингаас авч гарсан байх.., Тийм, тийм... Нойрон дунд нэг хүн нуруугаар минь чирж яваа юм шиг санагдаж байсан...

Ева одоо ховсдуулсан юм шиг байлаа.

- Ээ Ева! Эгчдээ ингэж хар буруу санаж болохгүй! Энэ чинь муухай хэрэг... Би таныг жигшин зэвүүцэнэ. Ева босох гэж байгаа юм шиг өндийв... Их огцом хөдөлсөн учир золтой л орноосоо ойчсонгүй.

- Хэдий тийм боловч болсон бүх явдлаас уламжлаад гарч ирэх учир шалтгааны зүйн дүгнэлт ганц ийм байна. Тийм шүү, Вик ээ!

Тэгтэл миний ард нэг хүн байгааг мэдэрч эргэн харвал Элен байлаа. Хөл нь шалбарч, үсэнд нь гацуурын шилмүүс наалдан платье нь урагджээ. Зөндөө гүйж харайгаад амьсгаа нь давхцсаных ч юм уу, эсвэл дүү бүсгүйнхээ булай муухай зэмлэлийг сонсоод тэгсэн юм уу зүрхэн тушаагаа гараа тавьжээ. Элен Еваг удаан ширтэв. Ева нүдээ буулган доош харлаа. Элен гарч, өөрийн өрөөний үүдийг тасхийтэл савах сонсодлоо. Миний амьсгаа дээр гаран

- Ева! Та сая юу хэлснээ мэдэж байна уу? гэсэнд бүсгүй толгой сэгсрэн

- Вик ээ, би мэдэхгүй! Надад мэдэх юм алга, Вик ээ!.. би... би нээрээ жаахан солиотой байх аа... гэв.

- Би нэг л юм мэдэж байна гэсэнд Ева толгойгоо өргөн миний өөдөөс ширтэв.

- Таны явж чаддагийг мэдэж байна! Бас та бол миний энэ насандаа үзсэн хамгийн бузар муухай банзал гэдгийг мэдэж байна!

Пөө-өөх! гэж Ева чанга ёйлогнон уруулаа цорвойлгож нүдээ бүлтийлгэн ав хоморгонд орсон араатан мэт байлаа.

Энэ бүсгүй одоо яаж маягласан ч хожимджээ. Би үүнд итгэхгүй... Би биеэ эзэмдэж чадахгүй боллоо. Хөнжлийг нь хуу татаж хаясанд Ева айсандаа нүд нь бүлтэлзэн бие нь чичрэн салганаж байв.

- Та явж чаддаг! Одоохон босоод явж чаддагийаа үзүүлээд аль, муу банзал! гэж би архирав.

Евагийн царайд сахиулсан тэнгэрийн төрхтэй юм юу ч үгүй болж, аймаар муухай болжээ. Би дэлбэртлээ уурлан бүсгүйн гараас шүүрч аваад орноос нь хэвх татан буулгаж урагш хүчтэй түлхэв. Зүрх минь цээжиндээ багтаж ядан оволзож, яахыг хүлээж байлаа. Ева шал дээр унахдаа тэргэнцэрийнхээ дугуйг толгойгоороо мөргөж, муухай чарлан өндийж суух гээд чадсангүй. Би дэргэд нь очиж, дээш нь өргөн цэх болгоод дахин тавьсанд хяргуулсан юм шиг

хөлд минь сулдайн унав.

Үүнийг үзэж байж л миний сэтгэл сая амарлаа. Еваг орон дээр нь аваачиж тавиад

- Ева! Хэрэв би санамсаргүй тохиолоор эндүүрсэн бол ийм юм хийсэн өөрийгөө хэээээ ч уучлахгүй гээд бүсгүйн зүг нэг харж, даруй гарч одлоо.

АРАВДУГААР БҮЛЭГ

Би Элен дээр оров. Уйлан хайлж байгаа болов уу гэсэн чинь туйлын тайван байхыг нь хараад ихэд гайхлаа. Элен зөөлөн сандалд хөлөө ачиж эрүүгээ тулан суужээ. Би орон дээр нь суув. Одоо ч гэсэн би түүний үзэсгэлэнг бахдан харлаа. Платье нь урагдаж, хөл нь зөндөө шалбарсан ч гэсэн Элен биеэ гайхмаар эзэмдэн тайвширсан байв.

- За тэгээд энэ бүхний тухай та юу хэлмээр байна даа? гэсэнд Элен өрөвдөлтэйхөн инээмсэглээд

- Ийм байна, Виктор оо,.. Энэ хүнтэй олон жил нэг гэрт сууж, хамаг анхаарал халамжаа энэ хүнд төвлөрүүлж, насныхаа хамгийн сайхан үеийг энэ хүнд зориулсан... Тэгсэн чинь энэ хүн миний ингэж биеэ зольсны ачийг санах байтугай, харин ч... үзэн яддаг юм байна! гэв.

Энэ хүүхний ингэж цөхрөнгөө барж байгааг харахаар өрөвдмөөр! Би аргадан тайтгаруулахыг оролдож

- Элен... гэсэнд

- Өө зүгээр, Виктор оо... олон үгээр яах вэ

- Ева уурын мунхагаар тэгж хэлсэн биз... Урхинд орчихоод мултрах арга олж ядахдаа...

- Цээжиндээ хадгалж явсан үгээ хэлсэн хэрэг. намайг үзэн яддаг юм байна. Таныг булааж авсныг минь Ева хэзээ ч уучлахгүй гэдгийг би мэдэж байсан гэхэд нь би түүний үгийг тасалж

- Байзаарай... Евагийн шөнө явдгийн тухайд миний таамаглал зөв юм шиг байна... Гэхдээ юу болж байгааг өөрөө ухаардаггүй бололтой.. Эсвэл... гэсэнд

Элен - Эсвэл юу гэж?

- Эсвэл энэ дэлхий дээр урьд хожид үзэгдээгүй туйлын арга бачтай бааштай хүүхэн байх... гэсэнд Элен санаа алдаад

- Энэ асуултад хэн хариу өгөх юм бэ? гэв.

- Эрт, орой нэгэн цагт бид хариуг нь олж болно. Ева нойрны эм гэж юу хэлэв?

- Эмчилж байгаа эмч нь бичиж өгсөн юм.

Ямар нөлөөтэй юм бэ?

-Тунгийн их, багаас болно. Зүрх нь хөөрсөн үед арван дуслыг өгдөг... Ийм хэмжээний эм өгөхөд нойрсуулахаасаа илүү тайвшруулах нөлөөтэй байдаг...

-Өчигдөр орой эм уусан уу?

-Үгүй... Энэ чинь Евагийн худал хэлснийг давхар батлаж байна! Виктор та ойлгож байна уу? Өчигдөр орой эм өгөөгүйг минь Ева сайн мэдэж байсан шүү дээ!

- За тийм байж, Элен. Одоо унтацгаая. Маргааш энэ бүхний учрыг олох гэж оролдоод үэье...

- Миний хувьд бол юм бүхэн тодорхой байна. Би Евад муу санахгүйг хичээдэг байсан. Гэтэл өөрөө намайг аргагүй байдалд оруулаа...

- Эмчтэй зөвлөх хэрэгтэй байна.

- Эмчийг нааш нь авчрахаас өмнө Виктор та очиж бүх байдлыг яриад санал зөвлөлгөөг нь асууж мэдвэл зүгээр.

- Би маргааш эмчтэй уулья,

Би Эленийг түшин сандлаас босгож, дараа нь бие рүүгээ татан тэвэрсэнд мөрөн дээр минь толгойгоо тавилаа. Үсэнд нь наалдсан гацуурын шилмүүс хүзүүг минь хатгаж байгааг мэдрэв...

Маргааш нь би Эленд амалсан ёсоор Канны орж, Лекэний гэр бүлийн, эмчтэй уулзав. Эмчийг үзлэгт явчихаас нь өмнө амжиж очих гэж өглөө эртлэн гарав.

Доктор боомтын ойролцоо, харьцангуй нам гүм гудамжинд суудаг юм байна. Намайг гэрийн дээлтэй хүлээн авав. Тэр бол хүн эмчлэх, ийш тийшээ үзлэгт явах гэж байхын оронд бөмбөлөг тоглож (ийм тоглоом энд их дэлгэрчээ) байвал таарах нилээд насжсан өвгөн хүн байв. Их яриа хөөрөөтэй, эелдэг хүн юм. Буурал ямаан сахалтай, инээмсэглэсэн нүдтэй, цүдгэр гэдэстэй, чац богинохон, ер нь л харваас инээд хүрмээр өвгөн юм.

- Та доктор Буссик үү? гэж асуув.

- Танд хүчин зүтгэе.

- Намайг Виктор Менда гэдэг... Мадемуазель Элеи Лекэний болзоот хархүү.

- Оо-ёо! Хараач Хөөе... Тэр хүүхний нөхөрт гарах гэж байгааг мэдээгүй шүү гэхэд нь би инээмсэглэж

- Нэг сарын өмнө үүнийг би өөрөө ч мэдээгүй байсан юм гэсэнд миний наргиа үг түүний санаанд таарсан бололтой, тас тас хөхөрч

- Та тэгээд гэрлэхийн өмнө үзүүлэх гэж ирээгүй юм байгаа биз дээ? гэв.

- Арай үгүй.

- Арай гэдэг нь юу гэсэн үг вэ? Таны бие эрүүл мэнд тийм сайн биш байгаа юм уу? гэж өвгөн гайхав.

Огт өөр хэргээр ирлээ,

Өвгөн эмч даруй сонирхов. Би Евагийн шагайнд шавар наалдсаныг үзсэнээсээ эхлээд урьд шөнийн явдал хүртэл өөрийн үзэж харсан бүх зүйлийг юу ч үлдээлгүй бүгдийг ярилаа. Эмчийн царай барайж дургүйцсэн байдалтай ямаан сахлаа имэрч сууснаа намайг ярьж дуусахад

- Үгүй ер өө! гэж дуугарав.

Дараа нь нилээд удаан бодолхийлсний эцэст өөрийнх олон номын шүүгээний нэгний дэргэд очин тавиур дээрээс нэгэн хавтас авч үзэв. Хавтас дээр "ЛЕКЭН" гэж бичсэн байхыг би харлаа. Эмч доторх бичгийг эргүүлж тойруулж үзэв. Би дуугүй хүлээж суулаа. Эцэст нь эмч ам нээж

- Бүсгүйн өвчний байдал, хүнд хөнгөнийг санаж байна. Тэр бүсгүйг явж чадна гэж итгэхэд бэрх... ямар ч гэсэн хэвийн байдлаар... Таяг, тусгай багаж мэтийн юм хэрэглээд жаахан хөдөлж чадвал дээд тал нь ... Үгүй дээ, үүнээс илүү чадахгүй! гэв.

- Хэдий тийм боловч Евагийн явж чаддаг болох нь нүднээ ил байна. доктор оо! Үүнийгээ яах гэж нуусан юм бол?

- Ай эрхэм ээ, полиомиелитийг бага судалсан юм гэхэд хүний сэтгэл гэдаг чинь хавьгүй их нууц... Ялангуяа тахир дутуугийн тэргэнцэрт өссөн гэж болох бүсгүйн сэтгэлиин нууц... Би ойрын өдрүүдэд очиж үзнэ. Шууд ингээд очвол бачимдан балмагдаж магадгүй гэж хэлээд өвгөн эмч босов. Энэ өвгөн надад таалагдав. Хэдийгээр харахад инээд хүрмээр хөгийн байдалтай, олон үгтэй ч гэсэн сэтгэл мэдрэлийн сайн мэргэжилтэн юм байна гэдгийг ойлголоо.

- За тэгвэл удахгүй уулзах хүртэл баяртай доктор оо. Тантай танилцсандаа баяртай байна.

Шатаар бууж явахдаа энэ өвгөн эмч миний сэжиг таамгийг нотлохуйц гойдын юм хэлээгүй ч нууцаар эдгэрч болох боломжийг бас үгүйсгэсэнгүй гэж бодлоо.

Энэ өдөр Ева өглөөний цайнд ч ирсэнгүй, үдийн хоолонд ч ирсэнгүй. Гагцхүү орой тийшээ нэг үзэгдэхэд царай нь жаахан цонхийсон юм шиг санагдав. Санчиг нь хөх няц болжээ. Шөнө тэргэнцэрийнхээ дугуйг мөргөж орхисных. Өргүүр бууж ирэх үед Элен бид хоёр "Мөрөөдлийн хайрцаг" зургийн үзэсгэлэн худалдааны байрын дотоод чимэглэлийг ярилцаж байлаа. Бид хоёр нэн даруй нэгэн зэрэг нүдээ өргөж харав. Ева хар хилэн хэлхгэр банзал, үсний өнгө нүүрийн тэгийг нь сайхан тодруулсан жокей хөх хүрэм өмсчээ. Энэ хувцас нь гайхалтай сайхан зохисон байлаа. Ева гүүрээс бууж ирээд

- Мэнд амар! Танилцахыг зөвшөөрнө үү. Уралдааны замын шинэ од, Затопекийн гол өрсөлдөгч, холын зайн дээд амжилтыг эвдэгч байна! гэж тачигнуулан өгүүлэхэд

- Тэнгэрийг бодож, болиоч! гэж Элен зандрав.

- Тэнгэрийг бодоод уу?.. За тэгвэл дахиад үг дуугарахаа байя. Би дэргэд нь очиж

- Урьд шөнө бүдүүлэг муухай зан гаргасныг минь уучилна уу. Ева, Би их ичиж байна гэсэнд

- Яамай. Тэглээ гээд би үхчихээгүй байна... Тэр чинь ойрын нэг шөнө миний гарч бужигнуулахад саад болохгүй гэв.

- Ева! Та заримдаа зүүд нойрон дундаа явж чаддаг болох тийм байдалд ордог байж болох юм.

- Гойхон санаа байна!

- Би учрыг олж ядахдаа...

- Миний зүүдэн өвчин намайг яаж дуудаад сэрэхээргүй бөх унтуулдаг байна уу? гэхэд нь би бүр босон харайж

- Хэрэв та нээрээ унтаж байсан юм бол таныг дуудаж сэрээх гээд чадаагүйг минь яаж мэдсэн юм бэ? гэж гайхан асуув.

- Гэхдээ...

- Юу гэхдээ гэж?

- Би нойрон дундаа намайг дугтчин сэгсчиж, нэрээр минь дуудаж байгааг тодхон мэдэрч байсан...

- За тэр дээ!

- Харин би нүдээ нээж чадахгүй байсан.. Нойр их хүрч юу болж байгааг огт мэдэхгүй байсан... За тэр дээ!

- Өө. таны сэрдэж сэжиглэдгээс бүр залхаж гүйцлээ гэхэд нь би дал мөрөө хавчаад

- Боль доо, Ева. Бид дахиад бие биөдээ хаяж э хэлнэ.... гээд би дууныхаа өнгийг өөрчилж:

- Та эгчийгээ их гомдоолоо, Ева!.. Ядахдаа үүнийг санаж байгаа биз дээ? гэсэнд

Санаж байна... гэв.

Эгч, дүү хоёр бие биеэ харахдаа тэдний царайд сэтгэлийн түгшүүр ил байлаа.

- Ай Элен! Эгч минь!.. Намайг уучил... Намайг уучил даа!..

Элен дэргэд нь очиж, дүүгээ тэврэв. Одоо тэд тэврэлдээд уйлалдаж байна... Ширээн дээрээс аяга хурааж байгаа Амелия эмгэн учрыг ойлгож ядсан байдалтай, намайг муухай харав. Миний сэтгэл зовоод гарлаа.

Шөнө юу юугүй бороо асгамаар байснаа тэгсгээд өнгөрөв. Одоо тэнгэр цэлмэжээ. Би

байшинг тойрон гимнастикийн талбайд очиж олс өөд авирлаа. Би урьд ийм амархан авирч чаддаггүй байсансан. Одоо бол жингүй болсон мэт санагдав. Миний биед асар их чадал хуримталж, ингэж авираад тэнгэрт хүрсэн ч чадмаар санагдлаа.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Энэ шөнө онцын юм болсонгүй. Ева унтахаар явж би дадсан заншлаар тавтай нойрсохыг хүсээд /ямар ч далдын санаагүй/ түүнийг далд, орсны дараа Элентэй ярьж эхлэв.

- Евагийн хойноос нүд салгалгүй сайн харах хэрэгтэй байна. Хэрэв өөрийн ухаантайдаа явж чаддаг бол гадагшаа гарахын өмнө хэдэн шөнө хүлээе. Хэрэв зүүд нойрон дундаа өөрийн ухаангүй явдаг бол хэдийд ч босоод явахыг хэлэхэд хэцүү. Өөрт нь мэдэгдэлгүйгээр өрөөнд нь сэмхэн түгжиж болох уу? гэхэд Элен толгой сэгсэрч

- Ева мэдэж орхино. Тэгээд аймаар муухай юм болно! гэв..

- Тэгвэл би гудамд унтаж байя.

- Үүнийг чинь бас мэдэж орхино, хараад байгаарай. Эргэн тойронд нь ямар нэг хэвийн биш юм болоход түүнийг сэрж мэдрэх зургаадахь мэдрэмжтэй юм шиг байдаг.

-За тэгвэл би үүдний танхимд буйдан дээр унтъя.

- Өөрөө мэд дээ, Виктор оо. Танд муу юм болно

- Миний төлөө санаа зовох юмгүй, хонгор минь би хатуу юман дээр унтах дуртай. Цэрэгт алба хааж байсан үеийг минь санагдуулна.

Би нэгд Еваг төөрөгдүүлэхийн тулд, хоёрт гэрийн хувцас өмсөж, хөнжил авахын тулд дээшээ өрөөндөө оров. Ороод нэг хэсэг цонхны дэргэд зогсож, тамхи татаж байснаа муур мэт гэтэн доош буулаа.

Би үүдний танхимын нөгөө буйдан дээр тавтай сайхан унтаад өглөө нь гимнастик хийхдээ урьд урьдынахаас илүү хичээнгүйлэв. Өглөөний ийм биеийн тамирын дасгал надад их тус болдог. Үүний ачаар өдөр нь ширээний ард сууж байхад хурсан өөхийг зайлуулдаг. Миний гэдэс чийрэг, уян болжээ. Булчин шандас минь ган төмөр мэт хатуурч, дасгалжсан бие минь урьд урьдынхаас эрүүл чийрэг болсныг мэдрэхэд сэтгэл маш таатай байлаа.

Өдөр шөнө ээлжилсээр...

Би үүдний танхимд унтдаг хэвээр. Хэрэв хэрэгтэй гэж үзвэл хэдэн сар ч тэнд унтахад бэлэн байлаа. Ямар ч байсан Еваг шөнө явж байхад нь барьж авахаар шийдэв, Еваг нэг шөнө дахин босож явна гэдэгт би өчүүхэн ч эргэлзэхгүй байлаа...

Доктор амалснаараа хүрч ирэв. Евагийн өрөөнөөс гарч ирээд нэгийг бодолхийлэн гайхсан байдалтай толгой сэгсэрч байлаа. Элен бид хоёр түүнийг хашааны хаалга хүртэл үдэж гаргахад

- Еваг явж чадна гэж бодохгүй байна... Та нар эндүүрсэн бололтой гэв.

- Тийм байх ёсгүй, доктор оо! Тийм байх ёсгүй! гэсэнд доктор биднээс туйлын энгийн бөгөөд

ямар ч өөгүй учир зүйтэй нэг юм асуув.

- Та нар явж байхыг нь харсан юм уу?

Нээрээ би Евагийн явж байхыг нүдээрээ хараагүй шүү дээ! Миний баттай сайн мэдэж байгаа ганц зүйл бол Ева нэг хэсэг хугацааны турш өрөөндөө байгаагүй. Түүний явж байхыг нүдээрээ харах, өрөөндөө үгүй байхыг үзэх хоёр бол асар их ялгаатай! Доктор ямаан схлаа байн байн шувтран чухам энэ ялгааг надад сануулаа. Докторыг гаргаж өгөөд бид үг дуугүй буцаж ирцгээв. Тэр шөнө Эленийг зэмлэж Евагийн хэлсэй санав. Миний юу бодож байгааг Элен мэдсэн бололтой довжоон дээр гараад

-Виктор та... эндүүрч байна гэж хэлсэн нь учиртай.

Намайг хариу хэлэхийн завгүй Элен яваад өглөө.

Докторыг явсны маргааш бид дахиад бөөн үймээн болов. Шөнө хоёрдугаар давхарт их чимээ гарахад сэрээд шатаар өгсөн гүйж очиход Элен дүүгийнхээ үүдийг балбаж байлаа,

-Юу болов ло, Виктор оо? гэж Элен асуув

-Мэдэхгүй... Та юм сонсов уу?

Элен хаалганы бариулаас угз угз татах боловч үүдээ дотроос нь түгжсэн бололтой.

—Одоо наад золигийн хаалгыг чинь хэмх цохиё гэсэнд

- Хэрэггүй. Миний өрөө, халуун усны өрөөгөөр дамжаад орьё.

Би гудмын цаад мухарт гүйн очиж, Элений өрөөгөөр хурдан өнгөрөн халуун усны өрөөгөөр дамжин очиход халуун усны өрөөний талд байдаг Евагийн хаалга бас дотроосоо түгжээтэй байв.

- Бас түгжээтэй байна! гэсэнд

- Наашаа эргээд ир! гэж Элений сэтгэл түгшин хашгирлаа.

Эргэж очиход Элен хаалганы бариулаас угзачсаар байв. Би гэдрэг ухарч байгаад баруун мөрөөр хаалгыг хар чадлаараа дарсанд тас няс хийн хаалга онгойж өрөөнд давхин оров.

Өрөө нь гэрэлтэй, ор, тэргэнцэр хоёр нь хоосон байлаа. Ева шалан дээр уурын халаалгын радиаторын хажууд хэвтэж байв. Толгой нь шархтаж, шархнаас нь цус гоожин, алтан шаргал үс нь бараг час улаан болсон түүнийг өргөн авч орон дээр нь аваачиж тавилаа

- Хувцасласан байна! гэж Элен уулга алдав

Би урьд үзсэнээ гайхан мэлрээд үүнийг ажиглаагүй. Ева үнэхээр өмд, ноосон цамц өмссөн байлаа

- Эмч дууд. Би ухаан оруулахыг оролдоод үзье!

Би халуун усны өрөөнд гүйн орж, тэндээс нашитырын спирт авчран алчуур норгоод Евагийн хамарт ойртуулсанд төдөлгүй нэг зогисуулаад нүдээ нээв.

- Миний бие муу байна гэж бөвтнөхөд нь

Зүгээр, зүгээр, Толгой чинь жаахан хавдсан байна гэв. Ева намайг таниад

-Юу болсон бэ?.. Би орноосоо ойчоо юу? гэв.

Элен бид хоёрыг орж ирэхэд Ева өрөөний холын чанд хэвтэж байсан. Тийшээ тэргэнцэргүй хүрсэн байна. Тэргэнцэр нь орны дэргэд байж байсан. Гэсэн ч нууц тайлагдах болоогүй байна.

- Тийм, чи ойчсон байна

- Нойрондоо юу?

- Мэдээж, тийм...

Доктор Буссик хагас цагийн дараа ирж, Евагийн шархыг угааж цэвэрлээд онцын ноцтой юм байхгүй гэж түүний сэтгэлийг тайвшруулав, Дараа нь юу болсныг биднээс асуув. Элен товчхон ярьж өглөө. Элений ярьж дуусмагц би

- Доктор та ойлгож байгаа бизээ. Ева өрөөгөө дотроос нь түгжсэн байсан... Явж чаддаг нь энэ удаа ямар эргэлзээгүй байна... гэсэнд

- Ямар ч гэсэн ойчсоныг бодоход муухан явдаг юм байна гэв

Ева шиг ийм хүн байтугай, эрүүл чийрэг, хурдан шаламгай хүн ч ойчдог шүү дээ!

- Зүйтэй л байна... Ингэхэд хөлийг нь үзэж байхад хөдлөхөө болиод долоон жил болж байгаа баруун, зүүн хоёр хөлийн аль алины нь булчин нилээд чийрэг байгааг гайхлаа...

- За тэр дээ!

-Тийм... Нээрээ ер бишийн сонин тохиолдол. Энэ бүсгүйг нэг сайн мэргэжилтэнд үзүүлэх хэрэгтэй... Парист аваачиж үзүүлэх юм биш үү, мадемуазель Элен?

-Тэгье л дээ

- За би Фарно-Рейнд зурвас бичиж өгье. Тэр бол энэ асуудлын талаар тэргүүн зэргийн мэргэжилтэн. Доктор Буссик явахдаа сэтгэл нь хөөрсөн байлаа. Бид хоёр Евагийн өрөөнд эргэж ирэв. Толгойг нь боосон цагаан боолтны цаанаас зарим газраар цус нэвчин улайжээ.

- Та нар цаанаа юу шивэгнэлдээд байв? Бас дахиад нэг ид шидийн гайхамшиг нээгээ юу?

- Ева! Одоо бид танд бүгдийг хэлье. Та орноос ойчоогүй юм байна.

- Тэгээд хаанаас ойчсон байх нь вэ?

- Та хөл дэөрээ зогсож байгаад ойчжээ!

- Тэгэлгүй дээ!

- Тийм шүү, Ева! Та халаалгын радиаторыг толгойгоороо налсан байсан. Радиатор өрөөний цаана байгааг харж байгаа биз дээ. Тэнд хивс дээр таны мөр үлдсэн байна. Таны өрөөний хоёр хаалга дотроосоо түгжээтэй байсан!

- Хн-хн!

Их ноцтой ,байдал бий болсныг Ева одоо ойлгов бололтой.

- Бас нэг юм байна. Бид нааш орж ирэх гэж хаалгыг эвдсэн гэж би нэмж хэлэв.

Ева хаалгыг харав. Түгжээ нь санжигнах аж.

- Элен эгч ээ! Эгч ээ! Намайг авраач. Би энд байна! Би өөрөө өөрөөсөө айгаад байна. Үүнээс хойш би таны өрөөнд унтаж байя, За юу? гэж Евагийн хашгичихад

- Тэгээрэй л дээ, дүү минь... гэв.

- Нээрээ тэгвэл дээр. Их гутарч сэтгэлээр унах хэрэггүй. Эмч нар үзээд хурдан эдгээчихнэ... Бүх өвчнийг чинь эдгээнэ! гэж би хэллээ.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бид хэлцэж тохирсон ёсоор Евагийн орыг Элений өрөөнд тавьж, би дахиад гуравдугаар давхар дахь байрандаа оров. Нэг хэсэг нам тайван байлаа. Би дэлгүүрийнхээ ажил явдлыг дахин хөөцөлдөж эхлэв.Ажил дуусах ойртож байлаа.

Ева одоо энэ ажлыг онц их сонирхохоо болив. Шөнө зүүд нойрондоо ч юм уу, явж чаддаг нь нотлогдсоны дараа нэг л хачин дүнсгэр номой болчихсон. Заримдаа миний өөдөөс айж балмагдсан ч юм шиг, цэнэж болгоомжилсон ч юм шиг нэг хачин харна.

Евагийн иймэрхүү байдалтай болсныг миний буруу гэж таамаглаж байсан болохоор би ичиж байв. Үгүй гэхэд эгч дүү Лекэний гэрт намайг ирэхээс өмнө иймэрхүү явдал болдоггүй байсан аж. Би ирээд амгалан тайван байдлыг алдагдуулж, хоёр бүсгүйг хөшмөл байдлаас гаргажээ. Энэ байшингийн хаалганы хонхыг дарснаар намайг ирэхээс өмнө хүний бараа харах нь цөөн байсан энэ айлын агаар амьсгалыг үймүүлэн бусниулсан байна.

Муухай ааштай Амелия авгай намайг нэг нүдээрээ үздэггүй хэвээр. Одоо болж байгаа энэ хэрэг явдлын гэм буруутан нь намайг хэмээн ад үзэж, үүнийгээ нуудаггүй байв. Эмгэн миний нүдэнд аль болох цөөн харагдахыг хичээж, болж өгвөл надтай юм ярихгүйг бодно. Чих нь хатуу болохоор тэр үү, мэдсэн ч эс мэдэгч болдог юм уу, шөнийн сүйдтэй явдлыг анхаарахгүй байх шиг. Гэвч эзэгтэй нарынхаа зан байдлын өчүүхэн төдий өөрчлөлтийг ажиглаж сурсан зарц хүний хур их соргог мэдрэмжээр өөрөөсөө нэг юм нуугаад байгааг мэдсэн бололтой. Би Элентэй гэрлэснийхээ дараа энэ ааш муутай эмгэнийг эндээс зайлуулахаар нэгэнт шийдээд байлаа. Одоохондоо эмгэний адайр аашийг тэвчин хүлцэн хэрэгтэй болох юм.

"Мөрөөдлийн хайрцаг" дэлгүүрийн нээгдэх өдөр ойртлоо. Би үргэлж их ажилтай байдаг болохоор гэрийн бараа харах нь цөөн. Би урьд өмнө хариуцлагатай чухал ажил хийж байгаагаа хэзээ ч ийнхүү ухамсарлан мэдэрч байсангүй. Ер нь би ямар нэг ажлыг үүн шиг сайн хийж байсан удаа ч үгүй биз. Агаарын десантын цэрэгт сайн дурааараа бүртгүүлсэн сагсуу хөвгүүнтэй адил энэ ажилд улайран зүтгэсэн... Ерөөсөө энэ бол миний энэ насанд олдсон ганц бололцоо байж болох юм гэдгийг ойлгоод аманд орсон өөхийг хэлээрээ түлхэхгүйг хичээж байв. Ийнхүү ажилд улайгаад эгч дүү хоёрыг гойд их анхаарах чөлөөгүй байлаа.

Эленд дурласан сэтгэл маань баясгалант мөчийг хүлээж байв. Миний хайрын сэтгэл чөлөөлөгдөх цаг хараахан болоогүйг мэдээд Эленийг номхон хүлцэнгүй харж байлаа. Энэ хүүхний ухаалаг даруу байдал нь надад таалагдана...

Нэг мэдэхэд гуравдахь шөнө болов.

Элен намайг хоёрдугаар давхраас дуудаж байлаа. Би их бөх унтаж байсан юм. Гэтэл хүүхний түгшүүрт дуу намайг ташуурдсантай адил боллоо. Шатаар бууж явахдаа бас л Евагаас болж нэг хэрэг мандсаныг таамаглав. Энэ удаа чухам яаж сүйд манангий нь хутгасан юм бол доо? Элен миний барааг хармагцаа

- Виктор оо! Ева дахиад алга болчихжээ! гэв?

- Яаж тэр вэ? Таны өрөөнд унтаж байсан биз

- Би унтаж байсан... Шөнөжин нүд анихгүй байлтай биш дээ!

- Тийм л дээ, хонгор минь... Чамайг зэмлэж байгаа ч юм биш. Ер нь яагаад алга болчихдог байна

- Сэтгэл түгшиж, цээж давчдаад сэрсэн чинь том сүмд төөрчихлөө гэж зүүдэлсэн... Айгаад гэрэл асаагаад харсан чинь хаалга онгорхой, ор нь хоосон байсан

- Гадагшаа гарч эрсэн үү?

-Үгүй. Мэдсэн дороо... таныг дуудсан.

- Хувцас нь байна уу?

- Алга.

Би үүдний танхимд гүйж оров. Үүд нь задгай байлаа. Довжоон дээр гарч:

- Ева! Ева! Чи хаана байнаа? Эргээд ирээч гэж хар тэнхээгэөрээ хашгирсанд навчис ширчигнэхээс өөр хариу чимээ алга.

Би Элен дээр эргэж оров.

- Одоо яах вэ? гэж асуухад нь

- Мэдэхгүй байна.,. Гадаа тас харанхуй... Урьдных шиг өөрөө эргээд ирэх биз дээ...

- Би ч бас тэгж бодож байна...

Одоо эгч дүү хоёрын хамт унтдаг болсон өрөөнд оров... Аймаар том. Миний дотор муухай болоод ирэв. Элдвийн юм үзэж ханах шиг!

- Виктор таны сэтгэл зовоод байна уу?

- Сэтгэл зовох юм байна даа, тийм үү?

- Би айгаад байна... Миний бодоход...

- Юу гэж? гэсэнд Элен нүгэлт муу бодлыг зайлуулья гэсэн шиг толгой сэгсрээд

- Үгүй, даанч аймаар юм... гэв.

- Хаалгаа түгжсэн үү?

-Үгүй. Бид хоёрын ор ойрхон байдаг болохоор

- Тийм л дээ, ойлгож байна... Танд сонсдохгүй яаж хувцаслаж чадсан байна вэ?

- Халуун усны өрөөнд хувцасласан байж болох юм

Халуун усны өрөөнд орж үзэхэд бүх юм нь эрэмбэ журмаараа байлаа. Ямар нэг хувцас хунарын зүйл алга. Гарахаар завдан байсны гэнэт угаагуурын тавиур дээр шилэн аяга байхыг харав,

Аяга хоосон байх боловч дотор нь нэл ягаан өнгийн юм наалдсан байхад нь үнэртэж үзвэл нялуун юм үнэртэж байхад нь гайхан Элений өөдөөс эргэж харав. Элен нэг хачин харж байна. Яагаад ч юм бэ, нэг сэжиг төрлөө. Харахад өөрийн сэтгэлийг зовоож байгаа юмыг бодохын оронд ямар нэг сэжиг авахуулахгүй юм.

-Энэ чинь таны Евад өгдөг нойрны эм байна, тийм үү? гэсэнд Элен толгой сэгсрэн

- Мэдэхгүй... гэв.

- Яагаад? Шинэхэн найруулсан бололтой, бас ёроолд жаахан шавхруу үлджээ. Тэгэхлээр та эм өгсөн юм байна!

- Үгүй дээ, санахгүй байна... Ева заримдаа бие нь муу бол өөрөө авч уудаг... Бас гараад явчихсан байна шүү дээ...

-Үнэмшилтэй тайлбар юм. Гэсэн ч миний сэтгэлд хангалтгүй байв.

- Эм нь хаана байгаа вэ?

- Гэрийн эмийн санд байгаа байх...

Би гэрийн эмийн сангийн хайрцгийг онгойлгож үзэв. Улаан шошготой резин бөглөөтэй тэр жижиг шилийг би маш сайн санаж байна. Эмийн сангийн хайрцагт алга.

- Элен ээ, энэ чинь нэг л жигтэй юм байна..

- Виктор! Та намайг битгий айлгаач!

Элений царай лаваар хийсэн юм шиг гөлчийж. зовхи бөлцийсөн байлаа... Эленийг нэг хэсэг дуугүй ажиглав. Миний сэтгэл мэдрэл тэссэнгүй.

- Элен та надаас нэг юм нуугаад байна...

- Хаанаас даа, Виктор оо!

Миний сэтгэл догдолсондоо бие чичирч, хоолой дээр тээглэсэн бөөн юмыг доошлуулах гэж шүлсээ залгив... Хөлд минь тугалга цутгасан юм шиг. Хамаг биеийг минь айдас эзэмдээд

- Эмийн шил хаана байгаа вэ?

- Хэлсэн шүү дээ, мэдэхгүй...

- Ева нойрны эм уусан бол шатаар бууж чадахгүй. Аяганд байсан эм бүтэн хороо цэргийг унтуулж хүрнэ. Ингэхэд аяганы амсарт уруулын будаг наалдсан байна. Тэр нь танай дүүгийн хэрэглэдэг цикламен будаг мөн. Та маргахгүй юм байгаа биз дээ?

Элөн хариу дуугарсангүй. Намайг ухасхийн гарахад Элен зам тавьж өгөв. Бие минь улам их салгалж байна. Бид хоёр унтлагын өрөөнд эргэн орж, дахин сайн үзээд гудамд гарлаа. Миний амьсгаа давхцаж эхлэв.

Байшинд сүм шиг гэх үү, үхээрийн газар шиг гүм... Элөн сүм үзэж зүүдэлсэн гэсэн!

Би урьд Евагийн унтдаг байсан өрөөнд оров. Хэдэн хоногийн өмнө мужаан дуудсан атал хаалгыг нь болтол засаагүй байна. Би энэ өрөөг бас дахин үзлээ. Гэнэт хаалгыг нь эвдсэн тэр шөнө огт анзааараагүй өнгөрсөн нэг зүйл миний анхаарлыг татав... Түгжээний дэгээ, тээг хоер нь хоёулаа бүтэн байна!

Ойлгож байна уу?.. Намайг хаалга эвдэх үед дэгээгээр түгжээгүй цоожилсон байжээ. Уг нь Ева дэгээгээр оньсолдог гэж Элен хэлж байсан... Би Элен тийш эргэж

- Элен!.. гэж дуудав.

- Юу гээ вэ?

- Тэр шөнө би наашаа гүйж ирэхэд үүд нь дотроосоо түгжээтэй байгаа гэж үнэмшсэн. Жинхэнэ хэрэг дээрээ та өрөөнөөс гараад үүдийг нь түлхүүрээр түгжсэн юм байна!

- Та солиоров уу?

- Би бол таныг солиорсон юм уу даа гэж боллоо.

- Битгий доромжлоод байгаарай!

Би Элений гараас шүүрэн авч угз татаад

- Намайг хаалга эвдэхийн өмнө Еваг дотроосоо түгжсэн гэж баттай мэдүүлэхийн тулд та намайг халуун усны өрөөнд ор гэсэн! Та л энэ байшинг сэтгэл мэдрэлийн өвчтөний эмнэлэг шиг болгожээ!

- Энэ чинь даанч хүн үнэмшмээргүй үг байна даа, Виктор оо!, Та гэв гэнэт яах чинь энэ вэ?

Би хариу хэлэхийн оронд Элений хөлийг шүүрэн авч, туфлийг нь сугалж аваад улаар нь дээш харуулсанд хивс дээр элс асгарав.

- Элен! Та өнөө шөнө байшингаас гараагүй, Гэтэл туфли дотор чинь элс байна!

Энэ үг түүнийг мэлзэх газаргүй болголоо! Элен юу ч хэлж чадахгүй хий ангалзав.

- Та дүүгээ үзэн яддаг юм байна, тийм үү? Элен чимээгүйхэн уйлан вандан дээр сандайлаад

- Би тэсэхээ байлаа. Нээрээ би тэсэхээ байлаа Виктор оо... гэж сонсдох төдий шивэгнэв.

Би юу хэлэлтэй билээ дээ? Энэ намтар дуусах ойртож байх шиг. Эленд нуугаад байх юм үгүй бас нээрээ харваас тэнхээ нь тасарсан байна.

- Би олон жил энэ хөөтэй тэргэнцэрт аргамжигдсан хүн. Та ойлгож байна уу? гэхэд нь

- Ойлгож байна гэв.

Би үнэндээ эгч дүү хоёрын энэ эмгэнэлт байдлыг ойлгож байлаа. Элөн дүүгээ асрах гэж өөрийн эрх чөлөө залуу насыг золиосонд гаргасан байна... Тэгээд өөрийн баяр баясгалангүй гунигт амьдралыг гэнэт нэгэн өдөр олж харжээ...

- Жинхэнэ хэрэг дээрээ би ч тахир дутуу хүн байлаа, Виктор оо..

- Ингэж жүжиглэхийн хэрэг юу байв? Еваг ч зовоож өөрийгөө ч зовоож байхын оронд түүнийг зөнд орхичихгүй яасан юм бэ?

- Орхих гээд зүрх хүрээгүй юм.

- Та түүнтэй туйлын аймшигтай инээдэмт жүжиг тоглож зүрхэлсэн байна шүү дээ. Та Еваг өөрөө мэдэлгүй зүүд нойрондоо босож явдаг сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн гэж өөрт нь итгүүлэх арга эрж байсан байна! ЭНэ чинь үзэшгүй муухай хатуу сэтгэл шүү, та ойлгож байна уу?

- Би Евад тэгж итгүүлэх гээгүй...

- Хэнд итгүүлэх гэсэн юм бэ? Надад уу?

- Тиймээ, танд.

- Яах гэж тэр вэ? Учрыг хэлээд өгөөч. Элен нүдээ буулган тонгойв. Эрүү нь ээтийж, магнайд нь гүн үрчлээ тодрон Элен одоо тийм үзэсгэлэнтэй сайхан харагдахаа болилоо.

-Миний санаж сэдсэнээ гүйцэлдүүлэхэд Еваг шөне гадагшаа явдаг гэж бүгдэд итгүүлэх хэрэгтэй байсан.. Ийм болоод би энэ жүжгийг найруулж тавьсан юм... Таны эргэлзэж байгаагаа хэлсэн тэр өдөр миний толгойд ийм санаа төрсөн... Би Евагаас салж амрах юмсан гэж удтал хүлээсэн хүслээ биелүүлэх боломж гарлаа гэж бодсон... гэхэд нь миний дотор эвгүй оргиж

- Та дүүгээсээ салж амрах гэсэн хэрэг үү? Ева одоо хаана байгаа вэ? гэж асуугаад түрүүчээс хойш өдий төдий юм асуусан мөртлөө хаана байгааг нь сая лавласнаа өөрөө ч гайхав.

- Мэдэхгүй...

- Боль доо! Ева хаана байгаа вэ?

- Би... би байшингаас аваад гарсан...

- Хааш нь?

- Модонд аваачиж тавьсан...

- Тийшээ очицгооё.

Амьдрал хэмээгч ийм булай муухай байдаг ажээ гэж бодохоос сэтгэл минь давчдав. Элений ийнхүү үзэшгүй муухай хутган үймүүлснийг мэдээд түүнд дурласан сэтгэл минь жигшин зэвүүцэх сэтгэл болж хувирав.

- За явцгаая гэсэнд Элен толгой сэгсрэн

- Үгүй, үгүй... Ганцаараа яв... Надад тэнхээ алга гэв.

- Явцгаая! гэж би хэлээд гараас нь шүүрэн шатаар уруудлаа. Бид үүдний танхимаар өнгөрч, довжоон дээр гарав... Элен өрөөсөн туфльтэй, би хөл нүцгэн. Одоо энэ ямар хамаа байх вэ дээ. Бүх зүйлийг аль болох түргэн хийх хэрэгтэй гэж дотоод сэтгэл минь хэлээд байлаа...

Бид ширэг дээгүүр гацуур модон ой руу явлаа. Энд овоо гэрэлтэй байна. Модноос ёозгүй хар сүүдэр тусна. Элен айсандаа хамаг бие нь чичрэн

- Намайг орхиоч, Виктор оо... Таныг гуйя...

- Еваг хаана тавьсан бэ?

- Тэнд..

Заасан зүг рүү нь нүд ширтэн харахад юу ч харагдсангүй. Гар чийдэн авч гараагүйдээ харамслаа.

- Еваг энд орхисон чинь үнэн юм бол би олж харах ёстой. Та худал хэлжээ.

Элен хариу дуугарсангүй, нүүрээ үрчигнүүлэн чимээ чагнаж байлаа. Тэгэхэд нь би бас чагнаад толгойд минь нэгэн аймаар бодол төрөв... Би одоо бүгдийг ойлголоо.

Галт тэрэг ойртож байгаа чимээ улам тодрон тохойн хажуугаар төмөр зам өнгөрдгийг саналаа.

- Муу өлөгчин! Чи Еваг төмөр зам дээр таввсан байна тийм үү?

Элен толгой дохив.

Би төмөр замын зүг хар хурдаараа гүйлээ. Галт тэрэг ойртож, чимээ нь тэнгисийн чимээг

дарав. Би хүч чадлаа шавхан гүйсэн учир миний бүх сэтгэл маань алга болж, гагцхүү гүйж байгаагаа мэдрэн ямар ч байсан амжиж аврах хэрэгтэй гэхээс өөр бодол төрөхгүй байлаа. Мод, бутыг тойрон газрын бартаагаар нэг өгсөж нэг уруудан гүйж явахад нүдний минь өмнө ганц Ева үзэгдэх шиг болж, ямар ч байсан галт тэрэгнээс өрсөн түүнийг олох ёстой гэхээс өөр хүсэл байсангүй.

Галт тэрэг аль талаас ирж явааг ч бүү мэд төмөр зам том гүвээг тойрсон байдаг. Гүвээний цаанаас зүтгүүрийн чимээ олигтой сонсдохгүй юм. Ямар ч гэсэн галт тэрэг ойртож явааг мэдэж байлаа.

Эцэст нь би гүвээний бэлд хүрч төмөр утсан хашаан дээгүүр даван төмөр замд хүрч, далан шороон дээгүүр гүйхэд хурц ирмэгтэй чулуу нүцгэн хөлийг минь хатгах оловч өвдөхийг мэдрэхгүй байлаа.

Галт тэрэг баруун талаас ирж явна. Дохионы нь гэрэл бүр тодхон харагдаж, бөөн утаа суунаглаж байлаа. Би гялалзан буй зам төмрийг харав.

Тэгснээ би уулга алдан хашгирав. Миний өмнө, галт тэрэгний наана зам дээр Ева хэвтэж байлаа...

Би нэг сайн амьсгаа авч цээжээ дүүргээд Ева руу хасхийв. Би хэдийд ийм хурдан гүйдэг болов оо?! Надад өөрт минь ямар аймшигт аюул заналхийлж байгааг огт үл бодон хар эрчээрээ гүйв. Миний нүдний өмнө өрөөл татанхай, бас нойрны эмд толгой нь мэнэрсэн хүн хэвтэж байна. Галт тэрэгний чимээн дундаас гэнэт ард

- Вий-ктор! Хэрэггүй!!! Хэрэггүй ээ! Виктор гэж Элений хашгирах сонсодлоо,

Энэ нь надад улам хүч нэмэх шиг болов. Ийм үед төрсөн дүү бүсгүйгээ үхээсэй гэж хүснэ гэдэг ямар муухай хар санаа вэ! Галт тэрэг бүр ойртон ирлээ. Дохионы гэрэл нь зам төмөр дээр тусан гялалзуулав. Сүүлчийн хэдэн метрийг би гүйх гэж шулуухан ниссээр Евагийн дэргэд хүрэв.

Дараа нь юу болсныг өөрөө мэдэрсэнгүй. Энэхэн мөчөөс эхлэн тархи мэнэрээд явчихсан... Гагцхүү нүүрсний хар утаа залгиж, нуруу руу халуун гал төөнөж, толгой дээр чих дөжрөм их түжигнэж тачигнах чимээ гарсныг л санаж байна.

Миний тэнхээ тасран амьсгаа давцхан далан шороон дээр ухаан алдсан байжээ. Ухаан ороод Еваг элгэндээ чанга тэвэрсэн байгаагаа мэдэв. Ева нүүр рүү минь халуу оргитол амьсгалж байлаа...

Еваг далан дээр аяархан тавиад өөрөө босов. Би хэзээ ч хэвийн байдлаар амьсгалж чадахгүй юм шиг салгалаж байлаа. Цээжинд минь нүүрсний цог шатаж байх шиг. Хамаг бие салганан чичирч байв. Хэн ч, хэзээ ч ингэж чичирч байгаагүй бизээ...

Сэрүүн салхи сэтгэлийг минь жаахан тайвшруулав. Амьсгаа аажимдаа хэвийн байдалд орж эхэллээ. Би духныхаа хөлсийг ханцуйгаар арчив...Дараа нь Еваг сэрээх гэж сэгсчиж үзэв.

Элен ихээхэн хэмжээний нойрны эм өгсөн болохоор тийм амар сэрэхгүй нь мэдээж... Тэгэхэд нь би Еваг тэврэн өргөв. Энэ хөөрхий зовлонт бүсгүй сэрсэн дороо ямар аймшигтай юм болсныг тэр даруйд ухаарахгүй биз. Би гуйвж дайван Еваг далан шороон дээгүүр тэврэн явсаар төмөр зам эгч дүү Лекэний байшинд хамгийн ойртож очдог газар хүрэв. Хөл минь, ерөөсөө бие минь хичнээн их ядарсныг одоо л мэдэрлээ. Еваг тэвэрч явахдаа хөлийн дор юу байгааг мэдсэнгүй. Эцэст нь түүнийг үүрэхээр шийдэв. Үүрээд явбал ой дотуур өнгөрөхөд арай амар байх биз.

Дороо зогсоод хөөрхий бүсгүйг үүрэхээр завдтал гэнэт...

Далан шороон дээр нэг том бараан юм харагдав. Тонгойж хараад энэ бол Элений тасар тасар татуулсан бие байгааг ойлгов...

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Элен намайг галт тэргэнд дайруулаа гэж бодон нэг агшны төдий алмайран бие нь хөшсөний харгайгаар амиа алдсан болов уу даа. Цээжин дээр нь асар гүн шарх гарч, өрөөсөн хөл нь бараг тасарсан байлаа. Нүүр нь гэмтсэнгүй. Царай нь тайван, нэг жигтэй инээмсэглэл тогтсон байх шиг санагдана. За даа, үхсэн хүний царайн нууцыг тайлах гэж оролдох илүүц ажил бизээ. Би Еваг далан шороон дээр тавиад Элений хажууд өвдөг сөхрөн суув...

Би Еваг орон дээр нь тавьж, хувцсыг тайлан хөнжлөөр хучив. Дараа нь түүний хувцсыг сайтар цэгцлэн сандлын түшлэгт өлгөв. Өөр юу сан билээ?.. Аа тийм халуун усны өрөөнд орж, шилэн аяганд үлдсэн нойрны эмийн шавхрууг асгаж, аягыг угаав, Үүний дараа өрөөндөө очив. Бүх өрөөний гэрлийг унтраагаагүй. Амилия авгай өглөө босоод энэ янзаар нь үзэг. Үзсэн харсан зүйлийн тухай түүний мэдүүлэг Элений амиа хорлосон гэдэг таамаглалыг улам бататгана.... Эленийг сэтгэлийн хямралд автан гуньж гутрахдаа тэгсэн байх гэж бодох биз. Ямар ч атугай би ингэж найдаж байна. Энэ бүхний дараа би цурам хийж чадаагүйг хэлэх хэрэг байна уу даа? Цаг дуугарахад, ялангуяа гүвээний хажуугаар галт тэрэг өнгөрөхөд. хамаг бие чичирч байлаа.Өчигдөрхөн миний болзоот бүсгүй байсан хүүхний үхдэл нүдэнд минь үзэгдсээр. Хөөрхий Элен! Ийм янзаар эцэслэхийн өмнө яасан их зовоо бол доо?! Уг нь аз жаргалтай амьдралд зориулсан гэмээр энэ өргөө сайхан байшинд олон жилийн турш өдрөөс өдөрт нэгэн хэвийн байдалтай амь зуусаар сүүлдээ өөрийн амьдралаас бүрмөсөн залхаж, үзэн ядах болсон болов уу гэж бодохоос айдас хүрэх шиг!.. Хүн амьтангүй бөглүү зэлүүд газар урц овоохойд орогнон суудаг зэрлэг бүдүүлэг юмнууд иймэрхүү маягийн ааш зан гаргана уу гэхээс нэр төр, шударга ёсны хууль зүйд захирагддаг соёлт хүмүүс бол ингэхгүй дээ...

Элений заяа төөрөг өөр тийшээ эрэгсэн бол би ямар байдалд орох байсан бол?.. Эленийг цагдаа нарын гарт бариад өгч чадах байсан болов уу?.. Евагийн биеийг түүний саварт орхиж чадах байсан болов уу?.. Элений эмгэнэлтэйгээр төгссөн нь надад тийм ч сайхан сэтгэгдэл төрүүлсэнгүй. Би түүнд дурласан юм уу?.. Дурласан гэхэд одоо их эргэлзэж байна

Бид хоёрын харилцааг ийнхүү огт өөр талаас нь аваад үзэхээр зохиомол зүйл шиг санагдаж аз жаргалтай үргэлжлэх байсан гэхэд үнэмшил багатай байлаа. Элен сэтгэлийг минь догдлуулдаг байв уу? Миний дурыг булаасан уу?.. Би түүнтэй нэгэн гайхамшигт мөчийг хамт өнгөрүүлсэн үү?

Гэхдээ энэ чинь дурлал юм гэж үү?..

Үүр цайж, жигүүртэн шувууд жиргэн донгодож эхлэв. Шинэ өглөөг би арай уужуухан дотортой угтлаа. Амелия авгайн босож байгааг сонсов. Өглөө болгон сэрээд бүгшүүлэн ханиалгаж, хувцсаа өмсөх зуур ганцаараа ярьдаг зантай. Хараал зүхэл унщдаг ч юм уу, бүү мэд...

Авгайг доош бууж ирэхэд одоо хаана явааг нь сэтгэлдээ төсөөлөн таамаглах гэж нүдээ анив. Авгай хоёрдугаар давхарт ирээд гайхан уулга алдаж, Эленийг янз янзаар хэдэн удаа дуудсанаа дараа нь нэгдүгээр давхарт бууж ирэв бололтой, чимээ нь сонсдохоо болилоо.

Тэгтэл эцэж туйлдсан би орон дээр суугаагаараа унтаад өгчээ... Хэдхэн минут унтсан боловч

энэхэн хооронд бие минь амарч сэргэлэн байв.

Нүүр гараа угааж байтал Амелия авгай үүдийг минь тогшив. Энэ эмгэн над дээр анх удаа айлчлан ирж байгаа гэж хэлж болно. Намайг үргэлж жигшин зэвүүцсэн байдалтай байдаг үрчгэр царайд нь одоо сэтгэл түшгсэн байдал илт.

- Намайг асуугаад ир гэж явуулав уу? хэмээн тайван асуухдаа биеэ маш сайн эзэмдэж байгаагаа ойлгов

- Үгүй, өөр юм...

- Юу болоо вэ? Та нэг юманд сэтгэл зовоо юу

- Тийм. Мадемуазель Элен алга болчихжээ... гэхэд нь би бүр тас тас инээж

- Алга болчихсон гэнэ ээ. Хөгийн юм байна даа. Элен өглөө бүр гимнастик хийдэг шүү дээ.

- Үгүй!

- Тэгвэл салхинд явж байгаа биз...

- Үгүй!

Амелия авгай ийнхүү тоть шиг Үгүй! үгүй! давтан хурц нүдээрээ намайг шөвөгдөх мэт ширтэн харлаа.

- Үгүй гэдгийг та яаж сайн мэдсэн юм бэ?

- Биеийн тамирын хувцас нь өрөөндөө байж байна... Бусад хувцас нь ч бас... Мадемуазель гэрээсээ шөнийн цамцтай гарсан шиг байна... Гудмаас өрөөсөн туфлийг нь оллоо... Энэ байшингийн бүх гэрэл асаатай байсан...

- Үгүй ер өө!.. Мадемуазель Ева яасан бэ

- Унтаж байна. Дуудаад сэрдэггүй... Дахиад л нойрны эмээ уусан юм байх.

- Очиж үзье.

Хоёрдугаар давхарт би бүх өрөөний үүдийг онгойлгон шагайж үзэв, Би сайн жүжиглэж байгаагаа мэдэж байсан бөгөөд эмгэний бүх сэжгийг өөрөөс зайлуулж чадлаа.

- Та эндээс хаашаа ч битгий яваарай. Би байшингийн эргэн тойрон эрээд үзье гэж эмгэнд хэлэв.

Төдөлгүй би гацууран ойд очив. Шөнө тэнд ямар нэгэн мөр үлдээсэн байж магадгүй. Одоо тэгээд үлдсэн байвал арилгах аятайхан боломж таарлаа. Явж байхдаа бутан дээр миний нусны алчуур байхыг олж, халаасандаа хийв. Төмөр замд хэтэрхий ойртож зүрхэлсэнгүй,

намайг хүн харчих вий гэж айгаад.

Нэг цагийн дараа эргэж ирэхэд нэг цагдаа, төмөр замын албан хаагч хоёр ирээд Амелия авгайтай ярилцаж байлаа. Ингээд мөрдөн байцаалт эхэлснийг ойлгов.

- Та төрөл садангийн нь хүн үү? гэж цагдаа надаас асуув.

- Бараг тийм... Би мадемуазель Элений болзоот хархүн.

- Мадемуазель үхчихжээ! гэж Амелия авгай гашуудан өгүүлэв.

Цагдаа, төмөр замчин хоёр "аймшигтай золгүй явдал" болсныг надад болгоомжтой ярилаа. Би зохих ёсоор жүжиглэн хариулав,

- Хамгийн гайхалтай нь зам дээгүүр дан шөнийн цамцтай явж байсан байна... Зүүдэн өвчтэй байсан юм уу? гэж цагдааг асуухад Амелия авгайг хариу хэлэх болов уу гэж өөдөөс нь харлаа.

Цагдаа асуултаа давтан асуухад авгай дал мөрөө хавчаад

- Жаахан байхдаа тийм байсан... Сүүлдээ зүв зүгээр болсон... гэв.

Цагдаа сүрхий философич эр байжээ.

-Мөрдөн байцаагч учрыг нь олно биз гэж тэр хэлээд гарч одов.

Төдөлгүй цагдаа, төмөр замчин хоёр яваад өгөв. Амелия авгайтай хоёул үлдээд дотор жаахан эвгүй байлаа. Эмгэн үнэнээсээ харамсан гашуудаж байлаа. Би түүнд юу гэж хэлэхээ мэдэхгүй юм. Би уйлж байгаа дүр үзүүлэхийн тулд бус, дотроо онгойлгохын тулд уйлмаар байсан боловч уйлж чадсангүй. Амелия авгай бүр дэргэд минь хүрч ирээд

- Таныг энэ айлын босго алхсан тэр өдрөөс хойш энэ гэрт муу юм шүглэсэн байна гээд уйлсаар байх боловч харц нь ширүүн байлаа.

- Таны хэлснийг зөвшөөрч байна.

- Энэ хоёр охин танд ухаан алдсан... Энэ хоёр... гээд түгдрэхэд нь миний сэтгэл түгшин цааш нь юу хэлэхийг хүлээв. Энэ эмгэн олон зүйлийг таамаглаж байгаа байж болох юм.

- Хоёр бүсгүй урьдынх шиг бие биеэ хайрлахаа больсон. Хөөрхий Элен лав амиа хорлосон байх! Танаас болж дүүгийнхээ хайрыг алдаж байна гэж мэдээд үүнийг тэсэж чадаагүй байх! гэж эмгэн хэлээд мэгшин уйлж амьсгаа нь бөглөрөн хэсэг дуугүй болов,

- Та чинь ад албины элч байна! гэж эмгэн намайг үзэн ядсан нүдээр ширтэн өгүүлээд буйдан дээр уналаа. Би Еваг сэрээх санаатай өрөөнд нь очив. Мөн л үхсэн юм шиг унтсан хэвээр. Би түрүүчийнх шигээ дахин нашатырын спирт үнэртүүлсэнд нэг зогисуулаад нүдээ нээв.

- Ева та миний үгийг сонсож байна уу? Бүсгүй толгой дахиж байгаа нь тэр үү, толгойгоо

жаахан хөдөлгөв.

- Битгий унтаарай. Хүлээж байгаарай... Би халуун усны өрөөнд орж, эмийн сангийн хайрцагаас макситон авчран Евад жаахан уулгаад духанд нь нойтон алчуур тавилаа. Ева аажмаар ухаан орж эхлэв. Таван минутын дараа нойр нь овоо сэргэж

- Би дахиад тэнэг юм хийгээ юу? гэж шивнэн асуув.

- Үгүй, Ева... гээд би орон дээр нь сандайлж сайхан үсийг нь илбэн:

- Танд нэг гунигтай мэдээ дуулгах болж байна гэсэнд Ева сэтгэл нь сэртхийсэн бололтой ч дуугүй өнгөрөв.

Аймшигтай юм болсон... гээд би хэлэх зүрх хүрдэггүй. Ева Элений хоосон орыг хараад

- Элен эгч үү? гэхэд нь би толгой дохив.

- Эгч яагаа вэ? яваад өгөө юу? Сонин таамаг юм даа.

- Зарим цэг утгаар яваад өгсөн гэж болох ч бүүр холын аянд яваад өгсөн...

- Үхчихсэн юм уу?!

- Тийм.

Ева нүдээ анив. Уруул нь цайгаад ирлээ.

- Ева!

- Өөв...

- Таны бие муу байна уу?

- Үгүй, зүгээр... Яагаад тийм юм болоо вэ

- Эгч чинь... зүүдэн өвчтэй хүн байжээ...Нойрондоо босож явдаг байсан байна... Өнөө өглөө... төмөр замын тэндээс олсон...

Ева даруй нүдээ нээж

- Төмөр замын тэндээс ий?.. гэж хашгирав

- Тийм...

- Би урьд шөнөжин төмөр зам зүүдэлсэн

- Хачин юм байна...

Дараа нь би түүнд иймэрхүү үед ярьдаг ердийн юмыг ярилаа... Бас аргадаж тайтгаруулах хоосон үг хэлэв. Үүнийг хэн анхаарч сонсох билээ. Ярьж байгаа хүн нь ч өөрөө ч сонсдоггүй юм чинь...

Дараа нь Амелия авгай ирж, хамт асгаруулав. Ева хөгшин зарц авгайн элгэнд наалдан эхэр татан уйлав. Би өрөөний нөгөө захад очиж тэр хоёрын уйлж байгааг харахдаа энд одоо надад хийх юмгүй болжээ гэж гуниглан бодов.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мөрдөн байцаалт нэг их удсангүй дуусав. Цагдаагийн хоёр мөрдөн байцаагч ирж биднээс бүдэг балархай юм асуусан. Хууль цаазын үүднээс бол энэ эмгэнэлт жүжгийн юм бүхэн нь "зохих журмаараа" байсан бололтой.

Элен зогсоогоороо галт тэргэнд дайруулсныг магадлах мэргэжилтэн нар тодорхойлон тогтоосон байна. Энэ нь хүний гарт амь үрэгдсэн байх болзошгүй сэжгийг тасалжзэ. Хоёрдугаарт, энэ гэрийнхний дотор тахир дутуу Еваг эс тоолбол Элений үгүй болохыг эд материалын талаас сонирхох хүн байсангүй. Тэгэхлээр хэргийг энэ талаас нь авч үзэх шаардлага гарсангүй. Өрөөл татанхай хүүхнийг хүн амины хэрэг хийсэн байж магадгүй гэж хэн сэжиглэх билээ дээ?!

"Амь үрэгдэгч эмэгтэй зүүдэн өвчтэй байдалд байсны улмаас санамсаргүй гай зовлонд учирсан байна" гэж мөрдөн байцаалтын албан есны дүгнэлтэд өгүүлжээ, Сүрхий нарийн дүгнэлт юм. Цагдаа нар амиа хорлосон байж болох таамаглалыг авч үзсэнгүй. Талийгаач хүүхэн нэлээд ихээхэн хөрөнгө мөнгөтэй байсан учир ийм таамаглалыг үндэсгүй гэж үзсэн биз.

Эленийг гурав хоногийн дараа оршуулав. Хүн цөөн, Амелия авгай, доктор Буссик, айл хөршийн хэдэн хөгшин. Ингээд л гүйцээ. Оршуулгын газраас гарч явахад доктор Буссик намайг хэзээний дотнын танил мэт сугадан авч

- Таныг дөхүүлж өгвөл болох уу? гэхэд нь

- Бололгүй яах вэ, доктор оо... гэв.

Нэг хэсэг дуугүй явсны дараа доктор гараа суллаж аваад дороо зогсов..

- Ноён Менда та хэлээч, таны толгойд амьдрал гэгч жигтэй хачин юм байна гэсэн бодол төрөхгүй байна уу?.. Та над дээр очиж, дүү бүсгүйн нь өвчний тухай ярьж байсан. Гэтэл эгч нь алга болоод өглөө...

Би хэсэг эргэлзэв. Докторыг төөрөлдсөн чигт нь орхих уу?

- Доктор оо! Танд нэг зүйлийг үнэнээр нь хэлье...

- Бушуухан хэлээрэй! Миий сониуч зан хөдлөөд тэсэж ядан байна, эрхэм нөхөр минь!

- Евагийн өвчний тухайд...

- Юу гэж?

Цүдгэр гэдэстэй, ямаан сахалтай, хөөрүү доктор Буссик хөдөөний ,гүдэс шулуун эрийн нийтлэг дүр юм.

- Евагийн тэр өвчин гэдгийг Элен зохиосон болов уу гэж бодоод байх юм гэсэнд доктор

зальтайхан анивалзаад

-Үүнийг чинь би ч бас бодож байсан байвал яахвэ? гэв.

- Тийм байж болох юм... Тэгээд л энэ сэдвээр одоо тантай яриа үүсгэж байгаа хэрэг... Хөөрхий хүүхний мэдрэлийн систем нь их муудсан бололтой юм, дүү бүсгүйгээ өвчтэй хүн болж худлаа баашилж байгаагаар үзүүлэн өсөө авах гэж оролдож үзсэн. Энэ санаа нь бүтэхгүй болохоор...

-Энэ чинь их гунигтай намтар юм. ,Амь насанд нь зориуд төвөг учруулж болохгүй болохоор нь ингэдэг байна шүү. Үүнийг ойлгоход хэцүү гэж үү? Хэмээн хэлээд шүүрс алдав.

Нар төөнөж байлаа. Амелия авгай бидний өмнө салгалж явна. Энэ бол баясгалант сайхан байгалийн ганцхан хар толбо байв.

-Эрхэм нөхөр та одоо яах бодолтой байна вэ доктор асуув.

- Чемоданаа аваад явна... Би өөр яах билээ

-Залуу хүн танд амжилт хүсье

Бид хоёр замын билчир дээр саллаа. Би хэсэг тээнэгэлзсэний дараа алхаагаа хурдасган Амелия авгайг гүйцэж очив. Бид хоёр дуугүй явж байлаа. Ер нь юу ч ярих билээ дээ, бид хоёр. Анх танилцсан өдрөөсөө хойш үргэлж үг дуугүй байсан улс...

Бид толгойгоо унжуулан гэлдэрсээр манай өргөө гэрийн хашааны хаалганд хүрч ирэв. Ева тэргэнцэрт довжоон дээр сууж байлаа. Гашуудлын хар платье өмсчээ. Бүсгүйг хараад зүрх минь шимшрэв. Холоос арчаагүй дорой амьтан харагдах юм! Одоо бүр гав ганцаар үлдлээ.

Дотоод хашаатай, хятад дээвэртэй, цэцэрлэг, гүвээтэй, тодорхой стиль маяггүй энэ байшин гэнэт бүсгүйг тэмтрүүлээрээ барьж авсан наймалж мэт санагдав.Үнэхээр тахир дутуугийн тэргэнцэрт суугаа гашуудлийн хар хувцастай, өөрт нь жаргал авчирч үл чадах овоо хөрөнгө мөнгөтэй энэ бүсгүй хязгааргүй их ганцаардлын билэг тэмдэг мэт санагдана.

- Энэ бүсгүй яах гэж хүн болж төрөв дөө гэж Амелия авгай шүүрс алдан өгүүлэв.

Би ч биеэ эзэмдэж чадахаа больжээ. Хашааны хайснаас зууран барьж, духаараа хашаа налан асгаруулан уйлж эхэллээ... Амелия авгай намайг гайхан ширтэв. Намайг ингэнэ чинээ санаагүй бололтой.

- Ороох! Хүн амьтан харна... гэж авгай хэллээ. Намайг довжооны дэргэд очиход Ева эелдэг тайван харцаар угтан гараа сунгаж, бэлхүүсээр минь тэврээд цээжийг минь толгойгоороо налав...

- Та эгчид минь их хайртай байсан даа гэж хөөрхий бүсгүй санаа алдлаа.

- Би түүний хойноос уйлаагүй. Ева таныг бодоод... уйлж байна

Ева тэр дорхноо гэдийж, гар нь тэрэгний дугуй дээр унав.

- Виктор та үнэнээсээ хэлж байна уу?

- Тийм... гээд би бүсгүйн сайхан үсийг болгоомжтой энхрийлэн иллээ. Тэгээд юу ч хэлэлгүй, юм хумаа цуглуулж бэлтгэхээр явлаа.

Хамаг юмаа хоёр чемоданд хийв. Миний өрөөнд нарны гэрэл туссан ч гэсэн гэнэт маш уйтгартай харагдаад ирлээ. Миний сэтгэлд энэ өрөөтэй холбогдсон дурьдатгал их бий...

Намайг бууж ирэхэд Ева дотоод хашаанд байж байв. Намайг хүлээж байсан бололтой, гарч ирмэгц минь хоёр чемоданыг нүдээ их болгон ширтэж

- Вик ээ гэж уулга алдлаа. Би дэргэд нь очив.

- Энэ чинь юу вэ? Та.. явах гэж байгаа юм уу?

- Тийм л дээ. Цаашид энэ байшинд байж болохгүйг минь та өөрөө сайн мэдэж байгаа!

- Та юу хэлнэ вэ! Байж болохгүй гэнэ... Яагаад байж болдоггүй юм бэ? Та нэг муу хулчгар амьтан шиг ингээд зугтаж болохгүй! Та намайг орхиод явах юм уу?

- Хэн ч гэсэн танд...

- Хэн байсан ч надад хамаа алга Вик ээ! Би энд ганцаараа үлдэхийг хүсэхгүй!

- Танайд Амелия байж байна.

- Үүнийг хүн байж байна гэх үү?

- За ийм байна, Ева! Би энд саатвал тун муу юм болно. Намайг хүн юу ч гэж бодох юм билээ

- "Мөрөөдлийн хайрцаг" дэлгүүрээ яах вэ?

- Тэр бол хоосон мөрөөдөл төдий байсан болов уу даа... Нээрээ мөрөөдөл...

- Та тэр дэлгүүрийг надад орхиод явах гэж байна уу?

Би хоёр чемоданаа шал дээр тавиад өлмий дээрээ суулаа.

- Таны зөв юм уу даа... Би нээрээ танай албан хаагч байж болох юм... Харин би одоо зочид буудалд очиж сууна... Тан дээр үргэлж ирж байх болно гэхэд Ева амныхаа дэргэд гараа хумбайлган бариад

-Амелия! гэж хар тэнхээгээрээ хашгирав. Эмгэн дотоод хашаанд ойр байсан бололтой, хүрч ирлээ. Ева миний хоёр чемоданыг зааж

- Ноён Мендагийн юмыг өрөөнд нь аваачигтун гэхэд нь би дуугүй байж чадсангүй.

- Эндээ байж байг, Амелия. Би явна... гэв.

- Виктор оо! Хэрэв гарч явах юм бол гай болно шүү!

- Манайд гай зовлон багадаад байна уу? Гэж Амелия бөвтнөв. Тэгээд миний хоёр чемоданыг авч:

- Та хаашаа явах гэсэн хүн бэ? гэж хэлсэн нь намайг алгадаад авсантай адил санагдлаа.

Би төөргөө харахаар шийдэв. Сэтгэлийнхээ гүнд дотор минь онгойлоо. Би энэ айлд олзлогдсон хүн гэдгээ сайн мэдэж байлаа. Ийм сэрэл сэтгэгдэл надад хүч тэнхээ нэмэх шиг болов. Оршин буй амьдралын бэрхшээл зовлон надад үргэлж дарамт болдог. Энд бол надад аюулгүй санаа амар,

Ева дийлсэн царайгаар инээд алдан

- Би тангүйгээр амьдарч чадахгүй, Вик ээ... Ингээд миний заяа төөргийг шийдэх нь энэ.

Эгч нь үгүй болсны дараа би Евад эгчийг нь орлох ёстой болжээ. Одоогоос эхлээд би энэ тэргэнцэрт аргамжаатай байх болж дээ.

- Ева? Танд нэг юм хэлье...

- Үгүй... үгүй. Ямар нэг янзаар буулт хийхгүй.

- Ева та надтай ханилан суухыг хүсэж байгаа юм уу?

Бүсгүйн царай нэг улайж, нэг цайрав... Нүүр нь хүртэл үрчийж муруйлаа.

- Та намайг дооглож байна уу?

- Үгүй, Ева... Энэ бол бүх зүйлийг хэвийн байдлаар зохицуулах цорын ганц арга... Хоюул ханилан суувал би эндээс зугтаж зайлах гэх хэрэггүй болно... Бид гэрлэлтийн гэрээ байгуулж, таны бүх өв хөрөнгийг танд үлдээхээр гэрээнд заана. Намайг эд мөнгөнд шунаад тантай суулаа гэж хүн амьтан бодвол тэсэхүйеэ бэрх байх болно...

- Ай Вик ээ, өрөөл татанхай хүүхэнтэй хэн ханилан сууж байсан юм бэ?.. Энэ чинь үзэгдэж сонсдоогүй хэрэг!

- За тэгвэл одоо үзэгдэж сонсдоно доо! Бүсгүй шийдэж ядан дотоод сэтгэлд нь тэмцэл болж байгаа бололтой. Нэгэн талаар омог бардам зан нь хөтөлж, нөгөө талаар жаргалыг хүсэн хорхой нь хүрч байгаа бололтой. Эцсийн бүлэгт эмэгтэй хүний зан дийллээ

- Вик та нэгэн биеэ зольж яах юм бэ?

- Үүнд биеэ зольсон юм юу байгаа. юм бэ?

- Та... та надад хайртай юу? .

- Би чамайг хязгааргүй энхрийлэн санадаг...

- Энэ чинь дурлал биш!

- Ер нь аливаа сэтгэлд заавал хаяг шошго наахын хэрэг байна уу? Би таныг орхиж явмааргүй байна. Энэ нь сайны шинж биз дээ, тийм үү?

Бүсгүй хөмсөг зангидан хэсэг бодолхийлээд

- Би бол танд... таныг анх харсан мөчөөс эхлэн танд нүдээ өгсөн..

- Тэгвэл эргэлзэх хэрэггүй.

- Би эргэлзээгүй байна!

- Тэгвэл та яах гээд байгаа юм бэ?

- Би учрыг ойлгох гэж ядаж байна... Та бол нас залуу, цэвэрхэн төрсөн эр...

- Баярлалаа.

- Та үүнийг өөрөө сайн мэдэж байгаа. Та нээрээ эрхэн сайхан эр... гэж бүсгүйн хэлэх дууны өнгөнд уйтгарлангуй аяс мэдэгдэв.

- Ева та өөрөө ч их хөөрхөн бүсгүй...

- Сүрлэн хүүхэлдэй шиг...

- Таныг энэ тухай хэзээ ч бүү дурсаж бай гэж хэлсэн шүү дээ..

- Уучлаарай... гээд Ева тэргэнцэрийнхээ дугуйг тогшив.

- За тэгээд ханилан суух шив дээ? гэж инээмсэглэн өгүүлэхэд

- Хэзээ вэ? гэв.

- Нэг хэсэг байж байгаад. Гашуудлын хугацаа дуусахыг хүлээх хэрэгтэй.

- Гашуудал дуусч болно гэж бодож байна!

Бүсгүйн нүднээс аяндаа нулимс асгарав. Би аргадан нулимсыг нь арчиж өглөө. Би бүгдийг хэлэх аргагүй байлаа. Үхсэн хүнийг үзэн ядсанаас эгчийнхээ хойноос гашуудан уйлж байг даа.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Гэрлэх ёслолыг олны хэлдгээр туйлыи явцуу хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэв. Бид хоёр сүмд ч, хотын захиргаанд ч хоёулхнаа очиж, гэрч нарыг газар дээрээс оллоо.

Өнгөрсөн хоёр сард Еватай суух шийдвэрээ өөрчлөе гэсэн бодол миний толгойд орж байгаагүй гэвэл худлаа боло. "Виктор чи цэвэрхэн төосөн залуу хүн... Чи өрөөл татанхай хүүхэнтэй насаараа наалдаж яах гэсэн юм бэ. Энэ чинь солиотой хэрэг. Чи ингэж өөрийгөө хөөдөх эрхбайхгүй. Эхнэр авна гэдэг чинь өрөөлийг өрөвдөж буян санахын нэр биш. Гэрлэлт бол ариун дурлалд үндэслэсэн, дурлалын үргэлжлэл нь байх ёстой. Үр удам үлдээхгүй ийм холбоог чи яаж тэвчих юм гэж би өөр өөртөө хэчнээн хэлэв дээ.

Хэдэн удаа би юм хумаа цуглуулан чемоданд хийж унтлагынхаа өрөөний үүдийг онгойлгосон... Гэвч эцсийн мөчид намайг нэг юм саатуулан зогсоож байлаа.Энэ нь тухай бүрд өөр өөр юм байдаг байв... Ухаан нь байшингийн хаа нэгтээ нэг юм чийхран дуугарах,өөр нэг юм санаанд орох гэх мэт...

Эцсийн бүлэгт би өөрөө өөртэйгөө тэмцэх хэрэггүй юм байна гэдгийг ойлгов...

Харьж явах зам зуур машинаа жолоодон хажууд суугаа "хайрт эхнэрээ" нүдний булангаар харж явлаа. Ева гэнцвэр алдахгүй овоо цэх сууж байв. Царайд нь баясгалант инээмсэглэл тодрон улам гоо үзэсгэлэнтэй харагдана.

Энэ бүсгүйг хөдөлж чадахгүй болгосон хувь заяанд би гомдон харамсаж байлаа. Ева хэрэв тахир дутуу биш сэн бол Номин Хөх Эрэгт хамгийн хөөрхөн бүсгүй байх байсан сан.Би Еваг тэнгисийн хаялгана дээгүүр усны хувцастай гүйж яваагаар төсөөлөв. Одоо бид хоёр ханилан суугаад санаа минь амарлаа. Ийм чухал шийд гаргасны дараа хүлээх ч хамгийн хэцүү байдаг аж. Бодож шийдсэн зүйл биелэсний дараа урьд нь нарийн адармаатай юм шиг санагддаг байсан бүх зүйл энгийн хялбар болоод ирэх юм.

Чухам юу болсон билээ гэвэл би царайлаг хөөрхөн ч өрөөл татанхай бүсгүйтэй ханилан суулаа. Ингээд л гүйцээ. Өөр юмгүй. Би энэ бүсгүйг зайлшгүй үхлээс аврав. Үүний дараа бид хоёр хувь заяагаа холбохгүй байж болох уу даа. Амийг нь аварсан хүнтэйгээ голдуу иймэрхүү маягийн харилцаатай болдог, Хүний амийг аварна гэдэг бол тийм ч жирийн юм биш. Хашааны хаалга онгорхой байсан учир би гол эамаар байшингийн довжоонд тулж ирээд машинаас бууж тойрон очиохд Ева өөрөө хаалга онгойлгож өгөхөд нь би тонгойн гар дээрээ өргөж авлаа. Ева биед минь наалдав. Намайг шатаар өгсөж явахад үнсэн таалж байлаа. Уруул нь уян зөөлхөн, арьс үснээс нь маш сайхан сүрчиг анхилан байв. Евагийн үнсэлт надад өөр нэгийг бодуулав.

Удахгүй шөнө болно гэж бодохоос аймаар жигшмээр байлаа.

Ингээд сэтгэл түгшээсэн хэцүүхэн шөнө болов. Амелия авгай унтаад өгчээ. Ева бид хоёр үүдний танхимд юулхнаа үлдлээ. Ева өөдөөс минь харан инээмсэглэв, Сэтгэл нь их догдолжээ. Гэсэн ч надаас арай бага догдолсон шиг байна. Би аливаа эр хүнийг над шиг ийм байдалд ороосой гэж хүсэхгүй юм байна

- За ингээд энэ эрхэм эмгэний үлгэр жишээг дагалдах уу даа? Бид хоёр ч гэсэн амрах эрхтэй, тийм үү, хонгор минь? гэж би хэлэв.

Ева хариу хэлсэнгүй. Тэргэнцэрээ хөдөлгөн өргүүр рүү очлоо. Би шатаар өгсөн өрөөний нь үүдэнд очиж зогсов. Өрөөг нь би аль хэдийн янзалсан юм. Надад эндээс зугатах хүсэл урьд өмнө ингэж их төрж байгаагүйсэн. "Жаахан байж байтал юм бүхэн эцэс болно" гэж би өөрөө өөртөө хэллээ.

Ева хүрч ирээд үүдээ онгойлгон гэрлээ асааж

- Виктор гэж дуудав.

Одоо би л чухам саад дайруулсан юм шиг болж хөл минь хөдөлж өгөхгүй байна.

- Виктор! гэж Ева дахин дуудав.

Би дотогш оров. Ева унтахаар хэвтэхийн өмнө орныхоо дэргэд очдог ёсоороо очив. Хацар нь улааран байна.

- Та миний унтлагын өрөөнд орохыг айгаад байгаа юм уу даа? гэж бүсгүй жуумалзав,

- Хаанаас даа, Ева!

- Та намайг чи гэж дуудаж болно шүү Би чинь одоо таны эхнэр.

- Ева!

- Та надаас айгаад байнаа даа, тийм үү?.. Хууль ёсоор эр, эм болсон эрхээ эдлэхийг хүсэхгүй байгаа юм уу?

-Ева! Хоёр хүн хотын захиргаанд очиж, гэрлэлтээ албан ёсоор бүртгүүж ирсэн юм гээд тэр даруй өвөртөө орох ёстой гэж бодох нь тэнэг хэрэг шиг санагдахгүй байна уу?

- Уг нь дандаа л тэгдэг дээ,. Виктор оо... За учир нь үүнд байгаа юм биш... Та одоо надаас сэжиглэж байгаагаа үнэээр нь зүрхлээд хэлчих... Сэжиглэж байгаа нь таны нүдийг харахад ил байна... Та өрөөл татанхай надтай хонох дургүй байна, тийм үү?

Би энэ бүх байдалд сэтгэл давчдаад хаалганы хажууд зогсож байлаа. Евагийн хэлдэг үнэн. Үүний сацуу энэ чинь одоо миний эхнэр. Би энэ хүүхэнтэй гэрлэснээр гэмт хэрэг үйлдсэн юм биш байгаа. даа? Энэ хүүхнийг хоосн мөрөөдөлтэй нь орхисон бол дээр байж ...

Ева цээживчээ тайлан шалан дээр унагав. Дараа нь дотуур цамц, хөхнийхөө даруулгыг тайлан хажуу тийш нь шидэв. Хөдөлгөөн нь огцом ширүүн, шийдэмгий байлаа.

Бүсгүйн жижигхэн мээмийг харлаа. Уян болоод чийрэг юм. Хүрэн товч нь чинэрнэ. Би буруу харж

- Үгүй, Ева... Битгий ингэ... Би... би таныг гуйя гэв.

Ингэж хэлээд би өрөөнөөс гүйн гарч, шатаар гүйх үед Ева хойноос минь хийтэй юм шиг муухай хашгирах сонсдов... тэгснээ төдөлгүй цурхируулан уйлж эхэллээ.

Мэдээжээр би удтал унтаж чадсангүй. Маргааш нь ердийнхөөс орой бослоо. Намайг үүдний танхимд орж ирэхэд Ева тэнд хүлээж байв.

- Сайхан нойрсов уу, хонгор минь? гэхэд нь дал мөрөө хавчаад

-Ева! Хоёул нэг сайн ярих хэрэгтэй байна гэсэнд

- Болно л доо... гэв.

Амелия авгай миний цайг авчирч өгөхөд яриагаа түр таслах хэрэгтэй боллоо. Бид хоёрын өөр өөр өрөөнд унтсаныг эмгэн мэднэ. Үүнд, баярлаж байгаа бололтой.

-Ноён Менда та тавтай сайхан нойрсов уу? гэж эмгэний асуухад

- Их сайхан унтлаа... Таны хурхирахыг бараг сонссонгүй гэсэнд цочин балмагдсан эмгэн хажуу тийш зайлав.

- Менда... Би чинь одоо хатагтай Менда болсон... Сайхан нэр... Таны өвөг дээдэс итали хүмүүс байсан юм уу? гэж Ева асуув.

-Бүү мэд. Би үүнийг нэг их сонирхдоггүй... Намайг ойлгоорой, хоёул сайн ярья...

Би яах гэж ийм дэмий яриа үүсгэв дээ? Одоо болохоор надад хэлэх юм үгүй шиг санагдана.

- Та байдалд дасаж идээших хэрэгтэй болж байгаа юм уу даа?

Ева одоо юм бүхнийг өөрийн санаснаар болгож сурсан эрх танхи жаал охин шиг байлаа.

- Тийм ч байж болох юм!

- Яарах юу байх вэ дээ, хонгор минь! Бидний өмнө хамаг амьдрал маань хүлээж байна тийм үү?

-Хамаг амьдрал гэнэ! Би нүдээ анив... Ева үргэлжлүүлэн

- Дараа нь та надад нэрээ хайрласан. Энэ чиив маш сайхан бэлэг. Энэ нэр надад их сайхан санагддаг юм, Вик ээ!

- Боль доо, Ева... Би танд хайртай. Нэгэн цагт та минийх болно гэж андгайлья. Тайван хүлээж байгаарай гуйя.

Би дэргэд нь очиж үнсэв. Уруулаа жимийсэн байх агаад одоо миний өөдөөс нулимах нь уу

гэмээр санагдаж байлаа...

Элений нас барсны дараа өв залгамжлах асуудал шийдвэрлэгдэхийг хүлээгээд "Мөрөөдлийн хайрцаг" дэлгүүрийн ажил саатаж байснаа Ева бид хоёрыг гэрлэсний дараа ажил дахин эхэлж, одоо зургуудыг өлгөх, бараа авах л үлдлээ.

Надад ажил зөндөө. Энэ нь гэр бүлийн нарийн адармаатай харилцаанаас намайг холдуулна. Би худалдаа арилжааны ажилд хамаг анхаарлаа хандуулаад сэтгэлээ тайвшруулахыг хичээж байлаа.

Зургийн үзэсгэлэн худалдаа маань баярлаж баршгүй сайхан болсон. Энэ бол Ева бид хоёрын хамтын бүтээл. Хэн хэний маань хүчин зүтгэлээр маш сайхан ч бүтээл боллоо.

Би одоохондоо хүнгүй байгаа үзэсгэлэнгийн танхимаар явж байхдаа дөнгөж өлгөсөн сайхан сайхан зургуудыг бахдан үзэж байв. Шинэ байрны өвөрмөц үнэр урмыг минь сэргээн энэ танхимын гайхамшигт сайхан ирээдүйд итгэх итгэл төрүүлнэ...

Би энэ үзэсгэлэн худалдаанд хамаг хүч чадал, оюун ухаанаа зориулмаар байлаа. Би биеэ хайрлахгүй ажил лаж байлаа. Энэ бол хүн амьтантай уулзахаас зайлсхийх ганц бололцоо.

Орой нь залуу эхнэр дээрээ баяр баясгалантай эргэн ирнэ. Еваг урьд өмнө ийм эрчим чадалтай, ийм ухаан сэргэлэн, яруу хурц байхыг би ер үзээгүй.

Элений тухай гунигт дурьдатгал намайг орхиогүй ч түүний амь үрэгдсэний дараахь эхний өдрүүдийнх шиг тийм их зовоохоо больжээ.

Элен бол миний муу зүгийн тэнгэр байлаа. Хэнд ч гэсэн муу зүгийн тэнгэр байдгаас хойш одоо яая гэх вэ дээ...

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Ингээд одоо сүүлчийн шөнийн тухай ярих үлдлээ.Тэр орой би дэлгүүрээс нилээд их ядраад ирлээ. "Мөрөөдлийн хайрцаг" дэлгүүрт би арай дэндүү их цаг өнгөрөөж байх шиг. Ажилдаа улайгаад үдийн хоол идэж амжихгүй байх нь олон.

Цаг нилээд эрт байсан боловч би Евад тавтай сайхан нойрсохыг хүсээд гарав. Орондоо орж, тухтайхан хэвтэж аваад удалгүй унтаад өгчээ. Хэсэг хугацааны дараа ходоод хонхолзон сэрэв. Унтахын өмнө нэг жаахан юм идэхгүй бол шөнө хэвийн байдлаар унтаж чаддаггүйгээ би хэдийн ажигласан юм. Яаж ядарсан ч ходоод хоосон бол унтаж чаддаггүй. Би босож, аль болох чимээ гаргахгүйг хичээн гал тогооны өрөөнд орж хөргүүрийг онгойлгож үзлээ.

Би урьд өмнө ч олон удаа ингэдэг байсан. Ингэж шөнө босож юм идэх сайхан санагддаг. Хөргүүрээс хайрсан мах, хоёр зүсэм шарсан талх авч, том хундаганд улаан дарс хийж аваад энэ бүхнээ дотоод хашаанд аваачиж, жижиг ширээний ард суув.

Зөөлөн сайхан шөнө байлаа. Халууны эрч бууран сэрүү орж, амьсгаа авахад амар болжээ. Би авчирсан хоолоо амтархан идэж зуны сүүл сарын шөнийн энэ сэрүүн агаарыг цээж дүүрэн амьсгалав. Идэж ууж дуусаад тэндээ унтаад өгөх шахжээ. Урт сандалд хэдий хэр удаан зүүрмэглэснийг бүү мэд. Үүдний танхимын цаг цохилон дуугарсан боловч хэд цохисныг нь тоолсонгүй.

Гэнэт хаа нэгтээ юм ширжигнах чимээ гарахад нь би давхийн цочив. Эхлээд энэ байшинд шөнийн цагт дүүрэн байдаг ердийн нэг чимээ юм уу гэж бодлоо. Удалгүй шаржигнах чимээ дахин сонсдоход нь би чихээ сортойлгон чагнав!

Дахиад шаржигнав. Шатны тэндээс чимээ гарч байна. Шатны модон гишгүүр шаржигнаж байгаа бололтой. Би босож, улавч шаахайгаа тайлан үүдний танхимд хөл нүцгэн гэтэн очив. Би эндүүрсэнгүй. Шатны гишгүүр шажигнасан байжээ. Би баруун гартаа лааны зэс суурь авч, зүүн гараараа унтраалга тэмтэрлээ. Гэрэл гялсхийн асахад би гялбан цочиж, лааны суурийг алдаж орхив.

Шатан дээр Ева... зогсож байна. Маш сайхан зогсож байна шүү. Урд талаараа товчтой цагаан платье өмсөж, толгойгоо алчуураар боосон байлаа. Надад тэр шөнө төмөр замын далан дээр Элений үхээд хэвтэж байхыг харснаас ч илүү аймшигтай байв... Би бүр нүдээ анилаа,

Нүдээ нээхэд Ева шатан дээр алга байв. Ева өрөөнийхөө үүдийг тас хийтэл хааж байгаа сонсогдлоо. Би шатаар дээш гүйн гарав. Ева үүдээ дотроос нь түгжжээ. Ямар ч түгжээ, ямар ч хаалга байсан ч намайг саатуулж чадахгүй. Би үүдийг нь мөрөөрөө мөргөн онгойлгов.

Ева тэргэнцэртээ нуугджээ. Энэ тэргэнцэр нь түүний халдашгүй бат цайз болох юм шиг... Уушги зүрх минь амаар гарах гээд би цээжин дээрээ хоёр гараа тавив.

- Тэгэхлээр тэр шөнийн хүүхэн чи байсан юм байна, муу банзал!

Би байж ядталаа уурласан байлаа,

- Чи байсан юм байна! гэж би дахин давтан хашгирч байлаа.Би нэг л юмыг дахин давтан хэлж байсан бол цээжинд минь олон зүйлийн бодол хуйлран эргэлдэж байв. Энэ муухай шулам л олон жилийн турш бүгдийг мэхлэн төөрөлдүүлж байж шүү дээ... Төрсөн эгчийгээ ухаан солиороход хүргэсэн байна... Намайг бас малласан... Би сэтгэл мэдрэлийи муухай гажигтай нэг садар эмтэй гэрлэсэн байж!

Би түүний өөдөөс гайхан хараад тэр шөнө тэнгисийн хөвөөнд машин дотор сууж байсныг нь нэхэн саналаа. Би үүний мээм, уруул ам, завхай үнэрийг яагаад танисангүй вэ?!

Энэ хүүхэн миний эхнэр болоод олон хонож байгаа ч энэ завсар би нэг ч ойртоогүй байгааг хүнд хэлэх юм бол... Тэр шөнө машины суудал дээр энэ л хүүхнийг хагссан цэрэг эр шиг нухаж байсан эр...

Миний үзэн ядсан зэвүүн харц дор хүүхэн биеэ хурааж, бүр жижигхэн болсон юм шиг санагдлаа.

- Чи байсан юм байна! гэж би дахиад л гацсан юм шиг өгүүлэв.

Ингэж хэлээд түүн рүү алхлаа. Ева хананд шахуулахгүй гэж сурамгай хөдөлгөөнөөр тэргэнцэрээ хөдөлгөн зайлав. Одоо хаалганы наахан талд цаашаа хараад сууж байв. Одоо нэг л хөдөлбөл гудамд гараад явчихна. Би галзууртлаа уурлан амьсгаа бөглөрч, шүд зуун нударга зангидав.

- Муу садар эм чи хэдийнээс эхлэн ийм жүжиг тоглох болсон юм бэ?

Ингэж хэлээд би тэргэнцэрийг өшиглөсөнд хаалганы тэндээс гудмаар хоёр метр хэртэй өнхрөв. Ева тэргэнцэрээ даруй зогсоолоо.

- Хэл! гэсэнд Ева гэнэт биеэ сул тавьж

- Бүр анхнаасаа гэж хариулав.

- Худлаа!

- Үнэн!

- Учрыг хэл!

- Би арван гуравтайдаа өвдсөн юм... Эхлээд бах өвчин үгдэрч, үе мөчний хэрх өвчин болсон... Эмч полимиелит хүрэх вий хэмээн айж байна гэж аавд хэлж байсан юм... Нугасны үрэвслийн шннж тэмдэг үзэгдэж байсан юм байж... Би тэдний яриаг сэм чагнасан ..

- Тэгээд чи өвчтэй хүн болж баашилж эхэлсэн

- Чи өөрөө харж байна...

- Долоон жил шүү! Чи яаж чаддаг байна?!

- Чадья гэж их хүссэн болоод тэр.

Ийм учирлалыг сонсоод солиормоор!

- Яагаад вэ гэвэл би юу хүснэ вэ, санасандаа хүрч чаддаг, Вик ээ... Үүнийг чи мэднэ шүү дээ.

- Мэднэ... Чи яах гэж ингэсэн юм бэ?!

- Эцэг маань Эленд илүү хайртай байсан. Ээжийн хаяж явсныг уучилж чаддаггүй байсан. Ойлгож байна уу

- Чи тэгээд ямар ч байсан эцгийнхээ анхаарлыг татах гэсэн хэрэг үү?

- Тийм! Тэгээд санасандаа хүрч чадсан гэж чамд хэлж болох байна!

-Маш сайхан чаджээ, хонгор минь!.. Маш сайхан! Чи чинь цагийг эзэлсэн гайхамшигт жүжигчин юм байна.

- Битгий хэтрүүл, Вик ээ...

Тэгэхлээр тэр шөнө чи "дурлалын эрэлд" гарсан юм шив дээ? гэсэнд Ева нүднийхээ харцаар намайг шөвөгдөн

- Тэгээд юу гэж? Тэгэхэд чи бид хоёрт сайхан байсан биш үү, Вик ээ? Санаад үз... Тийм болоод би чамайг энд үлдээх гэж хүссэн... Чи амраглахад бахтай сайхан эр!.. Би чамайг харсан дороо дурлачихсан юм...

- Өлөгчин шиг үү. Галзуу өлөгчин шиг!

- Тийм л дээ, Вик ээ... Надад дурлал хэрэгтэй...

Миний насны залуу бүсгүйд энэ чинь гайхмаар юм гэж үү?

- Аль дайралдсантайгаа амраглах хэрэгтэй байдаг юм уу? гэсэнд хүүхэн бүр хуруу гараа сэгсчин зангаж

-Өө үгүй! Би хэрэгтэй хүнээ шилж чаддаг гэв.

Би бүр гайхан мэлэрч орхилоо.

- Чи бас намайг даажигнах зүрхтэй байна уу?!

- Чамайг даажигнаагүй. Учрыг хэлж байна... Би цаг үргэлж хөдлөхгүй байгаад байх аргагүй байсан! Ye ye биеийнхээ чилээг гаргаж байх хэрэгтэй байлаа!

- Чи надад хайртай дуртай гэж байна. Тэгвэл ингэж шөнө гадуур тэнэхийн хэрэг юу байна вэ?

- Шөнийн явдал намайг сайхан хөлчүүрүүлдэг юм

- Ээ Ева! Чи нээрээ сэтгэл мэдрэлийн өвчтэй юм байна.

- Чи юу хэлэх гээд байна вэ? Би хэсэг бодлогоширов.

- Хэлээч! гэж Ева хашгирлаа.

- Чамд тахир дутуу хүн болж баашлахаа болихсон гэдэг бодол ер төрдөггүй байсан уу? Өвчин чинь эдгэсэн юм шиг байдал үзүүлэх...

Хүүхний тас тас инээхэд би галзуурах шахав.

- Хааяа тийм бодол төрдөг байсан. Чамайг нүд ширтэж байхдаа... Гэхдээ энэ тэргэнцэрт сууж байх хэчнээн сайхан байдгийг чи мэдэхгүй байна!.. Амьдрал надад хүртээлгүй байдаг!.. Миий хөл дор байгаа энэ хивсэн дээгүүр өнхөрч байгаа юм шиг амьдралын дээгүүр өнхрөөд!.. Заримдаа шөнө их дур хүрээд байвал босож явдаг... Энэ их ядаргаатай... Энэ хоёр мөч дээрээ хөдлөх гэж биеэ зовоож байхын хэрэг юу вэ?!

Үгүй энэ хүүхний хэлж байгаа үгийг сонсоод үнэхээр солиорч болох юм!

- Чи хэдийд машин жолоодож сурсан юм бэ?

- Арван настайдаа. Эгч маань инээд зугаа болгох гэж зааж өгсөн юм.

- Чи тэгээд хэнд ч хэзээ ч баригдаж байгаагүй юу

- Би азтай хүн шүү, Виктор оо... Чи л хамгийн анх... Харин үүнийг хүнд битгий хэлээрэй! За ер нь хэлсэн ч хүн чиний үгийг үнэмшихгүй... гээд жуумалзан инээвхийлж

- Манай эгч гэж нэг тэнэг юм намайг баашилж байгаа хүн болгож үзүүлэх санаатай хичнээн зовж байгааг нь хараад...

Өөртөө туйлын их ач тус болсон талийгаач эгчийнхээ тухай ингэж хэлдэг байна шүү!..

- Эгчийнхээ тухай ингэж ярихыг чинь хориглоно! Чи муу бузар хорт могой! гэж намайг галзуу юм шиг хашгирахад Ева гэнэт царайгаа төв болгож

- Би хорт могой байж болох юм. Тэгвэл чи могойн хор! Чамайг үзэн ядна! гэв.

- Би юу?!

- Эмийн дур булаах цэвэрхэн хоншоортой, гэтүүр харцтай чи л Элен эгчийг алсан!

- Дахиад хэл! гэсэнд Ева хоёр алгаа амныхаа дэргэд хумбайлган барьж байгаад

- Чи л Элен эгчийг алсан! гэж хар тэнхээгээрээ хашгирав.

Тэгэхэд нь би түүний тэргэнцэрийг дахин өшиглөлөө. Ева хоёр гараа амны дэргэд барьж

байсан учир шатаар уруудан өнхөрч буй тэргэнцэрийг тэр даруйд зогсоож завдсангүй. Би тэргэнцэрийг нь зогсоох гэж ухасхийсэн боловч хожимджээ. Тэргэнцэр нь Еватай хамт спортын хурдан чарга аятай, шатаар уруудан өнхөрлөө. Тэргэнцэр шатны хашлага хоёрыг ээлжлэн мөргөж, оволзон донслоход Евагийн чихэнд чийртэй муухай хашгирах дуу хурдыг нь улам ихэсгэх шиг санагдав, Шатны эргэлт дээр баруун дугуй нь хашлага мөргөн тэргэнцэр нь онхолдож, гурван метрийн өндрөөс үүдний танхимын чулуун хавтан шал дээр ойчив. Би хоёрдугаар давхраас хэдэн секунд хий гөлрөн харж байснаа шатаар уруудан ухасхийлээ.

Ева эвдэрхий тэргэнцэр дороо хэвтэж байв. Цагаан платье нь урагдаж, цээж, гуя нь ил гарчээ.

- Ева! Чи шархатсан уу?

Нүдний нь харц надад найдлага төрүүллээ. Тэнгэрийн авралаар энэ хүүхэн амьд байна. Би тэргэнцэрийн их биеийг өргөн хажуу тийш зайлуулж, Евад гараа сарвайв. Ева гараас минь шүүрч аваад өндийхийг оролдсоноо дуу алдан хашгирч гэдрэг унав.

- Миний нуруу хугарсан байна, Вик ээ!

-Битгий дэмий яриад бай! Тэнгэрийг бодож босооч| Алийв, босооч дээ! Босооч! гэсэнд Ева толгой сэгсрэн

- Чадахгүй байна, Вик ээ, бүр тангараг! МИНИЙ ХОЁР ХӨЛ ЭЗЭНГҮЙ БОЛЧИХЖЭЭ! гэв.

ТӨГСӨВ.